



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ТАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-14
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-86
<hr/>	
1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	18-34
2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	34-54
3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	54-61
4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	61-66
5. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	66-73
6. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, хаалттай/	73
“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ /үргэлжлэл/	74
7. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	74-78
8. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	78-80
9. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	80-82
10. “Жижиг, дунд үйлдвэрийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	82-83

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 10-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 45 гишүүн хүрэлцэн ирж, 59.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Х.Болорчулуун, Ж.Мөнхбат, Б.Саранчимэг, Н.Учрал;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Ж.Эрдэнэбат;

Тасалсан: С.Ганбаатар;

Хоцорсон: С.Амарсайхан – 1 цаг 39 минут, С.Батболд – 2 цаг 28 минут, Ж.Бат-Эрдэнэ – 40 минут, Д.Ганбат – 36 минут, Ц.Сэргэлэн – 45 минут, Д.Цогтбаатар – 45 минут, О.Цогтгэрэл – 1 цаг 19 минут, Б.Энхбаяр – 1 цаг 25 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Чинзориг нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Чинзориг нар үг хэлэв.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Оюунчимэг, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тусгагдсан Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 2023 онд “18,921.9 тэрбум төгрөг”, 2024 онд “20,797.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,859.9 тэрбум төгрөг” гэснийг 2023 онд “19,049.6 тэрбум төгрөг”, 2024 онд “19,822.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,314.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “34.7”, 2024 онд “36.3”, 2025 онд “34.5” гэснийг 2023 онд “34.9”, 2024 онд “34.6”, 2025 онд “33.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 17
Бүгд: 59
71.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2024 онд “22,401.7 тэрбум төгрөг”, 2025 онд “23,128.8 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “21,426.8 тэрбум төгрөг” 2025 онд “22,583.6 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “39.1”, 2025 онд “36.5” гэснийг, 2024 онд “37.4”, 2025 онд “35.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд дэмжээгүй үг хэлэв.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 22
Бүгд: 59
62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ 2024 онд “1,926.4 тэрбум төгрөг”, 2025 онд “727.1 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “951.5 тэрбум төгрөг”, 2025 онд “1,156.9 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “3.4”, 2025 онд “1.1” гэснийг 2024 онд “1.7”, 2025 онд “1.8” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 21
Бүгд: 59

64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд “-1,553.4 тэрбум төгрөг” гэснийг “-1,425.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “-2.8” гэснийг “-2.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 28

Бүгд: 59

53.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2023 онд “5,347.3 тэрбум төгрөг” гэснийг “5,359.7 тэрбум төгрөг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 20

Бүгд: 58

65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ 2023 онд “1,999.0 тэрбум төгрөг” гэснийг “1,961.2 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “3.7” гэснийг “3.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 23

Бүгд: 59

62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга

Б.Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн захирал Ц.Амарсанаа, мөн яамны Барилга, барилгын материалын хэрэгжилт зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Элбэгзаяа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга Ч.Ариунхур нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, Ц.Баянмөнх, С.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Н.Наранбаатар, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 4 дүгээр зүйлээс “47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг,” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 47.9 дэх хэсэг нэмэх:

“2/47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг:

“47.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана. Хайгуулын ажлын технологийн явцад туршилтын журмаар олборлох ашигт малтмалын дээд хязгаарыг төрлөөс нь хамааруулж Засгийн газар журмаар зохицуулна.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 25

Бүгд: 56

55.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.7 дахь хэсэг нэмэх:

“1/16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг:

16.7.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	22
Бүгд:	55

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	34
Татгалзсан:	21
Бүгд:	55

61.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дэх заалтын ““Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “6.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	24
Бүгд:	55

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.“Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 2 дахь заалтын 9 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт малтмал олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 22
Бүгд: 52
57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 10 дахь дэд заалт нэмэх:

“10/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлого боловсруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 22
Бүгд: 52
57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дахь заалтын 12 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлт үзүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 25
Бүгд: 52
51.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ц.Баянмөнх, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооноос Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 18

Бүгд: 48

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, Ц.Баянмөнх, С.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Банкны бүтэц, өөрчлөлтийн бодлогын газрын захирал Н.Ариунбат, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 08 минут үргэлжилж, 13 цаг 13 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Зургаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, хаалттай/

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 14 цаг 03 минутаас хаалттай горимоор дээрх тогтоолын төслийг хэлэлцэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 14 цаг 47 минутад нээлттэй горимд шилжин хуралдаан үргэлжлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Банкны бүтэц, өөрчлөлтийн бодлогын газрын захирал Н.Ариунбат, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Г.Занданшатар: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	20
Бүгд:	45

55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг “51.3.Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 23

Бүгд: 49

53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “2023” гэснийг “2024” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 21

Бүгд: 50

58.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 22

Бүгд: 47

53.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах асуудлаар санал хураалгах гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 22
Бүгд: 47
53.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаалаа.

Уг асуудлыг 15 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Арав. “Жижиг, дунд үйлдвэрийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:15/

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 8 болон 32 дугаар хорооны албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг, Г.Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Зэвсэгч хүчний 032 дугаар ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн

Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн болон “Багануур холбооны газар”-ын ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Л.Оюун-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн “Өлзий мэргэн үндэсний сурын холбоо” төрийн бус байгууллагын тэргүүлэгч, гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 6, 19 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Батжаргал, Н.Энхболд нарын урилгаар Төв аймгийн Заамар сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн ажилтнуудын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 23 минут үргэлжилж, 76 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Арван асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 6 саналтай.

Нийт ирц 59.2 хувьтай бүрдсэн байгаа шүү. 45 гишүүний.

Хоёрт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Гишүүд чимээгээ намжаарай. Суудалдаа суугаарай. Яриа сонсогдохгүй байгаад байна шүү.

Тавдугаарт, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай.

Зургаадугаарт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Долоодугаарт, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Наймдугаарт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Есдүгээрт, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Арав. “Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүд хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол 17.00 цагаас өмнө үндэслэл

бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Содномын Чинзориг нараас ирүүлсэн бичгийг уншиж танилцуулья.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуудал нэмэх горимын саналаар үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Асуудал нэмэх горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

Тэгэхээр уржигдар хоёр дахь өдөр тэтгэврийг тогтоохдоо 7 жилийн цалингийн дунджаар биш 5 жилийн цалингийн дунджаар тогтоох зорилгын төлөө 7 биш 5-аар тэтгэврийг тогтоо гэдэг жагсаал боллоо. Их Хурлын гишүүд очиж оролцлоо.

Мөн түүнчлэн энэ хуулийг хамт өргөн барьсан Монгол Ардын намын 2 гишүүн эв санааны нэгдэл хамтдаа байгаа гэдгээ илэрхийлсэн.

Мөн түүнчлэн энэ жагсаалын дараа бас нэлээн олон гишүүд асууж, хамтдаа байгаа шүү гэдгээ бас илэрхийлсэн байгаа.

Зарим нэгэн нөхдүүд жоохон тоомжиргүй маятай. Чи битгий ахмадуудыг ашиглаад байгаарай гэсэн маягтай юм ярьж байна лээ. Би тэд нар дээр энэ ахмадуудын акцыг илүү сайн явуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье.

Тэгээд ирэх долоо хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд С.Чинзориг гишүүнээр ахлуулсан

ажлын хэсгийг хуралдуулж өгөхийг Их Хурлын даргаас энэ цуглааны гол шаардлага гарсан байгаа.

Тийм учраас энэ асуудлыг заавал оруулж өгөөрэй гэж танаас 1500 гаруй ахмадуудын өмнөөс. Маш сайхан жагсаал болж, Монголын ахмадууд үнэхээр төрдөө ямар их хүндэтгэлтэй ханддаг юм. Тэнд ямар ч тийм хашхирч гуугчсан, шаагьсан, ордон гороолсон ийм зүйл болоогүй.

Монголын ахмадууд бол Монголын төрдөө итгэж явдаг, хамгийн сайн сайхан зүйлийг бидний төлөө хийнэ гэж найддаг ийм хүмүүсийн цуглаан болсон гэдгийг чухалчлан хэлье. Хэрвээ ирэх долоо хоногийн хэлцэх асуудлын дараалалд энэ асуудлыг оруулахгүй бол Архангай аймгаас эхлүүлээд жагсаалыг төв дээр нь зохион байгуулна.

Харамсалтай нь Архангайн гурван гишүүн гурвуулаа дэмжинэ гэсэн учраас Архангайг алгаслаад дараагийн Баянхонгор луу явахаас өөр аргагүй. Ийм нөхцөл байдлаар дараа дараагийнхаа арга хэмжээг авч энэ хуулийг батлуулахын төлөө эцсээ хүртэл явна гэдгийг хэлье.

Ер нь уржигдарын жагсаал Монголын түүхэнд хамгийн анх удаагаа хууль батлуулахын төлөө, дээрээс нь энэ жагсаал цуглааны хувьд хамгийн тийм соёлтой, хамгийн сайн сайхныг хүссэн, дээрээс нь өөрсдийнхөө проблемыг л ярьсан ийм ахмадууд цугласан гэдгийг хэлье.

Энэ тэтгэвэрт гарах гэж байгаа ахмадуудын зэрэгцээгээр маш их олон тэтгэвэрт гарсан настай хүмүүс маш их ирсэн байгаа. Тэр хүмүүс юу хүссэн бэ гэхээр энэ тэтгэврийн хэмжээ хэдийгээр

өнгөрсөн хоёр сард тэтгэврийн доод хэмжээг 15 хувиар нэмсэн боловч харамсалтай нь энэ тэтгэвэр чинь амьдралд ерөөсөө хүрэхгүй байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа.

Тийм учраас энэ ирэх жилийн төсөв баталж байгаа, нийгмийн даатгалын төсөв баталж байгаа энэ үед иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх асуудлаар бас нэлээн онцгой шийдвэр гаргана гэдэгт энэ Их Хуралд итгэж байгаа.

Тийм учраас Их Хурлын даргыг ирэх долоо хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийг хуралдуулах, энэ тов дараалалд оруулж өгөх тэр асуудлыг шийдвэрлэж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ долоо хоногийн чуулганаар Засгийн газрын мэдээлэл сонсох бол мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл, мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсох шаардлагатай байна. Дарга аа. Хөдөө аж ахуйн сайдын мэдээллийг сонсоно гээд хоёр ч удаа хойшилчихоод байгаа.

Тийм учраас энэ мэдээллийг сонсох, Хөдөө аж ахуйн сайдын мэдээллийг сонсохдоо энэ мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл, мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар бас Их Хурал дээр мэдээлэл сонсох зайшгүй шаардлагатай байна.

Би Өвөрхангай аймагт энэ жил зун алаг цоог болсон. Говийн 6 сум

зуншлага болоогүй. Зүүн талын 4 сум зуншлага бас тааруухан болсон. Говийн 6 суманд зуншлага муухан болсон учраас зүүн талынхаа сумдад отор орж ирээд зүүн талын 4 сум нь ч гэсэн бас адилхан цаг маш хүндэрчихсэн.

Өнөөдрийн байдлаар Өвөрхангай аймгаас 700 гаруй малчин өрх гаднын аймгуудад алсын отор хийнэ гээд нутаг орноосоо малаа тууж нүүж гараад сар гаруйн хугацаа өнгөрч байна. Энэ отроор явж байгаа малчдыг хөөж туухгүй байх, ая тухтай өвөлжүүлж, хаваржуулаад нутаг буцаахтай холбоотой асуудлаар энэ Хөдөө аж ахуйн яам, Онцгой байдал, Шадар сайд илүү онцгой ч ажилламаар байгаа юм.

Би энэ асуудлаар Хөдөө аж ахуйн сайд, Шадар сайдад нэлээн хандаж байгаа. Засгийн газар дээр яриад энэ отрын малчдыг хөөж туухгүй байх, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гаргаад өгөөч ээ гэж хэлэхээр өөдөөс нь өмнө нь Онцгой комисс шийдвэр гаргачихсан. Тэр шийдвэрээр явна гээд ингээд яриад байдаг. Энэ гаргасан шийдвэр нь амьдралд хэрэгжихгүй байна шүү дээ.

Онцгой байдлын комиссоос орон нутгийн удирдлагууд хоорондоо гэрээгээ хий. Оторчдод отрын бүс нутаг гаргаж өг гэсэн ийм шийдвэр гарсан юм билээ. Энэ нь одоо болтол ерөөсөө хэрэгждэггүй. Би Өвөрхангай аймгийн даргатайгаа ярьсан. Булган, Сүхбаатар, Төв аймгууд одоогоор ерөөсөө аймгийн Засаг дарга нар нь хүлээж авдаггүй. Гэрээгээ байгуулаагүй байгаа юм билээ.

Саяхан энэ Төв аймгийн Цээл, Заамар, Сэлэнгэ аймгийн Орхон-Туулд явж байгаа малчдыг маш олноор нь хөөж туусан. Зарим малыг нь машинаар дайрсан ч гэсэн ийм асуудал гараад

малчдын хооронд зөрчил нэлээн хурцдах янзтай байна. Аргаа ядахдаа малчид өчигдөр TV5 телевизийн сурвалжлах багийг газар дээр нь урьж Заамар сум, Цээл суманд нөхцөл байдал дээр нь очоод ирсэн байна. Ингээд TV5-аар ч гэсэн Өвөрхангай аймгийн отроор явж байгаа малчдын нөхцөл байдал амаргүй байна гэдэг асуудал яваад байна шүү дээ.

Энэ малчдын хөдөлмөр ч бас амаргүй хөдөлмөр шүү дээ. Нар салхинд хамгийн их гандаж, элээгдэж явдаг, цаг наргүй хөдөлмөр. Энэ мал аж ахуй чинь онцлог нь **“хаяа багтвал бууж, хамар хатгавал иднэ”** гэдэг зарчмаар л энэ мал аж ахуйн үйлдвэр чинь явж ирлээ шүү дээ. Одоо ийм зарчмаар энэ мал аж ахуйн үйлдвэр чинь явах боломжгүй болчихлоо.

Тийм учраас Засгийн газар онцгой анхаарч Онцгой комисс, Хүнс, Хөдөө аж ахуйн сайд энэ асуудалд онцгой анхаарч отрын малчдыг хөөж туухгүй байх, очсон нутагт нь ая тухтай өвөлжүүлж, хаваржуулаад хавар тохирсон хугацаандаа нутаг буцаах талаар тодорхой шийдвэрээ гаргаж энэ отроор яваа малчдадаа онцгой анхаармаар байна. Аль болгон энэ малчид чинь хэдэн малаа туугаад үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг орох орон байхгүй ингэж явах юм.

Энэ Өвөрхангай аймгийн малчид чинь нутгаасаа гараад сар гаруй боллоо. Гэр орноо бариад ая тухтай амарч унтаж чадахгүй, дандаа машин дээрээ нэг эсгий овоолоод л, тэр дотроо цайгаа уугаад л, тэр дотроо унтсан болоод л ингээд л амарч чадахгүй сар гаруйн хугацаатай явж байна шүү дээ.

Энэ тал дээр Засгийн газар, Онцгой комисс, Хүнс Хөдөө аж ахуйн

сайд онцгой анхаарч, Засгийн газар дээрээ мал аж ахуйн өвөлжилтийн асуудлыг авч үзээд отрын малчдад тодорхой бүс нутаг гаргаж өгөх, отрын малчдыг хөөж туухгүй байх талаар тодорхой шийдвэрүүдээ гаргаж өгөөч ээ.

Би чуулган дээр ярьсан. Шадар сайдтай ч өөрийн биеэр ч уулзаж хэлсэн. Тэгээд бид шийдвэрээ гаргачихсан л гээд байдаг. Энэ шийдвэр чинь хэрэгжихгүй байна шүү дээ. Одоогоороо Булган аймаг, Сүхбаатар аймгийн Засаг дарга нар зун малын халдварт өвчин гарсан гээд 2023 оны 01 дүгээр сарын 01-н хүртэл гаднын мал авахгүй, отор хүлээж авахгүй гэсэн захирамжтай. Ингээд ерөөсөө сумдын удирдлагууд нь хөдөлдөггүй ийм л нөхцөл байдалтай байна шүү дээ. Энэ нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа Монгол орны зовлон байна шүү дээ энэ чинь.

Тийм учраас энэ Онцгой комисс, Хөдөө аж ахуйн яам энэ оторчдод онцгой анхаарч, отрын бүс нутаг гаргаж өгөх, очсон бүс нутгаас нь хөөж туухгүй байх талаар тодорхой шийдвэр гаргамаар байна. Яаралтай бас энэ Засгийн газар авч үзэж бас анхаарч шийдвэр гаргахгүй бол энэ оторчдын асуудал маш хүнд байдалтай байна гэдгээ зориуд хэлье.

Тэгээд энэ долоо хоногийн хуралдаан дээр энэ өвөлжилтийн бэлтгэл ажил, мал аж ахуйн өвөлжилтийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэллээ. Тийм.

Ирэх долоо хоног Ерөнхий сайдын мэдээлэл. Намрын ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэлийн асуудлаар мэдээлэл хийхээр хойшилсон байгаа. Тийм ээ.

Энэ долоо хоног гишүүний асуултад хариулах ийм хуваарьтай долоо хоног. Хоёр дахь долоо хоногт гишүүдийн асуултад хариулдаг.

Тэгээд энэ долоо хоногт Байнгын хороодын саналаар тэр асуулт хариултын цаг тавьсан байгаа. Одоо хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан

саналуудтай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үндсэн үзүүлэлтүүдэд холбогдох өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу дараах саналуудаар санал хураалгалаа. Үүнд:

1.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 2023 онд “18,921.9 тэрбум төгрөг”, 2024 онд “20,797.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,859.9 тэрбум төгрөг” гэснийг 2023 онд “19,049.6 тэрбум төгрөг”, 2024 онд “19,822.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,314.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “34.7”, 2024 онд “36.3”, 2025 онд “34.5” гэснийг 2023 онд “34.9”, 2024 онд “34.6”, 2025 онд “33.6” гэж өөрчлөх;

2.Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2024 онд “22,401.7 тэрбум төгрөг”, 2025 онд “23,128.8 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “21,426.8 тэрбум төгрөг” 2025 онд “22,583.6 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “39.1”, 2025 онд “36.5” гэснийг, 2024 онд 37.4”, 2025 онд “35.6” гэж өөрчлөх;

3.Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ 2024 онд “1,926.4

тэрбум төгрөг”, 2025 онд “727.1 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “951.5 тэрбум төгрөг”, 2025 онд “1,156.9 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “3.4”, 2025 онд “1.1” гэснийг 2024 онд “1.7”, 2025 онд “1.8” гэж өөрчлөх;

4.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд “-1,553.4 тэрбум төгрөг” гэснийг “-1,425.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “-2.8” гэснийг “-2.6” гэж өөрчлөх;

5.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2023 онд “5,347.3 тэрбум төгрөг” гэснийг “5,359.7 тэрбум төгрөг” гэж өөрчлөх;

6.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ 2023 онд “1,999.0 тэрбум төгрөг” гэснийг “1,961.2 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “3.7” гэснийг “3.6” гэж өөрчлөх гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэж, танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын

хорооны танилцуулгыг хэлэлцэн, хуулийн төслийг эцэслэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, Хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүнд байна уу? Алга байна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 8 болон 32 дугаар хорооны албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе өө. /алга ташив/

Эрхэм хүндэт Баянголчууд Та бүхэн маань амжилт бүтээл дүүрэн байх болтугай.

Одоо Баагаагийн Батгөмөр гишүүнээр асуулт тасаллаа. Одоо Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бичиг баримт яагаад бий болсон юм бэ гэдэг талаар жаахан түүхээ сөхөх юм бол ямар нэгэн хязгаар тавих хэрэгтэй юм байна л гээд ярьсан байхгүй юу.

Тэгээд ямар нэгэн хязгаар яагаад тавих болсон бэ гэхээр энэ сонгуулийн амлалтаас болоод төсвийн зарлагын хэтрэлт, тэгээд уул уурхайн бүтээгдэхүүн. Бид баян юм. Тийм болохоор сайхан зардлаа тэлнэ гээд. Ингээд 2005 оноос Монгол Улсад төсвийн сахилга бат байхгүй болчихсон. Тэгээд оруулж ирсэн бүх мөнгөө сайхан таргаад хаячихдаг. Тэгээд цаашдаа дандаа ийм байх юм байна гэдэг ийм хүлээлт чинь өөрөө эдийн засгийг халаачихсан байхгүй юу.

Тэгээд эдийн засаг халаад цаашаа бүр болохгүй юм байна гээд. Тэгээд ийм нэг төсвийн хүрээ гэдэг ядаж 3 жилээр төлөвлөдөг байя. Зардлын хязгаарыг нь? төсвийн алдагдлын хязгаарыг нь тогтоодог байя л гэж ийм бичиг баримт уг нь хийсэн юм.

Тэгээд одоо харамсалтай нь энэ зүгээр цаас болчихлоо л доо. Байнга өөрчлөгддөг. Ямар ч нөлөө байхгүй. Тэгсэн ч гэлээ гэсэн энэ бол яг ингээд

бодлого барьдаг институцийн хувьд аягүй чухал бичиг баримт байдаг юм. Ялангуяа цаашаагаа нөгөө олон улсын байгууллага, санхүү мөнгө босгох эд нарт үүнийгээ үзүүлдэг байхгүй юу.

Нэг жилийн төсөв үзүүлж ярьдаггүй юм. Дунд хугацааны бичиг баримт үзүүлж ярьдаг юм. Тэр нь болохоор хоёрхон бичиг баримт байдаг юм. Нэг нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр. Ихэвчлэн мөрөөдлийн жагсаалт байдаг. Албан ёсны бичиг баримт нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл байдаг юм.

Тэгээд тэр дээрээ очиж яриа хэлэлцээрээ хийдэг. Гэтэл энэ маань одоо ингээд бодитой биш. Хэрэгждэггүй. Тэгээд анхныхаа тэр зорилгоосоо бүр ингээд хазайчихлаа.

Одоо яг үүн дээр би зүгээр нэг зүйл тодруулмаар байгаа юм. Манай энэ Сангийн яамныхан ер нь цаашаагаа энэ төсвийн бодлого авч явж чадах юм уу? Яг ийм байдлаараа. Энэ төсвийн хүрээн дээр чинь дахиад л төсвийн зарлага чинь тэлээд л, алдагдал чинь бас ингээд л өссөн байхаар л яваад байна шүү дээ. Үүнийгээ нэг удаа ч гэсэн орлогынхоо түвшинд нь хязгаарлачихаж болохгүй байгаа юм уу?

Одоо ингээд цаашаагаа бид ингээд эдийн засаг сайн ч үед, муу ч үед ингээд тэлж явсаар байгаад тэгээд ямар ч орон зайгүй болчихлоо шүү дээ. Нэг ширхэг цахилгаан станц барих эх үүсвэр байхгүй. Тэгээд газар доор дэд бүтцийн санхүүжилт хийх боломж байхгүй. Тэгээд л цаашаагаа хөгжлийн асуудлыг санхүүжүүлэх ямар ч боломжгүй төсөвтэй болчихлоо шүү дээ.

Монгол Улсын төсөв халамж санхүүжүүлдэг, цемент зуурдаг, цемент

санхүүжүүлдэг ийм л түвшин болчихлоо шүү дээ. Цаашаагаа. Ирэх жил 2023 онд нэг ширхэг ч төгрөгөөр шинэ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй гэж байгаа боловч яг үндсэн нөхцөл байдал чинь манайх угаасаа өрөөгүй болчихсон шүү дээ. 2024, 2025, 2026 онд ямар ч боломж байхгүй. Тэгээд урсгал зардлыг чинь хоёр хүн тутмын нэг нь халамж. Тэгээд хөрөнгө оруулалтын зардал чинь дандаа ингээд цемент зуурдаг. Үр дүн байдаггүй.

Үгүй ээ, тэгээд цаашаагаа энэ төсөв чинь хөгжлийг санхүүжүүлэх боломжгүй болчихоод байна шүү дээ. Үүнийгээ хязгаарлахгүй юм уу? Тэгээд ядаж энэ хүрээн дээрээ алдагдалгүй байхаар 2023, 2024, 2025 оныгоо оруулж ирж болохгүй байгаа юм уу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, одоо энэ нэг дуусаагүй баахан барилгууд байна. Эд нарыгаа зарчихаач ээ. Сангийн сайдад би хэлээд л байгаа юм. Дуудлага худалдаагаар зараач ээ. Тэгэхгүй бол цаашаа ямар ч өрөө тасалгаа байхгүй шүү дээ. Сангийн сайд бол маш сайн мэдэж байх ёстой. Сангийн яамныхан бүр их мэдэж байх ёстой.

Он дамжиж явсан энэ үр ашиггүй баахан цементүүд чинь өнөөдөр урсгал зардлыг нэмээд л, үр дүнд нь ийм их тэлэлттэй болчихоод байна шүү дээ. Гэтэл тэр дуусаагүй барилгууд чинь газар нь жирийн иргэдэд олдохгүй, бизнесүүдэд олдохгүй. Зөвхөн дуудлага худалдаагаар зарлалаа гэхэд газар нь үнээ нөхчих байхгүй юу.

Тэгээд ийм байдлаар бид энэ зардлаа хязгаарлах ажлыг одооноос л хийхгүй бол тэгээд Монгол Улс чинь дампуурлаа шүү дээ. Ерөөсөө л.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хорооноос танилцуулгатай холбогдуулж асууж байгаа. Эцсийн хэлэлцүүлэг. Байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултад хариулна.

Г.Тэмүүлэн: Т.Доржханд гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр үндсэндээ бид энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг Монгол Улсын төсвийн дунд болоод урт хугацааны бодлогын баримт бичиг байдаг. Энэ бодлогын баримт бичиг цаашид тогтвортой байх, цаашид тогтвортой мөрдөгддөг байх асуудал зарчмын асуудал байгаа.

Үндсэндээ би таны хэлсэн саналтай 100 хувь санал нэг байгаа. Бид Тогтвортой байдлын тухай хууль дээр төсвийн хүрээний мэдэгдлийг анх тусгаж өгч төсвийнхөө тогтвортой байдлыг хангах, төсөвт энэ хөндлөнгийн нөлөөллийг байхгүй болгох үндсэн дээр энэ бодлогыг хийж өгч байсан. Гэтэл сүүлийн 10 жилийн хугацаанд төсвийн хүрээний мэдэгдэл маань өөрөө 11 удаа өөрчлөгдсөн, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 13 удаа өөрчлөгдсөн ийм нөхцөл байдал байгаа.

Тэгэхээр бид энэ асуудалд бодитоор нь үнэлэлт дүгнэлт өгч, энэ дээр өөрсдөө цэг тавих зайлшгүй шаардлага байгаа гэж харж байгаа юм.

Тэгэхээр энэ удаагийн хувьд Улсын Их Хурлаас бид бүхэн энэ төсвийн хүрээний мэдэгдлийг цаашдаа төсвөөс нь тусдаа хэлэлцдэг болох, төсвийн хүрээний мэдэгдлийн ач холбогдлыг өндөрсгөх энэ тодорхой хуулийн өөрчлөлтүүдийг оруулж ирж байгаа.

Мөн цаашлаад бид тун удахгүй энэ сардаа багтаж энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулах, төсвийн тогтвортой хуульд өөрчлөлт оруулах босгыг өндөрсгөх, төсвийн хүрээний мэдэгдлийг цаашид илүү дийлэнх олгохоороо өөрчилдөг байх гэдэг юм уу, энэ хатуу босгыг бид оруулж өгч байж цаашид энэ төсвийн ил тод байдлын хяналт сайжрах, төсвийн төлөвлөлт, бодлого өөрөө сайжрах энэ нөхцөл байдал бүрдэнэ гэж харж байгаа.

Таны хэлсэн санал болох энэ орлогыг одоо өнөөдрийн байгаа түвшинд нь ядаж хязгаарлаж болдоггүй юм уу гэдэг асуудал ярьж байгаа. Энэ бол зөвхөн орлогын асуудал биш. Өнөөдөр бид КОВИД-ын дараах энэ тэлсэн хэмжээнд байгаа орлого, мөн цаашлаад зарлагаа ч гэсэн хязгаарлах зайлшгүй шаардлага байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр энэ удаагийн хувьд бид бас нэг талдаа шинэ хөрөнгө оруулалт байхгүй энэ цаг үе дээр төсвийн таналтыг тодорхой хэмжээнд тэвчиж болох зардлууд танах бодлогыг явуулсан. Энэ хүрээнд өргөн баригдсан төсвөөс төсвийн нэгдсэн тэнцвэржүүлсэн тэнцэл тодорхой хэмжээнд бага хувиар ч гэсэн сайжирч орж ирж байгаа.

Мөн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх энэ улсын төсвөөс санхүүжүүлэх зардал болоод зарлагын асуудлууд ч гэсэн бас тодорхой хэмжээнд буурч орж ирж байгаа гэдгийг танд хэлэх байна.

Тэгэхээр бид ер нь том зургаа харж, цаашдынхаа ирээдүйгээ харж, энэ улс орны төсөв өөрөө тогтвортой байх, бодлого нь өөрөө тууштай, зөв байх,

оновчтой зөв төлөвлөдөг байхын тулд төсвийн хүрээнийхээ бодлогыг төсвийн тогтвортой байдлынхаа хуулийг цаашид хэлбэрэлтгүйгээр сахин мөрддөг байх энэ эрх зүйн шинэчлэлийг хийх ёстой гэдэгт итгэл үнэмшил нэг байгаа.

Мөн дээрээс нь та сая барилгын салбарынхны асуудлыг хөндлөө. Энэ жилийн хувьд бид бүхэн улсын төсвөөс 2.7 их наяд төгрөгийн дуусаагүй барилгууд буюу өмнөх онуудад төлөвлөгдсөн барилгын байсан. барилгын санхүүжилтийн асуудлыг шийдэж байгаа. Гэтэл дараа жил ч гэсэн 1.5 их наяд, 2025 онд 300 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ өөрөө юуг харуулж байна вэ гэхээр олон жилийн хугацаанд бид энэ хөрөнгө оруулалт, төлөвлөлтийнхөө хэмжээнд бас тодорхой сахилга батыг баримтлаагүй байна гэдэг зүйл харагдаж байгаа. Энэ ч үүднээсээ бид энэ барилгын салбарынхны, тэр дундаа аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхний эрх ашгийг хамгаалах тодорхой зохицуулалтуудыг төсвийн хуульд хийж өгөх зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа.

2021-2023 оны хооронд ирэх жил хүртэлх хугацаанд энэ олон мянган барилгын аж ахуйн нэгж байгууллагууд цалингийн өөрчлөлт, барилгын материалын үнийн өсөлт, тээвэр, машин механизмын үнийн өсөлтөөс хамаараад тухайн барьж байгаа гүйцэтгэж байсан ажил, үйлчилгээ, хөрөнгө оруулалт нь төсөвт өртөг нь ихээр нэмэгдэж байгаа. Үүгээрээ дамжуулж их хэмжээний алдагдал хүлээхээр ийм нөхцөл байдал үүсэж байгаа.

Тэгэхээр бид үүн дээр ч гэсэн дүгнэлт хийж, цаашдаа барилгын

материал болн төсөвт өртгийн нэмэгдэл, цаашдаа магадгүй инфляцынхаа түвшинтэйгээ индексээрээ нэмэгддэг байх тодорхой хэмжээний зохицуулалтуудыг хийж энэ гарц шийдлийг гарах ёстой гэж харж байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг, Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт Хужиртууддаа хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Т.Баярмөнх дарга чинь сайн биз. Тэр ирчихсэн байна уу? З.Цэцэгмаа дарга. Та хэд тэгээд ажлын амжилт хүсье. Сайн сайхныг хүсье.

Одоо Мөнхөөгийн М.Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Төсвийн хүрээний мэдэгдэл гээд бид дунд болон урт хугацаанд Монгол Улс маань яаж хөгжих нь вэ. Тухайн иргэд, жишээлбэл, Улаанбаатар хотод амьдарч байгаа иргэд, орон нутагт амьдарч байгаа иргэд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг харангуутаа 2023 онд, 2024 онд, 2025 онд манай дүүрэг, манай хот? манай аймаг яаж хөгжих нь вэ. Гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улс энэ дунд болоод урт хугацаанд аль салбар руу илүү түлхүү хөрөнгө оруулалт хийж, аль салбарыг илүү их татварын бодлогоор дэмжих нь вэ гэх мэт тэр урьдчилсан таамаглах зүйлүүдээ олж харах ийм баримт бичиг.

Гэтэл өнөөдөр төсвийн хүрээний мэдэгдэл маань энэ үүргээ биелүүлж чадахгүй байгаад байна л даа.

Бид сая ингээд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай уулзахад танай төсвийн хүрээний мэдэгдлийг харахад яг гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чухал байна, гаднаас валют орж ирэх чухал байна гэсэн хэрнээ ямар бодлогоор яаж дэмжих юм, татварын бодлого нь юу байх юм гэдэг чинь танай төсвийн хүрээний мэдэгдлээс харахад тодорхойгүй байна гээд яриад байгаа юм.

Тэгээд сая бас Төсвийн байнгын хорооны дарга чинь ярьж байна. Бид яг энэ дээрээ үнэхээр тэгж 5 жилээр юм уу, 3 жилээр төсвийн хүрээний мэдэгдэлдээ маш тодорхой ямар бодлого бид эдийн засгийн салбартаа барих юм. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд энэ дунд болон урт хугацаанд аль салбарт хаанаас яаж хөрөнгө оруулалт орж, харин төр өөрөө бодлогоороо яаж татвараараа дэмжих юм гэдэг зүйлүүд уг нь тодорхой тусгагдаад явах ёстой. Гэтэл энэ өөрөө тодорхойгүй байгаад байна л даа.

Өнөөдөр бид хамгийн гол нь төсвийнхөө бүтцийг хүртэл аваад үзэхэд одоо зүгээр өрийн төлбөр, халамжийн төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн төлбөр, тэгээд хөрөнгө оруулалтын төлбөр гэсэн нэг хэдхэн дөрөвхөн бүтэцтэй л бараг болоод байна.

Тэгэхээр төсвийн бүтэцдээ хүртэл бид анхаарлаа хандуулахгүй бол энэ нь өөрөө нөгөө улс орнуудын хөгжлийн бодлого, төлөвлөлттэйгөө ч гэсэн энэ уялдахгүй яваад байна л даа. Бараг л бид төсөв батлахдаа өрөө яаж төлөх юм, өрийн төлбөр ямар байх юм. Халамж гээд л. Тэгээд тэтгэвэр,

тэтгэмж, хөрөнгө оруулалт нь дараа нь орж ирж байна. Хөрөнгө оруулалтаасаа харахад шинэ хөрөнгө оруулалт тусгахгүй. Хуучин гүйцэтгэл нь 70, 80 хувьтай. Гэрээ нь хийгдээд явж байгаа хөрөнгө оруулалтыг бид цааш нь ингээд дуусгана гэсэн нэг л тийм ерөнхий зорилготой явж байгаа нь өөрөө маш хязгаарлагдмал байгаа дээр иргэд ч гэсэн шүүмжлэлтэй хандаж байна л даа.

Тэгэхээр бид иймэрхүү зүйлдээ дараа дараагийн төсвийн хүрээний мэдэгдэл. Үүнтэй уяад тухайн жилийн төсвөө тооцохдоо ч гэсэн тэр хүн ам хэд байна. Хөгжлийн бодлого нь хаанаа юм гээд. Энэ тэрээ маш сайн тусгаж бодохгүй бол асуудал маш их байна.

Өнөөдөр иргэд бид ярьж байна шүү дээ. Өнгөрсөн жил бид жишээлбэл нөгөө төрөөс баримтлах мөнгөний бодлогыг баримтлахдаа нэг оронтой тоонд буюу инфляци 8-нд барина гэсэн бол одоо 13, 14. Хоёр оронтой тоонд ороод явж байна л даа. Өнөөдөр бид дахиад л 2023 оны төсөв батлахдаа нэг оронтой тоон дээр буюу дахиад 8 дээр нь юм уу, 6 нэмэх хасах 2 дээр авчирна гэсэн. Гэтэл 2023, дунд болон урт хугацаагаа харахад ийм эдийн засгийн нөхцөл байдлыг харахад бас ингэж харагдахгүй байна л даа.

Тэгэхээр энэ зөв тодорхойлж, зөв хүрээнийхээ мэдэгдэл энэ тэрийг бодит тоон дээр үндэслэж хийхгүй бол энэ алдагдалтай байгаад байгаа нь бас буруу байна. Эдийн засагчид ч гэсэн шүүмжлээд байна л даа. Манай улсын төсвийн орлого, зарлагыг харахад орлого нь 18 их наяд байхад зарлага нь 20 их наяд гээд 20 хувиас дээш энэ ялгаа нь гарч ирчхээд байгаа нь өөрөө бас ноцтой асуудал шүү дээ.

Тэгэхээр бид яаж эндээ тооцоолох вэ гэдэг дээр хүртэл төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ маш онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Уг нь энэ хараад байхад энэ удаагийн төсвийн нэг эерэг тал нь бид жишээ нь төсвийг алдагдалгүй л батлах бололцоо байгаа нь бас харагдаж байна. Гэхдээ ингэхэд яах юм гэхээр нөгөө саяын хэлээд байгаа эрдэс баялаг, гарч байгаа энэ экспортын бүтээгдэхүүн энэ бүхний маань орж ирж байгаа үр дүн нь, ач холбогдол нь, статистик, тоо баримт нь тодорхой байх нь өөрөө чухал байна.

Тийм учраас бид төсвийн хүрээний мэдэгдэл дээр цаашдаа Улсын Их Хурал яг тухайн Байнгын хороо энэ тэр нь ач холбогдол өгч нухацтай сууж, ажлын хэсэг энэ тэр нь бодит тоон дээр үндэслэж тооцоолж байх нь чухал байна шүү гэдгийг бас өнөөдөр бүр хэлье гэж бодсон юм.

Иргэдтэйгээ уулзахад хүртэл энэ зүйлийг бидэнд бас захиж хэлж байсан гэдгийг чуулганыхаа хуралдаанд.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Ингээд төсөв батлагдах нь. Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдах нь. Төсвийг сайн хийхийн тулд төсвийн хүрээний мэдэгдлээ их сайн хийж боловсруулах ёстой л доо.

Тэгээд энэ жилийн ингээд энэ төсөв, төсвийн хүрээний мэдэгдлийг үзэхээр Монголын эдийн засагт суурь реформын шинжтэй шинэчлэлийн бодлого ерөөсөө барихгүй байгаа юм.

Монголын төрд энэ хөгжлийн бодлого төлөвлөгч нар ер нь байхгүй болчихсон юм уу даа. Хөгжлөө төлөвлөж чадахгүй болчихсон байна. Жижиг улс жижиг төсөвтэй. Өр зээл ихтэй боловч суурь реформын шинжтэй шинэчлэлүүд энэ төсөвд байх ёстой. Энэ байхгүй байгаад байна.

Орлого олох боломжийг ажиллаж чадсангүй ээ. Харамсалтай. 1.5 их наяд төгрөгийг олох боломж байна. Төсвөө алдагдалгүй баталъя гээд бид өгсөн. Сангийн яамнаас орж ирсэн нь төсөвтэйгөө зөрчилдөөд бүх төсөв маань задрах ийм байдалд л орчихож байгаа юм л даа. Ингээд 127 тэрбум төгрөгөөр нэмээд л ингээд дуусаж байна л даа.

Дараагийн асуудал энэ Оюу Толгой төсөл байна. Дэлхийн 4 том төслийн нэг гэж байгаа шүү дээ.

Монголын ард түмэн маш их үр дүн хүлээж байсан. Далд уурхай ирэх жил ашиглалтад орно. Ирэх жил 600-гаад тэрбум төгрөг оруулахаар төлөвлөж байгаа нь үнэхээр гарч байгаа баялагтай нь харьцуулах юм үнэхээр жижигхэн байна шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ. Одоо энэ хөгжилтэй гэдэг орнууд жижиг орнуудыг шулдаг, удирдлагуудыг авлигаддаг, өөрийнхөө эрх ашгийг хангадаг шилдэг жишээ бол одоо энэ Оюу Толгой төсөл дээр байж байна шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ. Үүнтэй ажиллах шаардлагатай.

Оюу Толгой төсөлд Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай 92 дугаар тогтоолыг хаагаад хаясан. Тийм байж болохгүй ээ. Одоо үүнийг үргэлжлүүлж ажиллах ёстой гэсээр байтал хаасан шүү дээ.

Тэгээд одоо энэ дээр эрх ашиг хангагдахгүй байна. Үүнийг 2023 онд

үргэлжлүүлж ажиллах шаардлагатай гэж байгаа юм.

Төсвийнхөө зардлыг эрэмбэ, ач холбогдлоор нь эрэмбэлж чадаагүй. Хэмнэлт гаргаж чадаагүй. Төсвийн алдагдлыг бууруулах боломж байгаад байхад алдагдлыг нь бууруулж чадаагүй. Төсөв маань бүхэлдээ хөгжил биш, урсгал зардал санхүүжүүлж байна шүү дээ.

2023 онд Монгол Улсын Засгийн газар 1 тэрбум долларын гадаад өр төлнө. Энэ тодорхойгүй байгаа. Засгийн газрын өрийн хэмжээ 35 их наяд болоод 7 их наядаар нэмэгдэж байгаа.

Ажлын байрыг нэмэгдүүлсэн ЖДҮ-г дэмжсэн ийм бодлого энд алга. Ард иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, шинжлэх ухаан, технологи, инновацыг дэмжсэн бодлого алга. Төсвийн бодлого маань мөнгөнийхөө бодлоготой уялдаа муутай. Мянган хүнд ногдох төрийн албан хаагчдын тоогоор Монгол Улс дэлхийд манлайлдаг. Гэтэл өнөөдөр шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, үүнийг ашиглаад энэ төрийн зардлыг бууруулах энэ чиглэлд юм алга.

Ерөөсөө боломжоосоо доогуур төлөвлөөд, тэрийгээ төлөвлөгөө биелүүлсэн болоод явдаг. Далд эдийн засаг, хулгайтай тэмцсэнгүй. Нөгөө гурилын хулгайч баригддаг гэж үг байдаг. Нүүрсний хулгайч нар эхлээд баригдаж байна шүү дээ. Одоо энэ нүүрсний хулгай, тэрийг тойрсон үнийн луйвар, төмөр зам, тэр тээвэртэй холбогдсон энэ луйвар үнэхээр газар авсан. Дэндүү өндөр авсан. Аливаа зүйл өндрөөс унахдаа хүчтэй унадаг гэдэг. Хүчтэй унана. Энэ хулгай хийсэн хүмүүсийг хэн томилсон юм бэ? Тэр

томилсон хүмүүстэй нь хариуцлага тооцох хэрэгтэй шүү дээ.

Ямар ч байсан 2023 оны төсөл Монгол Улсын хөгжил, Монголын ард түмний амьдралд өөрчлөлт гаргаж чадахгүй нь ээ. Одоо энэ хулгай луйврыг ил болгох, далд эдийн засгийг ил болгож чадсан бол энэ 19 их наяд төгрөгийн орлогыг нэг дахин илүү нэмэх боломж байна.

Г.Занданшатар: Г.Тэмүүлэн гишүүн. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Байнгын хороон дарга хариулъя.

Г.Тэмүүлэн: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үндсэндээ бас л яг энэ төсөв, санхүүгийн сахилга бат гэдэг асуудал өнөөдөр бид бүхэнд ус агаар мэт хэрэгтэй байгаа гол зүйл байгаа.

Тэгэхээр энэ асуудал дээр бид төсвийн шинэчлэлийн хүрээнд, энэ төсвийн шинэчлэлийг Улсын Их Хурал болоод Засгийн газар хамтарч зайлшгүй ойрын хугацаанд хийж эхлүүлэх ёстой. Эхнээсээ Төсвийн байнгын хороо төсвийн шинэчлэлийн эхлэлийг энэ төсөв дагалдсан хуулиудын хүрээнд хийж эхэлж оруулж ирж байгаа.

Төсвийн шинэчлэлийг бид ойрын хугацаанд хийгээд залгуулаад мөн энэ салбаруудын шинэчлэлүүдэд зайлшгүй шаарлагатай байна. Тэтгэврийн шинэчлэл. Төсөв дээр хамгийн их ачаалал өгдөг энэ тэтгэвэр бол халамжийн бодлоготой холбоотой бодлогууд, энэ салбаруудын шинэчлэлүүд зайлшгүй ойрын хугацаанд хийгдэж байж төсөв дээр ирэх ачааллууд өөрөө буурах боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Тэгэхээр бид энэ асуудал дээр ер нь зарчмын үндсэн дээр хандаж төсвийг өөрөө хатуу чанга байлгах, цаашдаа төсвийнхөө тогтвортой байдлын хууль болоод төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг хэлбэрэлтгүйгээр сахин мөрддөг байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байж цаашдаа магадгүй бид төсвийнхөө хүрээнд зөв оновчтой зүйлдээ захиран зарцуулдаг, хөрөнгө оруулалтыг хуваарилдаг, төлөвлөдөг боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Бид ер нь таны хэлсэн саналтай 100 хувь нэг байгаа. Бид төсөв дагаж төсвийн хүрээний мэдэгдэл болоод тогтвортой байдлынхаа хуулиуд дээр бас нэг өөрчлөлт оруулдаг, өөрчилдөг буруу жишгийг халах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байгаа. Энэ хүрээндээ бид энэ Хууль тогтоомжийн хуулиар өөрчлөлт оруулах асуудлыг болиулах асуудлыг Байнгын хороо санаачлаад явж байгаа гэдгийг танд хэлэх байна.

Ер нь төсөв тэлэх энэ тэлэлт болгоны зардал болгон цааш нөгөө талдаа энэ инфляц болоод төлбөрийн тэнцэл, гадаад валютын алдагдал, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа асуудлууд байна.

Тэгэхээр бид энэ асуудал дээр бас нэг ул суурьтай хандаж, бодитоор шинэчлэлүүдийг хийж, төсөв дээр ирэх ачааллуудыг бууруулах зайлшгүй шаардлага байна гэдэгт байр сууриа илэрхийлэх байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн 1 минут.

Б.Баттөмөр: Энэ 2023 онд Монголын эдийн засагт хэд хэдэн сорилтууд тулгарч байгаа юм.

Нэгдүгээрт, “стагфляц”^{[өндөр инфляци, эдийн засгийн стагнацийн (зогсонги байдлын) хослол]-д гүнзгий нэрвэгдсэн шүү. Үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой.}

Дөрвөн хямралыг давж гарч байж арилсан ийм түүх дэлхийн түүхэнд байдаг юм билээ. “Бүтээмжээ нэмэгдүүлэх”, “орлогоо нэмэгдүүлэх”, “зардлаа хэмнэх”, “худалдаагаа үр ашигтай хийх” дөрвөн ийм шат дамжлагыг дамжиж байж энэ стагфляц гэдэг юмнаас гарна шүү. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сая манай С.Чинзориг гишүүний яриад байгаа энэ өвөлжилт хүндэрнэ. Монголд зуд болно шүү.

Гурав дахь асуудал бол Монгол Улс 9.7 тэрбум киловатт цаг эрчим хүч үйлдвэрлэж байгаа. Суурилагдсан хүчин чадлаас хэрэгцээ одоо бараг 10-аад хувиар давж байгаа. Эрчим хүчний салбар хамгийн эрсдэлтэй салбар болж байгаа шүү. Ийм зүйлүүд дээр бид анхаарах шаардлага байгаа.

Сүүлийн үед Валютын Сангийн хөтөлбөрт орно гэсэн нэг ийм юм яриад яваад байгаа. Ийм юм байж болохгүй шүү. Хэрвээ байдаг бол хариуцлага хүлээх ёстой шүү. Ийм байдалд оруулсан улсууд. Гадаад өрийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Зочид танилцуулъя.

Зэвсэгч хүчний 032 дугаар ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой тэмцэж байна.

Эрхэм хүндэт албан хаагчиддаа эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Гишүүдийн нэрийн өмнөөс. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 6 санал байгаа.

Эрхэм хүндэт албан хаагчид, цэрэг, ахлагч, офицерууддаа төрийн албаа чин шударгаар гүйцэтгэж, өргөсөн тангарагдаа үнэнч байж, ажлын өндөр амжилт гаргахыг хүсээд ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс амжилт хүсье. /алга ташив/

Одоо санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт бэлдэж байх хооронд Хассуурын Ганхуяг гишүүн сууж байх хооронд юу яая.

Сая Б.Баттөмөр гишүүний хэлж байгаа зүйлүүдийг бас Засгийн газар, Байнгын хороод анхаарна биз. Одоо манай доктор Б.Баттөмөр гишүүн бол бас маш чухал саналууд хэлж байгаа.

Тэгэхдээ Валютын Сангийн хувьд жилд 15 улс хөтөлбөрт хамрагддаг байсан бол цар тахал, дайны нөхцөл байдлын улмаас өнөөдөр Олон Улсын Валютын Сангийн гишүүн орнуудын бараг гуравны нэг нь хөтөлбөрт хамрагдахаар санал тавьчхаад орчхоод байна.

15 улс хамрагддаг байсан бол одоо 44 улс Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдчихаад байна. 44 улс. Одоо 20 улс хандчихсан байна. Тэр дотор хөгжингүй улсууд хүртэл. Бүр тогтоож төсөөлж байгаагүй тогтвортой эдийн засагтай гэж тооцож байсан улсууд хүртэл нэлээн хүндрэлтэй байдал бий болсон. Одоо Вьетнамын эдийн засаг дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж байгаа эдийн засгуудын нэг байсан. Өнөөдөр хүндрэлтэй болчихоод байна. Том улсуудын эдийн засаг ч гэсэн хүндэрч байна.

Тийм учраас энэ Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөр гэдэг бол тийм аймшигтай зүйл биш. Хүнд хэцүү зүйл гэхээсээ илүү хөнгөлөлттэй зээлийг тодорхой нөхцөлтэйгөөр зээлдүүлдэг. Нэн хөнгөлөлттэй зээл олгодог л. Энэ хүндрэлийг даван туулах үе нь дэлхий даяар тулгараад байгаа дайн, бэрхшээл, давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болоод байгаа үнийн өсөлт дэлхийн бүх оронд маш том хүндрэлүүдийг бий болгож байна шүү дээ. Үүнийг бид бас дотроо сайн ярьж, ойлголцож, ойлгуулж байх нь зөв байгаа юм.

Тэгээд Т.Доржханд гишүүн, Б.Баттөмөр гишүүдийн хэлж байгаа төсвийн хүрээний мэдэгдлийн тогтвортой байдал бол өөрөө маш чухал. Энэ талаар төсөв дагасан хууль дээр сая Г.Тэмүүлэн гишүүн хэллээ. Тогтвортой байдлыг бүр хуульчилж гуравны хоёроор юм уу, өндөр босготой нарийн болгохоор саналууд гарч ярьсан байгаа. Тийм ээ.

Энэ талаараа тийм ажил хэрэгч асуудлуудыг ярилцаж, хэлэлцэж шийдвэл цаашдаа чухал байгаа юм.

Ингээд санал хураалт бэлэн болсон байх. Ингээд санал хураалтаа эхэлье.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тусгагдсан Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 2023 онд “18,921.9 тэрбум төгрөг”, 2024 онд “20,797.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,859.9 тэрбум төгрөг” гэснийг 2023 онд “19,049.6 тэрбум төгрөг”, 2024 онд “19,822.4 тэрбум төгрөг”, 2025 онд “21,314.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “34.7”, 2024 онд “36.3”, 2025 онд “34.5” гэснийг 2023 онд “34.9”, 2024 онд “34.6”, 2025 онд “33.6” гэж өөрчлөх.

Санал гаргасан. Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ширнэнбаньдийн Адьшаа, Цогт-Очирын Анадбазар, Хавдисламын Баделхан Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Баагаагийн Баттөмөр, Энхбаярын Батшугар, Жадамбын Бат-Эрдэнэ, Гочоогийн Ганболд, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтай Ганибал, Хассуурын Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жамьянгийн Мөнхбат, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Саранчимэг, Цэдэвийн Сэргэлэн, Цэвэгдоржийн Туваан, Чинбатын Ундрам, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Содномын Чинзориг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Төмөртоогоогийн Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт.

Энэ дээр тэгээд ажлын хэсэг гээд биччихсэн юм байна шүү дээ. Төсвийн байнгын хороо. Цаашдаа Төсвийн байнгын хороо. Энэ тэгээд яагаад ажлын хэсэг гээд биччихсэн юм. Дагасан хууль юм чинь ажлын хэсгээрээ явах юм биш үү.

Ингээд санал хураалт явуулна. Санал хураалтад бэлэн байна уу? Санал хураалт. /алх цохив/

Үг авч болохгүй ээ. Дэмжсэн, дэмжээгүй санал хэлж болно. Тийм.

71.2 хувийн саналаар 42 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2024 онд “22,401.7 тэрбум төгрөг”, 2025 онд “23,128.8 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “21,426.8 тэрбум төгрөг” 2025 онд “22,583.6 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “39.1”, 2025 онд “36.5” гэснийг, 2024 онд 37.4”, 2025 онд “35.6” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Тогмидын Доржханд гишүүн дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Т.Доржханд гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүн үг хэлье.

Т.Доржханд: Баярлалаа. Би энэ заалтыг дэмжих боломжгүй байна.

Яагаад вэ гээд тэгэхээр манай зарлага бол ингээд байнга тэлээд байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг чинь хязгаарлах боломж нь уг нь төсвийн хүрээ байдаг. Тэгээд төсвийн хүрээгээрээ бас ингээд тэлээд л байх энэ зохицуулалтыг хийж болохгүй. Нэг.

Хоёрдугаарт, бас нэг ийм зүйл байна. КОВИД-ын үеийн хүндрэлийн

үеэр Засгийн газрууд баахан мөнгө тараачихсан. Гэтэл олон улсад олон улсын байгууллагууд, олон улсын эдийн засагч нарын яг санал нэгдээд байгаа юм нь яг тэр хүндрэлийн үе биш байна. Яг хүндрэлийн дараа бүр илүү их нөлөөллийг эдийн засагт цохилтуудыг КОВИД үзүүлэх юм байна. Энэ бол дунд хугацааны асуудал байна. Энд 2-оос 4 жил маш хэцүү байдал үүсгэнэ гээд.

Тэгээд сая Их Хурлын дарга хэллээ шүү дээ. Нийт Валютын Сангийн гишүүн орнуудын гуравны нэг нь хөтөлбөр авъя гээд гуйгаад байна гээд. Бодит байдалд яг энэ байхгүй юу. Яагаад вэ гээд тэгэхээр КОВИД-ыг л амжилттай дарж байвал хамаа байхгүй гээд баахан мөнгө тараагаад л, баахан иргэддээ мөнгө халамжлаад л, цаашаа бизнесүүдтэй хөнгөлөлттэй зээл өгсөөр байгаад дэлхий ертөнц чинь эдийн засаг нь гацчихаад байна шүү дээ. Гацчихсан. Бүх улсуудыг ханш нь дээшээгээ савлачихсан. Инфляц нь өсчихсөн. Нийлүүлэлтийн сүлжээ нь доголджихсон. Тэгээд цаашаа дэлхий өөрийнхөө цикл рүү орж ирэхэд хугацаа хэрэгтэй байна гээд.

Тэгээд ийм үед дэлхий юу авч байна вэ гээд тэгэхээр бизнес идэвхжихгүй байгаа үед татварын орлогоо бууруулах юм байна. Татвараа бид хангалттай авч чадахгүй юм байна. Татвараа авч чадахгүй байгаа тохиолдолд бид зарлага санхүүжилтээ хязгаарлахаас өөр аргагүй юм байна гээд.

Одоо Валютын Сангийн **Chief economist** гээд хэлж байгаа юм нь ерөөсөө л “хумь, хумь, хумь” гээд. Дэлхийн банкны **Chief economist** бас “хумь, хумь, хумь” гээд.

Энэ чинь ерөөсөө л онол нь, гарц нь байна шүү дээ.

Тэгэхээр бид дахиад хоёр, гурван жилийн хугацаанд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх гээд байна. 2024 онд бас сонгууль угтах гээд байна. Тэгээд Монголоо цаашаага авч яваад төсвийн сахилга баттай явах нь чухал юм уу, аль эсвэл за за энэ нэг төсвийн хүрээний мэдэгдлийг тэгээд төсөвтэйгөө нийлүүлээд л өөрчилчихдөг юм хөөрхий. Тэгээд л яах вэ энэ нь явж л байгаа дээ. Формал юм даа гэсэн байдлаар хандах юм уу л гэж.

Тэгээд тийм болохоороо энэ тоогоо хязгаарлах гээд байгаа юм. Түрүүчийн миний санаа нь бол орлого чинь хангалттай орж ирж чадахгүй ээ. Төсөөлөл чинь аягүй өөдрөг байна. Төсөөлөлд орлогоо өндөр тавьчихаар зарлагаа тэлээд яваад байгаа байхгүй юу.

30 жилийн зовлон энэ шүү дээ. Дандаа л ийм байж ирсэн шүү дээ. Одоо дэлхий ертөнцөд сүүлийн 1950 оноос хойш дэлхийн 2 дугаар дайнаас урьд хожид үзэгдээгүй ийм хүндрэл дэлхий дээр үүсчихээд байна. Тэр нь эдийн засгийн хүндрэл байна. Ийм болохоор одоо бүгдээрээ зардлаа хумиад бүсээ чангалаад явах нь хамгийн зүйтэй. Ингэж байж мөнгөний бодлого дээрээ орон зай гаргаж өгөхгүй бол инфляцаа дийлэхгүй юм байна. Цаашаа ханшаа барьж дийлэхгүй юм байна. Тэгээд энэ чинь өөрөө гинжин урвалаараа зардал өсөх л юм бол ханш өсөөд байдаг. Дагаад инфляци өсөөд байдаг. Тэгээд л эргээд л хүмүүс цалингаа өсгөхийг шаарддаг. Ингээд нэг чөтгөрийн тойрогт яваад байна. Үүний анхдагч нь төсөв юм байна. Төсвөө аягүй хэмнэх хэрэгтэй. Бүр хязгаарлаад алдагдалгүй төсөв баталбал маш сайн гэдгийг олон улсын

зөвлөмжүүд бүгдээрээ гарч ирээд байгаа юм.

Тэгээд тийм болохоор манай төсвийн хүрээний мэдэгдэл дээр ялангуяа ирэх жилийн төсөөллүүд дээр өөдрөг битгий төсөөлөөч ээ. Зардлаа хумьчих аа. Ядаж орж ирж байгаа орлогынхоо түвшинд зардлаа тавьчих л даа. Тэгээд бүгдээрээ нэг алдагдалгүй төсөв баталъя л даа. Ингэж байж бид өрийнхөө асуудлыг шийднэ шүү дээ.

Дэлхий ертөнц чинь мөнгө олдохоо больчихлоо шүү дээ. Бид ингээд Валютын Сан гээд. Биднийг гуйгаад л, хаалганы гадаа ингээд л тогшоод л та нар мөнгө аваач ээ гэдэг тийм юм байхгүй шүү дээ. Дэлхий дээр чинь.

Одоо бүх хөрөнгө оруулалтууд чинь ингээд Америк руу татагдчихлаа. Энэ бүс нутагт чинь хөрөнгө оруулалт байхгүй. Мөнгө их үнэтэй болчихлоо. Өнөөдөр Засгийн газар бонд гаргах юм бол 15 хувиас доошгүй. 15 хувиас доошгүй гарна гэдэг чинь Аргентины, хамгийн сүүлийн Грекийн жишээ шүү дээ. 16 дээр зогсоод л мөнгө өгөхөө больчихдог ийм нөхцөл байдалтай байгаа болохоор мөнгөө хэмнэе.

Г.Занданшатар: Дэмжихгүй гэсэн үндсэн санааг дэмжиж хэллээ гэж ойлгож байна.

Энэ заалт чинь төсвийн нийт зарлагын дээд хэмжээг бууруулж байгаа. Бодит мөнгөн дүнгээрээ бууруулж байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувийг бас бууруулж байгаа ийм заалт шүү дээ. Тийм ээ.

39-ийг 37 болгож байгаа. Санал хураалт явуулъя. Нэмэгдүүлсэн гээд та

хэлчихсэн учраас. Нэмэгдүүлээгүй бууруулж байгаа юм шүү гэдгийг бас тодотгож хэлж байгаа юм. Төсвийн зарлагыг 2024, 2025 оны төсөөллийг бууруулж байгаа юм. Санал хураалт. /алх цохив/

37 гишүүн дэмжиж, 62.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ 2024 онд “1,926.4 тэрбум төгрөг”, 2025 онд “727.1 тэрбум төгрөг” гэснийг, 2024 онд “951.5 тэрбум төгрөг”, 2025 онд “1,156.9 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “3.4”, 2025 онд “1.1” гэснийг 2024 онд “1.7”, 2025 онд “1.8” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

38 гишүүн дэмжиж, 64.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд “-1,553.4 тэрбум төгрөг” гэснийг “-1,425.7 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “-2.8” гэснийг “-2.6” гэж өөрчлөх;

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй тооцлоо. /алх цохив/

Тогмидын Доржханд гишүүн, Ширнэнбаньдийн Адьшаа гишүүнээр тасаллаа.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр энэ заалтууд нь өмнөх орж ирж байсан төслүүдээсээ жоохон жоохон бууруулаад ороод ирчихсэн болохоор хэмнэлт гэж харагдаад байх шиг байна л даа. Гэхдээ энэ зарчмын ялгаатай

асуудал тавиад байгаа юм шүү. Тухайлбал, энэ төсвийн алдагдал 1.5 гэдгийг 1.4 болгочихлоо. 2.8 дотоодын бүтээгдэхүүнийг 2.6 хувьд бууруулаад ороод ирлээ гээд. Буулгах нь зөв өө, зөв.

Тэгэхдээ бидний тавиад байгаа байр суурь чинь алдагдалгүй төсөв баталчих гэсэн ийм байр суурь тавиад байгаа шүү дээ.

Ардчилсан намын бүлэг бас алдагдалгүй төсөв батлах ёстой л гэсэн ийм байр суурьтай байна гэж би ойлгосон. Зөв шүү дээ.

Өнөөдрийн байдлаар сүүлийн 2000 оноос хойш, ялангуяа 2005 оноос хойш эдийн засаг уул уурхайгаас хамааралтай болсноос болоод л бид хамаг юмаа тавьчихсан. Үр дунд нь 18 их наяд төгрөгийн алдагдал үүсчихээд байгаа шүү дээ. 18 их наяд. Хуримтлагдсан алдагдал.

Үр дүн нь яг энд ингээд өр болоод явдаг. “Өр”. Тэгээд бүгдээрээ энд ингээд сайхан чанга дуугаар өр яриад байдаг. Өр муухай. Та нар нэмж авлаа. Бид аваагүй. Үгүй. Та нар авсан гээд.

Үгүй ээ, тэгээд өрөө бид яаж зарж байгаа вэ гэхээр өрөө ерөөсөө дараагүй шүү дээ. Дандаа дахин санхүүжилт хийгээд байгаа шүү дээ. Өрийг чинь дарах боломж нь юу вэ гэхээр энэ чинь төсөв чинь алдагдалгүй ашигтай батлагдаж өр дарагдана.

Манайх өрүүдээ дандаа дахин санхүүжүүлээд л, хойшоо шийдээд байгаа шүү. Дандаа хойшоо шидээд байгаа. Хойшоо шидэх тусам энэ чинь хуримтлагдаад яваад байгаа шүү дээ.

Тэгээд үүнийгээ нэг удаа ингээд зогсоогоод алдагдалгүй төсөв батлаад явж болдоггүй юм уу. Бүрэн боломжтой шүү дээ. Бүрэн боломжтой байгаа болохоор энэ Засгийн газрын зүгээс алдагдалгүй төсвөө оруулаад ирээч ээ. Улсын Их Хурал нь дэмжье. Сөрөг хүчнүүд нь энд дэмжье гээд байр сууриа илэрхийлээд байна шүү дээ.

Тэгэхээр цаашаа энэ төсвийн хүрэн дээрээ алдагдалгүй төсөв оруулж ирэх хэрэгтэй. Б.Жавхлан сайд аа. Алдагдалгүйгээр. Энэ Монгол Улсад хэрэгтэй шүү дээ.

Бид чинь одоо ингээд л сонгуулийн өмнө сайхан ард түмэндээ хайртай болоод л баахан халамж тараадаг. Тэгээд дэд бүтцийнхээ санхүүжилтийг хийгээд шавар зуурсаар байгаад одоо ингээд дэд бүтцийн санхүүжилт хийх мөнгө байхгүй. Арга ядаад төрийн өмчийн компаниудаар санхүүжилтээ хийлгэж байгаа нь үнэн шүү дээ.

Хаа байсан “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой Монгол” гэдэг компаниар чинь төмөр зам тавиулаад. Ийшээгээ явж байгаа төмөр зам нь тэгсэн чинь ямар ч ашиглалт байхгүй. Урагшаа явж байгаа нь мухар. Тэгсэн мөртлөө зөрүү нь өөрсдөө дөрөв, тав дахин үнэтэй зах зээлийн ийм үнээр ингээд шахчихсан. Тэр нь улсын нууц явдаг.

Үүнийг чинь бид парламент дээр ил тод ярьж байх ёстой шүү дээ. Улсын хөрөнгө оруулалтыг. Үүнийг чинь бид татвараар мөнгөөр нь аваад улсын төсөв дээрээ өнөөдөр үүнийг ярьж байх ёстой шүү дээ. Гэтэл эсрэгээрээ компанийн зарлага талд аваачиж тавингуутаа нууцлаад. Тэгээд бүтэн хулгай яваад байна шүү дээ.

“Эрдэнэт” гэдэг улсын үйлдвэрийн газраар янз янзын л юм санхүүжүүлээд. Сүүлдээ бүр жорлон хүртэл санхүүжүүлсэн нь үнэн шүү дээ. Бодитой байдал нь. Энэ чинь улсын төсөв санхүүжүүлэх ёстой юмыг яагаад тэр компани санхүүжүүлээд. Болохгүй шүү дээ. Энэ чинь хуулиа зөрчөөд байгаа байхгүй юу. Болохгүй шүү дээ.

Үгүй ээ, тэгээд ийм болохоороо Монгол Улс чинь цаашаагаа нөгөө энд сууж байгаа хүмүүс нь шинэ төсөв ярих ямар ч боломж байхгүй. Сонирхол ч байхгүй. Хөрөнгө оруулалтууд нь тэгээд баахан төрийн өмчийн компаниудаар хийгдээд яваад байх юм бол бид энд юугаа хийж сууж байгаа юм.

Үгүй ээ, парламент гэдэг чинь дэлхий дээр төсвөө батлах гэж л анх удаа үүссэн гээд. Үгүй ээ, тэгвэл энэ парламент чинь бүгдээрээ төсөв ярьдаг байя л даа.

Орж ирэх ёстой орлогуудаа бүгдийг нь авдаг байя. Зарцуулалтаа илэн далангүй ярьдаг байя. Тэгээд ирээдүй рүүгээ чиглэсэн хөрөнгө оруулалт хийхийн тулд алдагдалгүй төсөв баталъя. Тэгэхгүй өнөөдөр хадгаламжаа бид идчихэж байгаа. Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв сан байхгүй. Дээрээс нь Ирээдүйн өв санд оруулдаг нөгөө татварын орлогууд чинь баланс дотроо оруулаад ирчихэж байгаа юм. Ингээд л ерөөсөө байж болох бүх эх үүсвэрүүдийг ингээд оруулж ирсээр байгаад л алдагдал жоохон харагдаад байгаа боловч яг үнэндээ алдагдал чинь өмнөх жилээс өсчихсөн байгаа шүү.

Одоо тэр нөгөө хүснэгтүүдээ харах юм бол тоо нь ийм л байгаа шүү дээ. Үгүй ээ, цаашаа ингээд яваад байх

юм бол энэ парламент чинь төсөв баталж чадахгүй ээ. Төсөвт чинь орон зай байхгүй ээ. Төсөв чинь хөгжлийг санхүүжүүлэх, дэд бүтцийг санхүүжүүлэх ямар ч орон зайгүй болно. Энэ орон зайг гаргахын тулд бид өнөөдөр зогсоогоод алдагдалгүй төсвөө батлаад цаашаа явъя л гэж байгаа юм. Үр дүн нь хэн очих юм. Ирээдүй хожно шүү дээ. Ирээдүй.

Эдийн засгийн үзүүлэлтүүд, тэгээд зээл зэрэглэл тооцдог байгууллагууд чинь хүрч ирээд макро үзүүлэлтүүд чинь хангалтгүй байна. Төсөв чинь алдагдалтай нь гэнгүүтээ үзүүлэлтүүдээ буулгангуут компаниуд чинь өндөр үнэтэйгээр гаднаас зээл аваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь бизнесийг санхүүжүүлэх мөнгө чинь үнэтэй болоод бизнес чинь хумигдаад байгаа байхгүй юу. Энэ чинь болохоороо эргээд эдийн засгаа алж байгаа юм. Ирээдүйгээ алж байгаа. Энд байгаа энэ төсвийн энэ алдагдал чинь халаад байгаа байхгүй юу. Энэ өр чинь ингээд хуримтлагдаад л, хуримтлагдаж явсаар байгаад л үр дунд нь дийлэхээ болиод л дахиад л дефолт болно шүү дээ.

Ийм болохоор одоо үүнийгээ хязгаарлах хэрэгтэй. Тийм болохоор дэмжихгүй байгаа юм. Алдагдалгүй төсөв оруулж ир.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Төсвийн алдагдлын тухай бид өнөөдөр энэ чуулганаар авч хэлэлцэж байна.

Улс орны эдийн засаг манай Засгийн газар, Их Хурал энэ төр барьж байгаагаас шалтгаалахгүйгээр гадаад,

дотоодын нөхцөл байдлаас болж хүнд нөхцөлд орсон энэ цаг үед бас энэ төсвийн алдагдлыг бууруулах талаар Сангийн яам, Засгийн газар дорвитой. Хөнжлийнхөө хэрээр зөв алхам хийсэн гэж би ингэж бодож байгаа юм.

Өнөөдөр бүх хүмүүс энэ Сангийн яам руу, төсөв рүү ерөөсөө муу муухай байна гэдэг ийм юмыг л байнга л нулимж ярьж байна. Гишүүд ч ярьж байна. Хэвлэл мэдээлэл ч ярьж байна. Ард иргэд ч ярьж байна.

Энэ асуудал өнөөдөр ганцхан болсон асуудал биш ээ. Төсвийн алдагдал бол жил жил бүхэн л яригддаг асуудал. Харин ч энэ жилийн төсөв дээр шинэ хөрөнгө оруулалтыг тэвчиж, 10-аас доошгүй жил, олон жил дуусдаггүй тэр хөрөнгө оруулалтын барилгуудыг дуусгах талаар дорвитой шинэчлэл хийсэн. 1.5 их наядын алдагдлыг 1.4 болгож бууруулсан. Ийм юмыг нь бас ярья. Өнөөдөр.

Тийм учраас үүнийг би дэмжиж үг хэлж байгаа юм. Бид өнөөдөр сөрөг хүчин ч бай, эрх баригч ч бай, бодит байдлыг л харгалзаж энэ дээр тохирсон ийм бодлогыг л явуулах ёстой. Түүнээс биш одоо ийм хүнд нөхцөлд энэ Сангийн яам аа, Засгийн газар аа, энэ хөрөнгө санхүүг ээ, алдагдлаа яриад энэ дээр ийм асуудал дээр муу муухай бүхнийг энэ рүү үүрүүлээд нийгэмд ийм сөрөг үр дагавар гаргаад эндээс оноо энэ тэр авна гэвэл бас байж болохгүй асуудал. Байж болохгүй асуудал.

Энэ төсвийн алдагдал манайхаас шалтгаалахгүйгээр гадаад нөхцөл байдал, энэ валютын ханш, энэ хил боомтын асуудал, энэ гадаад Украин, Оросын дайн, дэлхийн эдийн засаг чинь өнөөдөр ийм байдалд орчихлоо шүү дээ. Ийм учраас Төсвийн байнгын хороон

дээр Сангийн яамтай хамтарч бас тодорхой төсвийн алдагдлыг бууруулах, энэ үр дүнгүй хөрөнгө оруулалтыг хязгаарлах. Урьд нь олон жил болсон дуусдаггүй улсын төсвийн хөрөнгө оруулалт нэрээр явагдаж байсан төсөл, хөтөлбөрүүдийг энэ 2023, 2024 онд дуусгах ийм шийдвэр гарсан нь бас цаг үе олсон асуудал гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Сайн сурцгаагаарай. /алга ташив/

“Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтоно.” гэж байгаа юм.

Одоо ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. /Алх цохив/

Ш.Адьяаа гишүүн ээ. Та чинь дэмжихээд одоо тэгээд саналаа өгөхгүй энд явж байдаг. Юу хийж яваа юм.

53.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

С.Чинзориг гишүүний хажуудаа сандалд суулгаад ав.

5.Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2023 онд “5,347.3 тэрбум төгрөг” гэснийг “5,359.7 тэрбум төгрөг” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.5 хувийн хувиар энэ санал дэмжигдлээ.

6.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ 2023 онд “1,999.0 тэрбум төгрөг” гэснийг “1,961.2 тэрбум төгрөг” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2023 онд “3.7” гэснийг “3.6” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /Алх цохив/

62.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хоёрт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Эрхэм гишүүн Цэндийн Сандаг-Очирыг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хийлээ.

Засгийн газраас Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт **101** хууль, Улсын Их

Хурлын **6** тогтоолын төслийг өргөн мэдүүлснээс анхны хэлэлцүүлгийн шатанд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаасан, түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх хугацааг түр хойшлуулах горимын санал дэмжигдсэн тул нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудыг нийт **99** хуулийн төсөл, Улсын Их Хурлын **6** тогтоолын төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Нэгдсэн хуралдаанаар дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтын уялдааг хангаж гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу зарчмын зөрүүтэй **1** саналын томъёоллыг бэлтгэн санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үед Гүйцэтгэх засаглалын хяналтын тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга

хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн холбогдох зүйл, заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул зарчмын зөрүүтэй 6 саналын томъёоллыг бэлтгэн санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Байнгын хорооноос эцсийн хувилбарын төсөл, зарчмын зөрүүтэй саналын томъёолол, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 99 хууль, Улсын Их Хурлын 6 тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн, хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.
Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн.

Нөхөр Бямбарагчаагийн Тэлмүүн Татварын бодлогын газрын ийшээ суу. Хоцорч ирчихээд чи яагаад дээшээ гараад суучихсан юм.

Барсүрэнгийн Баасандорж ийшээ суу. Мэргэжлийн хяналтын газрын дарга.

Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамнаас Барилгын хөгжлийн төвийн захирал Цэрэндоржийн Амарсанаа байна уу? Алга байна. Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын хэрэгжилт зохицуулалтын газрын дарга Доржпаламын Гантулга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Галбадраагийн Батбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Батсүхийн Элбэгзаяа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга Чойжилсүрэнгийн Ариунхур алга байна.

Одоо Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Ц.Даваасүрэн. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Уг нь одоо эцсийн хэлэлцүүлэг учраас Байнгын хорооноос асууна. Уг нь Байнгын хорооноос биш. Би бол Барилга, хот байгуулалтын яамнаас л асуумаар байгаа юм л даа.

Өнгөрсөн жил төсөв батлахдаа Их Хурал тогтоол гаргаж батлаад энэ барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой асуудлаар тодорхой чиглэл өгсөн тогтоол Их Хурлын тогтоолд орсон. Энэ тогтоолын дагуу барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор төсөвт өртөгт өөрчлөлт орж, 2023 оны төсөвт 300 гаруй тэрбум төгрөг тусаж л байна л даа.

Гэхдээ энэ дотор бас нэг алдаа гарсан байгаа юм. Барилга хот байгуулалтын яам ялангуяа энэ Барилгын хөгжлийн төвийнхөн барилгын компаниуддаа буруу ойлголт өгсөн юм уу, өөрсдөө юм аа ойлгоогүйгээс чинь болоод 2023 оны төсөв дээр барилгын материалын үнийн өсөлт нь суулгаж чадахгүй хоцорч байгаа маш олон аж ахуйн нэгж, байгууллагууд үлдчихлээ шүү дээ. Үүнийг Барилга, хот байгуулалтын яам юу гэж үзэж байгаа юм?

Их Хурлын тогтоол гаргахдаа барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор магадлан хийлгэж, төсөвт өртөгт нь өөрчлөлт оруулахаар асуудлыг Их Хуралд оруулж ир ээ гэдэг гэсэн шийдвэр гаргасан. Энэ нь орсон.

Нэг хэсэг газрууд нь төсөвт өртөг нь нэмэгдчихсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө төсвийнх нь объём нь ажлын хэмжээний өөрчлөлт ороод төсөвт өртөг нь нэмэгдчихсэн. Үүнийгээ Барилгын яам, Барилгын хөгжлийн төв нь барилгын материалын үнийн өсөлтөд энэ чинь орно гээд аж ахуйн нэгж, байгууллагуудаа тайвшруулж, өөдөөс нь тайлбар хийж явуулсаар байж байгаад нөгөөдүүл нь орох юм байна гэж хүлээж байсаар байгаад одоо яасан гэхээр энэ барилгын материалын үнийн өсөлт биш байна. Төсөвт өртгийн өөрчлөлт байна. Ажлын объём нь нэмэгдчихсэн байна. Ийм төслийг оруулахгүй гээд Сангийн яам 2023 оны төсөв боловсруулахдаа оруулж ирээгүй.

Тэгээд одоо Их Хурлын тогтоол дотор тэр төсөвт өртгийн өөрчлөлттэй холбоотой асуудал дээр аудит хийж байж төсөвт өртөг нь өөрчлөлт оруулах асуудлыг оруулж ир ээ гэдэг ийм асуудал. Ингээд дахиад энэ чинь 2024 он руу маш олон объект шилжчихэж байгаа юм.

Энэ бол үндсэндээ Барилга, хот байгуулалтын яам, энэ Барилгын хөгжлийн төвийнхний хариуцлагагүйтэй холбоотой л гэж би хэлэх гээд байгаа юм.

Та бүхний энэ буруу ойлголтоос болоод тэр орон нутгийн удирдлагуудад, барилгын компаниудад буруу олголт, буруу чиглэл өгснөөс чинь болоод маш олон компаниуд барилгын материалынхаа үнийн өсөлтийг тооцуулж чадахгүй, 2023 онд авч чадахгүй. Дахиж төсөвт өртөгтөө аудит хийлгэж байж 2024 оны төсөв дээр үүнийг ярих уу, үгүй юу гэдэг асуудал руу явчихлаа шүү дээ. Энэ хариуцлагыг хэн хүлээх юм?

Манай Өвөрхангайтай холбоотой яг ийм асуудлаас болоод үнийн өсөлт нь орохгүй хоцорч байгаа 7, 8 объект байгаа. Тэгээд яасан гэхээр Барилгын яам дээр ярихгүй байсан юм, Барилгын хөгжлийн төвтэй ярихгүй яасан юм гэхээр Барилгын хөгжлийн төвтэй зөндөө уулзсан. Энэ төсөвт өртгийн өөрчлөлт ч гэсэн энэ үнийн өсөлт мөн. Яг адилхан орно. Магадлан хийсэнтэйгээ адилхан хүчин төгөлдөр авч авч үзнэ. Үнийн өсөлт орно гэж хэлсээр байж байгаад тэгээд маш олон аж ахуйн нэгж, байгууллагууд чинь хоцорчихлоо шүү дээ.

Тэгээд үүнийг чинь дагаад маш олон хөрөнгө оруулалтын ажил царцах нь. Хөдөө орон нутагт хийгдсэн сургууль, цэцэрлэг ашиглалтад орохгүй ингээд дахиад нэг жилээр хүлээгдэх болчихлоо шүү дээ. Ийм хариуцлагагүй асуудлууд гарсан шүү.

Тэгэхээр Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв үүнийг юу гэж үзэж байгаа юм. Яагаад ийм буруу бас тийм ойлголт өгөөд, чиглэл өгөөд яваад байсан юм. Үүнээс чинь болоод маш олон барилгын компаниуд чинь ирэх жил үйл ажиллагаа нь зогсох нь байна шүү. Маш олон объектууд ашиглалтад орохгүй царцсан барилгын тоо нэмэгдэх нь байна шүү. Ингээд 2024 оноос наашгүй боллоо шүү дээ. Энэ хариуцлагыг хэн хүлээх юм? Би бол одоо энэ Барилгын сайдаас, Барилга хөгжлийн төвийн дарга нараас асуумаар байгаа юм л даа.

Г.Занданшатар: Барилгын яам. Төсвийн байнгын хороон дарга. Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр таны хөндөж байгаа энэ асуудал ер нь зүгээр том зургаар нь харж авч үзэх юм бол энэ ерөөсөө төсвийн сахилга баттай холбоотой асуудал.

Тэгэхээр бид ер нь зүгээр сүүлийн 10 жилийн хугацаанд тодорхой хэмжээнд сахилга бат, хяналтгүйгээр их хэмжээний зардлуудыг улсын төсөвт төлөвлөдөг, их хэмжээний барилга, байгууламжуудыг улсын төсвөөр хийх гэж оролддог. Үүнээс болоод яг үндсэндээ энэ жил болоод дараагийн жилүүдэд энэ хөрөнгө оруулалтын ачаалал төсөв дээр асар ихээр ирж байгаа. Энэ жил бид улсын төсвөөс 2.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс хийж байна. Шинэ орон хөрөнгө оруулалт хийхгүй ч гэсэн өмнөх онуудад хуримтлагдсан, өмнөх онуудад төсөвлөгдсөн энэ хөрөнгө оруулалтуудыг ядаж дуусгах, тодорхой санхүүжилтүүдийг шийдвэрлэх асуудлуудыг оруулж өгч байгаа.

Дараа жил ч гэсэн 1.5 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа. 2025 онд 300 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа.

Тэгэхээр бид энэ асуудал дээр том зургаар нь үнэлэлт дүгнэлт өгч, цаашдаа ер нь төсвийн сахилга бат, хариуцлагаа бас нэг зөв болгох, хариуцлагатай байх, олон жилд энэ хөрөнгө оруулалтуудыг хувааж төлөвлөдөггүй байх энэ зохицуулалтуудыг хийх зайлшгүй шаардлагатай байгаа.

Яг үндсэндээ 2021 оноос хойш, КОВИД-той он жилүүдээс хойш 2023 он хүртэлх энэ жилүүдийн хооронд олон мянган барилгын аж ахуйн нэгж, байгууллагууд, хувийн хэвшлийнхэн энэ төсөвт өртгийн нэмэгдлээс болоод асар

их хэмжээний алдагдал хүлээхээр байгаа. Банкны барьцаа, хүү зээлд боогдохоор байгаад байгаа.

Тэгэхээр энэ бол нэг талдаа тогтолцоо болоод, нэг талдаа эрх зүйн алдаа оноо, хуулийн цоорхойтой холбоотой асуудлууд байна гэж харж байгаа.

Барилгын материалын энэ үнийн өсөлт болоод төсөвт өртгийн нэмэгдэлд үндсэндээ 4 зүйл нөлөөлж байгаа.

Нэгдүгээрт, барилгын материалын үнэ өсөлт буюу сая сүүлийн хоёр жилийн хугацаанд нэмэгдсэн нийт 30-аас 40 хувиар нэмэгдсэн барилгын материалын үнмшилтэй холбоотой асуудал. Үүнтэй холбоотой бид магадлан хийж 303.4 тэрбум төгрөгийг энэ оны улсын төсөв дээр тусгасан байгаа.

Тэгэхээр 4 асуудлаас нэг асуудлыг шийдэж байна гэсэн үг. Цаана нь үлдэж байгаа үндсэндээ бид бас нэг анхаарах ёстой асуудлууд бол машин механизмын зардал болоод тээврийн зардал, цалингийн зардлууд байгаа юм.

Тэгэхээр эдгээр асуудлууд цааш цаашдаа дараа жилүүдийн төсвүүд дээр төсөвт өртгүүд нь нэмэгдээд орж ирэх энэ эрсдэлүүд байна гэж харж байгаа.

Үүнээс үндсэндээ бас нэг нөлөөлж байгаа зүйл эрх зүйн шинэчлэх шаардлагатай байгаад байгаа асуудлууд бол бид энэ машин механизмын зардал болоод тээврийн зардал, цалингийн зардлуудын тарифуудыг аль өмнөх олон жилийн өмнөх тарифуудаар тооцдог асуудлууд байгаа юм. Машин механизм, зардал гэхэд одоо бид хуулийнхаа дагуу 2012 оны тарифаар тооцож байна. Тээврийн зардал 2019 оны тарифаар

тооцож байна. Цалингийн зардал 2009 оны тарифаар тооцож байгаа юм.

Тэгэхээр бид энэ асуудлуудыг нэг талд нь шийдэж, цаашдаа ер нь энэ төсөвт өртгийн нэмэгдэл гэдэг юм уу, тухайн тэр инфляц, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн асуудлууд жил тутам инфляцтайгаа уялдуулаад шинэчлэгддэг энэ тарифыг гаргаж ирвэл илүү энэ маргаан бий болгохгүйгээр, цаашид тэрийг бид магадлахгүйгээр, аудит хийлгээд байх шаардлагагүйгээр автоматаар тусгагддаг индексжүүлэх, жил бүрээр нэмэгдээд байдаг энэ асуудлууд орж ирнэ гэж харж байгаа.

Нөгөө талдаа бид тодорхой хэмжээнд мэдээж энэ компаниуд дээр бас хариуцлага гэдэг юм уу, энэ төрийн захиргааны байгууллагууд дээр ч гэсэн тавих хяналтуудаа сайжруулах нь зүйтэй. Тэр саналтай бас санал нийлж байна.

Нөгөө талдаа бид бас том зургаар нь нэг зүйлийг анхаарах ёстой зүйл бол их хэмжээний хөрөнгө оруулалтуудыг, тодорхой дэд бүтцүүдийг, байшин барилгуудыг, магадгүй томоохон бүтээн байгуулалтуудыг төсвийн хөрөнгө оруулалтуудаар хийдэг энэ асуудлуудаа багасгах шаардлага байна гэж харж байгаа.

Бид төсвийн хөрөнгөөр энэ том хөрөнгө оруулалт хийдгийг цаашдаа болиулах ёстой. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль одоо орж ирж байгаа. Төсөв өөрөө чанга байх ёстой. Монгол Улсын эдийн засаг өөрөө жижиг учраас бид хувийн хэвшлээ дэмжих, илүү хувийн хэвшил нь одоо юу гэдэг юм энэ ачааллуудыг аваад явдаг, төрийн ачааг багасгаад явдаг, төсөв дээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэд Сэлэнгэчүүд, Сайханчууд Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо С.Чинзориг гишүүн тодруулж асууя. 1 минут.

С.Чинзориг: Би бол арай өөр юм ярьсан юм. Тэгээд Байнгын хороон дарга их том юм яриад л явчихлаа л даа.

Барилгын материалын үнийн өсөлт гэдэг нэг асуудал. Төсөвт өртгийн өөрчлөлт гэсэн нэг асуудал. Энэ хоёрыг Барилгын яам, Барилгын хөгжлийн төв яг адилхан гэж үзээд Барилгын яам барилгын компаниудаа хуураад явуулаад байсан.

Үүнээс чинь болоод барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой асуудал ороод төсөв өртгийн өөрчлөлттэй холбоотой асуудал чинь орсонгүй ээ. 2024 оноос наашгүй болчихлоо гэж би хэлээд байна шүү дээ. Үүнийхээ учрыг нь олооч ээ л гэж байна.

Хоёр дахь асуудал нь Г.Тэмүүлэн дарга аа, таны ярьж байгаа шиг энэ барилгын материалын төсөвт өртгийн өсөлттэй холбоотой, үнийн материалын

өсөлттэй холбоотой асуудал Та яг таны ярьж байгаа шиг ойлголтоор ярих юм бол наад асуудал чинь дуусашгүй яриа болно шүү.

Одоо тэгээд яах юм. Тэгээд цаашдаа тээврийн өртгийн нэмэгдэл, цалингийн өсөлт, материал, машин механизмын өсөлтийг нь дахин хийх юм уу? Тэгэх юм бол наад барилгын материалын өсөлтийн асуудал гэдэг чинь дуусашгүй яриа болно шүү.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулгад хариулъя. 1 минут.

Г.Тэмүүлэн: Бид энэ барилгын салбарынхантай болоод хувийн хэвшлийнхэнтэй, мэргэжлийн холбоодтой уулзсан. Ерөөсөө үндсэндээ төсөвт өртгийн нэмэгдэл гэж юу юм бэ гэж.

Энэ асуудал дотор чинь дөрөвхөн л асуудал байгаад байгаа юм. Нэгдүгээрт, бараа материалын үнэ. Нөгөөх нь машин механизм, тээврийн зардал, цалин. Энэ дотор нь угаасаа энэ дөрвүүлээ орчихсон байгаа. Энэ дөрвөөс бид энэ удаагийн төсөлт өртгийн нэмэгдлээр барилгын материалын зардлын нэмэгдлийн асуудлыг л шийдэж байгаа юм.

Тэгэхээр дараа дараагийн жилүүдээр орж ирж байгаа, илүү хүлээгдэж байгаа энэ төсөвт өртгийн нэмэгдэл дотор угаасаа энэ цалингийн зардал болоод тээврийн зардал, машин механизмын зардлууд суучихсан байгаа.

Харин хууль эрх зүйн орчин талаасаа бид тарифыг нь тухайн оных нь индексээрээ нэмэгддэг байх энэ шинэчлэлийг хийх ёстой байна л гэсэн саналыг хэлсэн.

Г.Занданшатар: Одоо Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Төсөв дагаж орж ирсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анх орж ирэхэд нь хараад тэгээд зарим нэг зарчмын зөрүүтэй саналыг Төсвийн байнгын хороонд би өгч байсан. Тэгээд миний бие Төсвийн байнгын хороонд байхгүй, ажлын хэсэгт байхгүй учраас бас энэ дээр тодруулаад асуучихъя.

Хамгийн нэгдүгээрт нь орон нутгийн хөрөнгө оруулалтыг хориглосон байсан Улсын Их Хурлын тогтоол анх дагаж орж ирж байсан.

Тэгэхээр үүнийг болиулах, 2023 онд орон нутаг хөрөнгө оруулалт хийх боломжоор хангах талаар энэ оруулж ирсэн хориглосон заалтыг хүчингүй болгуулахад санал өгч байсан. Энэ одоо яаж тусгаж орж ирж байгаа вэ?

Дараа нь Төрийн албаны хуульд зөвхөн “ТЗ”-д орон нутгийн нэмэгдэл олгож болохоор орж ирсэн байсан. Тэгээд миний бие бас төрийн үйлчилгээний, орон нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээний албан хаагчдад бас орон нутгийн нэмэгдэл олгох эрхийг нь нээгээд өгчихөөч ээ гэдэг санал өгч байсан. Энэ яаж шийдэгдэж байна вэ?

Мөн зарим гишүүдийн хамт бас миний бие санаачилсан сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын таван жилийн урамшууллын асуудал энэ ирэх оны төсөвт орж ирж сууж байгаа юу гэдэг нэг асуулт байгаа.

Дараа нь энэ Засгийн газар дахь хяналтын хууль бий болж байгаатай холбоотойгоор мэргэжлийн хяналтын

байгууллага татан буугдаж байна. Тэгээд хэчнээн хүн нь бусад байгууллагууд руу шилжээд, хэдэн хүн нь цомхотголоор ажилгүй болж байна вэ? Энэ үлдэж байгаа улсууд нь яамдууд руугаа яваагүй улсууд нь энэ Засгийн газрын дэргэд байгуулагдах агентлаг руу шилжиж орж ажиллаж байгаа юу гэдэг нэг ийм асуудал тодруулмаар байна.

Дараа нь энэ төсвийг дагаад 2024 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл гээд энэ Ерөнхий сайд аймгуудаар явахдаа амласан зүйлүүдийг Улсын Их Хурлын тогтоол болгоод Засгийн газарт үүрэг өгсөн ийм тогтоол байсан. Тэгээд Өмнөговь аймагт очоод Ерөнхий сайдын амласан ажлууд бас энэ дотор туссан байсан. Тэгээд энэ асуудлууд яаж явж байгаа вэ? Улсын Их Хурлын тогтоол энд явж байгаа юу, үгүй юу? Хасагдсан уу гэдэг нэг ийм таван асуудал дээр хариу авъя.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн. Төсвийн байнгын хорооны дарга.

Г.Тэмүүлэн: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр бид бүхний хувьд энэ “2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг оруулсан. Үүн дотроо таны асууж байгаа саяын энэ орон нутаг, бүх шатны орон нутаг тодорхой хэмжээнд өөрсдөө тодорхой олсон орлогоороо захиран зарцуулах энэ эрхийг нь нээх асуудлууд бас тодорхой хэд хэдэн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүдээс санал болгож гаргаж ирж байсан.

Тэгэхээр бид энэ тогтоолын төсөлд байсан 2.3 дахь заалтыг хассан байгаа. Тэгэхээр одоогоор ямар нэг байдлаар хязгаарлалт байхгүй гэсэн үг.

Монгол Улсын хувьд нийтдээ улсын төсөвт орлого бүрдүүлдэг, өөрөө өөрсдийнхөө төсвийг бүрдүүлээд явдаг ийм 6, 7 аймгууд байгаа.

Тэгэхээр бид энэ аймгууд дээр ч гэсэн тодорхой хэмжээнд орлого олж байгаа түүнийгээ захиран зарцуулах эрхийг нь хааж боох шаардлага байхгүй гэдэг асуудлыг тогтсоны үндсэн дээр ажлын хэсэг дээрээ ярилцаж хийж Байнгын хороогоор энэ асуудал дэмжигдээд ингээд хасагдсан гэдгийг танд хэлэх байна.

Саяын төрийн захиргааны албан хаагч нартай холбоотойгоор нийтдээ орон нутагт ажиллаж байгаа 20 мянга орчим хүн байгаа. Төрийн захиргаанд ажиллаж байгаа. Эдгээр хүмүүс дээр орон нутгийн нэмэгдэл буюу 20 хувийн нэмэгдэл тусаж байгаа. Энэ Төсвийн тухай хууль дээр суусан. Нийтдээ 34 орчим тэрбум төгрөг үүнд тусгагдаж байгаа.

Саяын төрийн үйлчилгээний албан хаагч нар буюу цаана нь үлдэж байгаа нийт 34 орчим мянган төрийн үйлчилгээний алба хаагч нар орон нутагт байгаа юм. Үүн дотроо боловсрол дээр 17.4 мянга, эрүүл мэндийн салбар дээр 4 мянга, соёлын салбарт 1.2 мянга. Бусад юун дээр 11 мянган төрийн үйлчилгээний албан хаагч нар буюу нийтдээ 34 мянган төрийн үйлчилгээний албан хаагч нар байгаа.

Улсын Их Хурлын тодорхой зарим гишүүдийн зүгээс төрийн үйлчилгээний албан хаагч нар дээр мөн

бас ялгаварлахгүйгээр орон нутгийн нэмэгдэл буюу 20 хувийг шийдэж өгөх саналыг дэвшүүлж байсан. Бид энэ асуудлыг судалж үзсэн. Нийтдээ 73 тэрбум төгрөг шаардлагатай байгаа юм. Эхнээсээ Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр энэ орж ирээгүй байсан. Бид энэ удаагийн төсвийн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэх орон зай тодорхой хэмжээнд гаргаж чадаагүй.

Тэгэхээр үүнийг үе шаттайгаар дараа дараагийн төсвийн хүрээнд шийдвэрлээд явъя гэсэн энэ бодлогыг баримталсан гэдгийг хэлэх байна.

Мөн саяын Улсын Их Хурлын тогтоол буюу 2023 оны төсөв Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд байсан. Монгол Улсыг 2024 оны төсвийн төсөлд тусгаж үе шатад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт гээд нийтдээ 15 төсөл, арга хэмжээ байсан. Үүн дотроо Өмнөговь аймагтай холбоотой саналууд дотор Өмнөговь аймгийн Баяндалай, Гурвантэс чиглэлийн 80 километр хатуу хучилттай авто зам. Мөн дээрээс нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд ахмадын сувиллын барилга, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эхо аппарат гэсэн ийм гурван асуудал 15 төсөл, арга хэмжээнд туссан байсан.

Тэгэхээр бид 2023 оны төсвийг ярьж байгаа учраас, 2023 оны төсвийг хэлэлцэж баталж байгаа учраас 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт буюу түүнийг хэрэгжүүлэх асуудал дээр тодорхой чиглэл гаргасан тогтоол гаргаад байх шаардлага байхгүй. Үүнийг Засгийн газар өөрөө өөрийнхөө ой санамжид аваад Засгийн газрын тогтоол, захирамж, шийдвэрээ гаргаад хэрэгжүүлэх энэ эрх нь нээлттэй гэдэг асуудлыг орхисон.

Тэгэхээр бид энэ үндсэн дээрээ 2023 оныхоо төсвийг хэлэлцэж байгаа үүднээс 2024 оны төсвийн төсөлд тусгах энэ жагсаалтыг хассан гэдгийг танд албан ёсоор хэлэх байна.

Г.Занданшатар: 87.
Барсүрэнгийн Баасандорж. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга.

Б.Баасандорж: Б.Баасандорж
Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Үүнтэй холбоотой салбарын нийтдээ 83 хуульд өөрчлөлт орж байгаа. Яг мэргэжлийн хяналт буюу бизнес эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд рүү шилжсэн, шилжиж байгаа хөндлөнгийн хяналт тавьдаг манай 1200 байцаагч, яг салбар салбар луугаа орон нутаг, нийслэл, яам, төрийн захиргааны байгууллага гээд энэ 1200 байцаагч шууд автоматаар салбар салбарынхаа хяналтыг тавихад салбар луугаа шилжинэ.

Манай мэргэжлийн хяналтын байгууллага өөрөө 1500 гаруй албан хаагчтай.

Тэгэхээр 200 гаруй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч нарын асуудал яригдана. Жишээ нь, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга, Тамгын дарга, санхүү, 21 аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нар гээд. Энэ хүмүүсийн асуудал Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэгдэнэ. Хууль тогтоомжийн дагуу.

Өөрөөр хэлбэл тухайн орон нутагтаа, нийслэлдээ ажлын байраар хангах асуудлыг нэгд тавина. Хэрвээ үнэхээр ажлын байр хомс байвал яг тэр 62 дугаар зүйлд заасан журмын дагуу яригдана.

Та сая асуулаа. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гэж шинэ төрийн захиргааны байгууллага бий болж байгаа. Энэ байгууллагын бүтэц, орон тоо, дүрмийг орон тооны хязгаарыг Засгийн газраар батлагдана. Энэ бол мэргэжлийн хяналт биш, захиргааны хяналт тавьдаг өөр чиг үүрэгтэй байгууллага байгаа.

Ийшээ шууд автоматаар шилжиж ажиллах асуудал яригдахгүй. Гэхдээ үнэхээр ажлын байраар хангах асуудлын хүрээнд Засгийн газрын түвшинд шийдвэрлэгдэх асуудал учраас би урьдчилж тэр дээр үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Болсон уу?
Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Би хоёр асуудал Байнгын хороон дээр тавьсан байгаа.

Эхний асуудал бол Их Хурлын тогтоол өрийн баталгаа гаргахтай холбогдолтой асуудал байгаа.

Энэ Хөгжлийн банкны ирэх онд төлөгдөх өрийг Засгийн газрын өрийн баталгаа гаргаж төлье гэж байгаа юм. Тэгээд одоо энэ батлагдах тийшээгээ болж байна л даа.

Энэ бол зээл төлөхгүй байх тийм сонирхлыг л бий болгоно. Тэр тусмаа нийгэм юу гэж харах вэ. Улс төрчид нь одоо ингээд янз бүрийн хүмүүсээ

томилж байгаад ингээд зээл авчихдаг юм байна. Нөлөө бүхий компаниуддаа. Тэгээд эд нар нь төлдөггүй юм байна.

Ер нь ажлын хэсэг харж байхад ер нь тийм л юм байна лээ л дээ. Тэр хорин хэдэн компани бид шалгуулахаар өгсөн байгаа шүү дээ. Харахад ардаа дандаа уяатай. Нийгэмд ийм зүйл ажиглагдана. Тэгээд одоо үүнийг ингээд л батлуулж гаргах юм байна.

Нөгөө талаараа энэ Засгийн газрын баталгаа, энэ өрийн чинь асуудал өнөөдөр асар өндөр хүүтэй гаднаас мөнгө босгоно. Одоо та нар **Bloomberg** рүү ороод үзэх юм бол Засгийн газрын бондын өгөөж чинь бараг 40 хувь хүрчихсэн байгаа шүү дээ. 40 хувь хүрчихсэн байгаа. Ийм л өндөр хүүтэй бонд гаргаж нөгөө зээлийг чинь зээл авсан улсууд нь төлөх биш Монголын төр баталгаа гаргаж төлөх болж байгаа байхгүй юу. Тэгээд одоо Их Хурал нь үүнийг ингээд батлах гээд байж байдаг.

Хоёрдугаарт, би тэр нэг 10 их наядын хөтөлбөр гээд. Тэгээд одоо арилжааны банкнуудад зээлийн хүүгийн зөрүү гэж олгоод байгааг тодорхой болго гэсэн шүү дээ. Янз бүрийн мэдээлэл ирж байгаа. Би нягтлаагүй учраас одоо хэлэхэд бас тийм оновчтой биш байх гэж бодож байна.

Ер нь бас л улс төрчид нь арилжааны банкнуудаас зээл аваад хүүгийн зөрүүд бас одоо энэ 60.0 тэрбум төгрөгөөс авах ийм магадлалууд байна гэж би ингэж хараад байгаа юм. Ийм яриа ч байна.

60.0 тэрбум гэдэг бол хуучин жижиг, дунд үйлдвэрийн сангийн нэг жилийн санхүүжилт байсан. Одоо нэг жилийн санхүүжилтийг бид тэр арилжааны банкнуудаас авч байгаа

компаниудын хүүгийн зөрүүнд өгч байна шүү дээ. Жилийн 3 хувийн хүүтэй авч байгаа тэр компаниуд. Гэтэл улс төрч очоод 3 хувийн хүүтэй аваад зөрүүгийг нь энэ 60.0 тэрбумаас төлүүлж байгаа бол энэ байж болохгүй зүйл.

Тийм учраас би тэр Их Хурлаас гарах тогтоолд, Г.Тэмүүлэнд би хэлсэн шүү дээ. Заавал үүнийг тодорхой шалгууртай болго. Экспортыг дэмжих чиглэлд, эсвэл импортыг орлох гэдэг юм уу ийм болгоод. Тэгээд ер нь энэ асуудлыг нэг шалга. Ажлын хэсэг гаргаад. Хэрвээ би ахлаад ажиллая гэвэл бэлэн байна.

Үүнийг ер нь нэг үз. Энд гарч байгаа дэл сул яриаг нь нягталж үзэх хэрэгтэй. Энэ чинь асар их мөнгө байхгүй юу даа. 60.0 тэрбум. Би хэлээд байна шүү дээ. Жижиг, дунд үйлдвэрийн сан ийм хэмжээний санхүүжилтийг хийдэг байсан. Нэг жилдээ. Одоо бол тэр мөнгийг бид яадаг болсон. Зөвхөн хүүгийн зөрүүнд өгдөг болсон. Хүүгийн зөрүүнд. Ямар шалгуураар тэр компанид өгөөд байгаа юм.

Тэгээд эдийн засаг нь сайжирч байгаа юм байна уу. Экспортын орлого нэмэгдэж байгаа юм байна уу. Байхгүй. Улам л юмны үнэ өсөөд л, улам л амьдрал доройтоод байна шүү дээ. Хэрвээ үр дүнгээ өгч байгаа энд надад ярих юм алга.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг нарын урилгаар Баянгол дүүргийн “Эрдмийн Өргөө” сургуулийн “Тусгал” мэтгэлцээний клубийн сурагчид Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Энэ жил **“Өсвөрийн парламент”** хөтөлбөрийн хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилго, Уур амьсгалын өөрчлөлт, Үндсэн хуулийн боловсрол чиглэлээр улс орон даяар ерөнхий боловсролын сургуулиудын дунд мэтгэлцээний тэмцээн зохион байгуулж байгаа. Шалгарсан сурагчийг бас шалгаруулж сурах бололцоогоор хангахаар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж, зарлаж байгаа гэдгийг Та бүхэндээ бас мэдэгдье.

Одоо асуултад хэн хариулах вэ? Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Төсвийн байнгын хороон дарга хариулъя.

Г.Тэмүүлэн: Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр төсөвтэй холбогдуулж Улсын Их Хурлын тогтоолыг өргөн барьсан. Үүнтэй холбогдуулж Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай гээд тогтоол орж ирсэн байгаа. Үүний 2 дугаар заалт дээр Хөгжлийн банкны 2023 онд төлөгдөх хуваарьтай гадаад үнэт цаасны эргэн төлөлтийг дахин санхүүжүүлэх зорилгоор хийх, зээллэх шаардлагатай тохиолдолд Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг Монгол Улсын Засгийн газар зөвшөөрсүгэй гэсэн ийм агуулгатай зүйл, заалт туссан байгаа.

Хөгжлийн банкны зүгээс авч үзэхэд нийтдээ бид бас материалуудыг ажлын хэсгийн түвшинд нягталж үзсэн. Нийтдээ Хөгжлийн банкны зүгээс тодорхой хэмжээнд өмнөх бондуудыг

гаргаж, эдгээр гадаад бондуудын эргэн төлөлтийг яг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулах, эсвэл дахин санхүүжүүлэх боломжгүй зайлшгүй тохиолдолд Засгийн газрын зүгээс одоо ийм эрсдэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн асуудлыг бас хөндөж энэ танилцуулга дээр тусгаж оруулж өгсөн байсан.

Бид энэ асуудал дээр таны саналыг бас хүлээж авсан. Яг энэ дээр тодорхой шалгуур шаардлагыг тавих, тодорхой хэмжээнд бүр энэ асуудлуудыг нягталж, тодорхой гарц шийдлүүдийг гаргах ёстой гэдэг асуудлуудыг тавьж байсан. Мөн дээр нь гишүүд ч гэсэн ер нь цаашдаа энэ зээлийн асуудлуудыг бодит эдийн засгийн салбарт шилжүүлдэг байх, боловсруулах салбар болоод тэр дандаа хөдөө аж ахуйн салбарт шилжүүлэх гэдэг асуудлыг тавьсан.

Тэгэхээр бид энэ 11 сарын сүүлээр төсвийн шинэчлэлийн хүрээнд ил тод байдал болоод хяналттай холбогдуулаад тодорхой хуулийн төслүүдийг өргөн барихаар бэлтгэж байгаа. Үүн дотроо ч гэсэн саяын энэ асуудалтай холбогдуулж ер нь Төсвийн байнгын хороо өөрөө нягталж үзэх. Үүн дээрээ дагалдуулж хуулийн төслийг өргөн барья гэсэн ийм төлөвлөгөөтэйгээр ажиллаж байгаа гэдгийг танд хэлэх байна.

10 их наядын төлөвлөгөөний хүрээнд 2021 онд 2 их наяд төгрөгийн зээлийг банкуудын эх үүсвэрээр олгосон. Энэ зээлийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөг байгаа бөгөөд зээлд олгох хүүгийн дотаци нь энэ 9 сарын 30-ны байдлаар зээлийн чанар нь 98.8 хувьтай байгаа гэсэн мэдээллийг ирүүлсэн байгаа.

Яг эхний 73.7 тэрбум төгрөгийн хүүгийн дотаци ажлын байрыг дэмжихэд зориулагдсан. Гол шалгуур нь нь эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлнэ. Жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. НӨАТ төлөгч байх, банкнуудын тавьсан шаардлагыг хангах гэсэн ийм шалгуурууд байсан. Бид үүнийг цаашдаа энэ шалгуур шаардлагуудыг ч гэсэн бас ер нь эргэж харж үзэж, эргээд энэ эдийн засгаа дэмжсэн, бусад энэ салбаруудаа дэмжсэн, бодит салбарт үр өгөөж болох байдлаар зарцуулах асуудлуудыг гаргаж тавих ёстой байх гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууна.

Ц.Даваасүрэн: Яг одоо жишээлбэл ингээд төсөв дагалдаж байгаа тогтоолдоо яг тодорхой ийм шалгууртай бодлого, тийм хугацаатай гэсэн тийм үүрэг даалгавар Засгийн газарт өгсөн заалт байгаа юм уу? Үгүй ээ. Тийм юм өгье л гээд байгаа шүү дээ. Тэгж хэлээд наадах чинь үр дүнтэй болно шүү дээ. Тэгэхгүй бол одоо ингээд баримжаагүй нэг сайхан л арван их наяд яриад суугаад байдаг.

Хэрвээ амьдралд үр дүн нь гараад байгаа бол хамаа алга. Гараад байсан бол юу гэж ингэж юмны үнэ өсөөд байгаа юм. Одоо наадахыг чинь тодорхой болгомоор байна шүү дээ. Тэгж байж дараа нь хариуцлага ирнэ шүү дээ. Тэгэхгүй бол ингээд урсгал байдлаар асар их мөнгийг ингэж хүүгийн зөрүүнд олгож ингэж болохгүй. Яг тодорхой чиглэлтэй болгох хэрэгтэй.

Би бол энэ мөнгийг хасья гэсэн шүү дээ. Хасья. Харин бараг одоо тэр жижиг, дунд үйлдвэрээрээ банкаар

дамжуулаад явуулбал ч илүү байж магадгүй. Тэгэхдээ бүр тодорхой.

Экспортыг дэмжих гэж байгаа бол яг ийм ийм чиглэлийн экспорт дээр. Хөдөө аж ахуйд бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хороо л хариулна л даа. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Энэ дагалдах хуулийн төсөл дээр нэг зөв заалт орж ирж байгаа нь энэ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох.

Тэгээд экспортод гаргах болон нууцын зэрглэлд хамаарах, худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулна гэсэн нэг ийм заалтыг дэмжиж байгаа. Тэгэхдээ одоо бид нар Улсын Их Хурал дээрээ Монгол Улсын түүхэнд гарч байсан хулгай дотроос хамгийн том хулгай бол нүүрсний хулгай юм гэдэгт бүгдээрээ нэг ойлголттой байгаа байх.

Тэгээд Улсын Их Хурал дээрээ яг ямар байдлаар бид энэ дээр хандах юм бэ. Ямар түвшинд яаж ярих юм. Засгийн газар болохоороо онлайн цахим бирж байгуулна. Тэгээд боомтынх нь үнээр зардаг байна гэсэн ийм мэдэгдлүүдээ хийчихлээ.

Улсын Их Хурал маань яах юм? Энэ холбогдох Байнгын хороод маань ямар байр суурьтай байгаа юм?

Одоо зөвхөн нүүрсээр дундын зуучлал байхгүйгээр шууд зарах асуудал гэхээсээ илүү цаана чинь илүү том асуудал юу вэ гэхээр тэвэрлэлт байна шүү дээ.

Саяхан би яг ингээд тээвэрлэж байсан хувийн секторын хүмүүстэй уулзаад мэдээлэл авахад тухайлбал 2021 оны 2 сард нүүрсний үнэ 500-гаас 600 доллар болоход нэг тонн нүүрсийг тээвэрлэх зардал 400 доллар байсан гэж.

Төмөр зам тавьсан бол бид 8-хан доллароор үүнийг тээвэрлэх боломжтой гэж байсан бол ердөө 30 километрийн зайнд богинын тээвэр гэж ярьдаг. Энэ тээвэрлэлтийн нэг тонн нүүрсний үнэ 400 доллар болсон байна шүү дээ. Нөгөө баахан бөмбөлөг гээд л ингээд.

Тэгээд бид нар чинь одоо мэдээлэл байхгүй шүү дээ. Ийм том хулгай яваад байна шүү дээ.

Тэгээд нүүрснийх нь өөрийнх нь үнэ нь 100 доллароос доошоогоо 60, 70 доллар байж байхад 30 километрт нэг тонн нүүрсийг 400 доллароор тээвэрлэж байсан байна гэдэг ийм мэдээлэл ирээд байна.

Тэгэхээр энэ мэдээллийг бид хаанаас баримт баталгаажуулах вэ? Энэ мэдээллийг нөгөө **OFFTAKE** гэрээнүүдээ ил болгоё гэсэн энэ санаачилга маань хаана явж байна? Улсын Их Хурал маань энэ дээрээ анхаарал тавих юм уу, тавихгүй юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгмөөр байна.

Тэгээд хоёрдугаарт энэ чинь. Та нар бод л доо. Чиргүүлтэй 2 машин 4 чингэлэгтэй. Тэгээд нэг машины зардал нь болохоор 60 мянган доллар байгаа байхгүй юу. Хоёр удаа эргэчих юм бол 120 мянган доллар. Хоёр удаа л 30 километр нүүрсээ зөөчих юм бол машинаа ав гэдэг ийм тохироогоор явсан байна.

Тэгээд нүүрсний асуудлаас гадна тээвэрлэлтийн ийм том хулгай явж байна шүү дээ. Ийм өндөр. Тэгээд үүнийг хэн ч мэддэггүй. Ямар ч мэдээлэл гаргадаггүй. Тэгээд өчигдөр гэхэд тухайлбал Боомтын түр хороон дээр ийм мэдээлэл бас өгөөгүй юм байна. Тэгээд үүнийгээ бид нууц бол нууцаас нь гаргаж байгаад ярих хэрэгтэй. Үнэхээр нууцлах гээд байгаа бол ядаж Их Хурал дээрээ ярьж байгаад энэ асуудлаа шийдэхгүй бол болохгүй нь ээ. Монгол Улс хөгжихгүй нь ээ. Хулгайгаа дийлэхгүй юм байна. Үнэхээр боломж алга.

Нэгхэн тонн нүүрсийг 400 доллароор зөөхөөр чинь одоо яах юм бэ энэ чинь.

Тэгэхээр чинь энэ чинь одоо нөгөө төмөр замыг тавиулахгүй байсан сонирхлууд чинь бүгдээрээ ингээд нэгдчихсэн. Бүгдээрээ машинтай. Эсвэл зарим нь ингээд вагонтой. Тэгээд л тэрүүгээрээ ингээд л ашгаа болохоороо тээвэрлэлтээсээ аваад байсан гэдэг ийм ойлголт ирж байгаа байхгүй юу.

10 жил ингээд явчихжээ. Одоо үүнийгээ бүгдээрээ Их Хурал дээрээ ярья. Авлигатайгаа дорвитой тэмцье. Энэ дээр Байнгын хороо тодорхой мэдээлэл өг өө.

Г.Занданшатар: Г.Тэмүүлэн гишүүн хариулъя. Т.Доржжан гишүүн жоохон мэдээлэлгүй байх шиг байна. Боомтын хянан шалгах түр хороо яагаад. Нүүрс бүгд шалгаад явж байгаа шүү дээ. Манай хяналт шалгалтын ажлын хэсгүүд. Үүний чинь үр дүнд бас илэрч байгаа шүү дээ.

Г.Тэмүүлэн: Төсөвтэй холбогдуулж дагалдаж гарах тогтоолын төсөл дээр бид энэ төрийн өмчийн

компаниудтай холбоотой, төрийн өмчийн компаниудын санхүү, энэ үйл ажиллагааны сахилга бат, хяналт хариуцлагыг сайжруулах үүднээс энэ ил тод байдал, нээлттэй байдлыг нь дээшлүүлэх үүднээс гурван заалтыг оруулж ирсэн.

Үүн дотор би онцолж хэлэх гээд байгаа гол онцлох зүйл маань юу вэ гэхээр ерөөсөө төрийн өмчийн компаниудын ер нь энэ мэдээллийг ил тод байлгах, олон нийтийн хараа хяналтад байлгах, олон нийт илүү энэ мэдээлэлтэй нь танилцах эрхийг нь нээж өгөх үүднээс төрийн өмчит компаниудын нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг нь бий болгоё гэдэг асуудлыг тавьж өгч байгаа. Тавьж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ бол татварын нэгдсэн системээс тусдаа нэг асуудал. Бид хоёр асуудлыг гаргаад тавьж байна.

Нэгдүгээрт нь, төрийн өмчийн компаниуд мэдүүлгийн шинж чанартайгаар нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгоод тэр дотроо заавал оруулах ёстой мэдээллүүдээ оруулдаг байя. Энэ бол худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөц. Тэгээд дээрээс нь харилцан хамааралтай болон сонирхлын зөрчил бүхий этгээдүүдийн хийгдэж байгаа хэлцлүүд байна уу, гэрээ контрактууд байна уу, өр авлага нь байна уу, захиран зарцуулалт нь байна уу, энэ бүх мэдээлэл болгон нээлттэй байршдаг байя гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Олон улсад Та бүхэн бүгдээрээ мэднэ. Ийм сайн жишгүүд байдаг. Төр нь өөрөө үүнийг дэмжээд байдаг. Канадын www.sedar.com гээд байгаа. Америкийн **EDGAR**[Electronic Data Gathering,

Analysis, and Retrieval] гэж байгаа. Японы **EDINET**[Electronic Disclosure for Investors' NETwork], Солонгосын **DART**[Data Analysis, Retrieval and Transfer System] гэдэг юм уу. Ийм олон улсын заавал мэдээлэх үүрэг бүхий мэдээллийн мэдүүлгийн системүүд байгаа.

Тэгэхээр бид яг ийм адилхан шинэ дугуй зохиогоод байх шаардлага байхгүй. Үүнийг хийе гэж харж байгаа.

Б.Энхбаяр гишүүн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн ажлын хэсгийг ахалж байгаа. Энэ дээр ер нь үүнийг анхаарч бид энэ системийг Санхүүгийн зохицуулах хороотой хамтраад хийхээр төлөвлөөд явж байгаа. Эхнээсээ ч гэсэн Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр бас эхний ажлыг эхлүүлээд явж байна гэж бид харсан. Мэдээллийг авсан.

Тэгэхээр энэ дээр компаниуд мэдээлэх тэр үүрэг, мэдээллийнх нь тэр оруулах тэр юу гэдэг юм хэлбэрийг нь ч гэсэн бүр тодорхойлж хуульчилж өгөх зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа.

Ингэж байж цаашдаа хувьцаат компаниуд, төрийн өмчийн компаниудын засаглал нь ил тод, нээлттэй байх, олон нийтийн оролцоотой байх, хөрөнгийнх нь тэр хяналтыг нь бид хянадаг байх, ил тод байдлыг нь сайжруулах боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Тэгэхээр энэ бол нэг талдаа гол ач холбогдол их зүйл байна.

Саяын таны хэлсэн уул уурхайн компаниуд, төрийн өмчийн компаниуд. Энэ ашигт малтмал олборлож байгаа бол, тэрийгээ боловсруулж байгаа бол, тэвэрлэж байгаа бол тэр шат дамжлага

бүрд хийж байгаа гэрээнүүд, тэндээс олж байгаа ашиг болгон, зарлага болгон бас ил тод нээлттэй байх ёстой. Үүнийг нь энэ татварын нэгдсэн системд хийе гэж байгаа юм. Энэ бол тусдаа систем юм шүү. Компаниудын нэгдсэн систем. Дээрээс нь татварын нэгдсэн систем. Энэ хоёр дээр бид ер нь төр өөр өөрсдийнхөө авах ёстой татвар болоод орлогынхоо бүх мэдээллүүдийг ил тод бүрдүүлдэг байя гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Манай Д.Цогтбаатар гишүүн бас Төрийн өмчийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох тухай, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн.

Үүнийг бид ойрын хугацаанд хэлэлцүүлж батлах ёстой гэдэг асуудал зайлшгүй шаардлага байгаа. Үүн дээрээс бид ер нь цаашдын төрийн өмчийн компаниудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгож өөрчилье. Хувийн хэвшлийн зонхилох байр суурьтайгаар хувийн хэвшлээ дэмжиж, илүү либерал байдлаар бид энэ зах зээлээ авч явахгүй бол бүх асуудал төрийн өмчийн компаниуд оролцдог. Нөгөөдөх нь менежмент муутай байдаг. Компанийн засаглалыг хэрэгжүүлж чаддаггүй. Үйл ажиллагаа нь доголтой байдаг. Өр зээлтэй байдаг. Энэ нөхцөл байдал дээр бид бодитоор үнэлэлт дүгнэлт өгөөд цаашаа гарч гаргалгаа шийдлээ хувийн хэвшил дээр тулгуурлаад хийх ёстой гэсэн байр суурьтай байна.

Г.Занданшатар: Т.Доржханд гишүүн тодруулж асууя. Байж байгаарай. Эхлээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн болон “Багануур холбооны газар”-ын ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэр өмнөөс ажлын өндөр амжилт хүсэе ерөөе. /алга ташив/

Тогмидын Доржханд гишүүн тодруулъя. 1 минут.

Т.Доржханд: Тэгэхээр энэ нүүрсний хулгай бол дөнгөж эхэлж байна. Нүүрсний тэр том пирамид унаж байна.

Үүнийг Улсын Их Хурал дээр ярилцах хэрэгтэй. Тэгээд Засгийн газрын хувьд 11 сардаа багтаагаад бид **OFFTAKE** гэрээгээ ил болгоно гэдгээ зарлачихсан шүү.

Тэнд Ч.Хүрэлбаатар сайд сууж байна. Та зарласан шүү.

Одоо Улсын Их Хурал дээр үүнийгээ сонсгол хийх хэрэгтэй. Нээлттэй сонсгол.

Бид сая 10-аад жил бараг ингээд төмөр зам байхгүй. Гацаасан хүн нь Халтмаагийн Баттулга Ерөнхийлөгч гэдэг ийм л ойлголттой байтал хажуу талд нь ингээд өө сайхан ингээд баахан машинтай зөөгөөд зөөгөөд явдаг ийм нөхдүүд зөндөө байна шүү дээ. Тэд нар чинь цөм хийсэн байна шүү дээ. Тэгээд хэн ч мэддэггүй. Тэгээд энэ чинь ингээд бүр түвшин түвшиндээ пирамид үүсгэчихсэн юмыг бид Их Хурал дээрээ ярьж байж шийдэхгүй бол энэ хулгай

чинь цаашаага дарагдчих вий. Их Хурал дээрээ зайлшгүй ярих хэрэгтэй.

Тэгэхээр Засгийн газарт чиглэл тодорхой өгөх хэрэгтэй. 11 сардаа багтаагаад асуудлаа танилцуул. Их Хурал дээр нээлттэй сонсгол хий гэж байгаа юм.

Г.Занданшатар: Их Хурал дээр, бүлэг дээр, Байнгын хороод дээр яригдаад л ингээд явсан асуудал даа. Тэгээд ажлын хэсэг хүртэл байгуулагдсан ажиллаж байгаа шүү дээ.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Улсын Их Хурал дээр Засгийн газраас төсөв өргөн барьсны дараахан төсвийн ажлын хэсэг дээр бид яриад орлогыг нэмэгдүүлэх урсгалууд байна гэж үзсэн. Үүний нэг нь жишээлбэл алт, нүүрс, татварын бусад орлого гэсэн. Алт дээр жишээлбэл 17 тонн гэж орж ирснийг 20 тонн болгосноор наад зах нь 30 орчим тэрбум төгрөгийг бас орлого руу татах боломж байна гэж бид үзэж байсан.

Тэгэхээр энэ маань яг бодитоор одоо ингээд суугаад нэгд ороод ирсэн байгаа юу гэдэг дээр.

Хоёрт нь, сая Т.Доржханд гишүүн хөндөөд байна л даа. Гэхдээ ахиц гарч байна. Тийм ээ. Татвар, гааль хоёрыг цахимжуулах, холбох энэ асуудал 2023 оны 01 сарын 01-нээс энэ “Эрдэнэс Тавантолгой” болон хилээр гарч байгаа эрдэнэс бүтээгдэхүүний бүгд цахимжиж, нээлттэй ил тод болно гэхээр нөгөө далд хулгайн замаар ордог тэр нүүрс буцаж орж ирэх валютын урсгал эрс нэмэгдэх, надад тийм дүр зураг зүгээр харагдаж байна л даа. Яагаад гэвэл тэр бүрэн эрхт төлөөлөгчийн сая 14, 20-иод хоног

ажиллахад валютын орж ирж байгаа тоог сая зарлаж байна лээ л дээ. Богино хугацаанд ийм хэмжээний валют орж ирэх бололцоо байна. Үүнээс үүдээд сая валютын нөөц нэмэгдлээ. Өчигдөр Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн нарийн бичгийн дарга байна лээ. Дэд сайд С.Наранцогт хэлж байна лээ л дээ. Өнөөдөр жишээ нь долларын ханш өмнө нь 150-аас 130 төгрөгөөр нэмэгдчихсэн байсан бол өнөөдөр 30-аас 50 төгрөг болж буурлаа гээд.

Тэгэхээр ингэж доороо шууд үнэхээр нөлөө нь үзүүлээд байгаа бол бид яг төсөв батлахаас өмнө бас энэ нүүрснээсээ орж ирэх орлого маань орлого тал дээр нэлээд их хэмжээний давуу боломж олгох дүр зураг харагдаж байна л даа.

Тэгэхээр энэ мэтээ бид хэрхэн яаж бас төсөөлж эцэслэн батлах вэ гэдэг бол чухал асуудал. Тэгээд энэ дээр орлого тал дээрээ нэмэгдүүлэх боломжийг бид бас одоо ингээд эцэслэн батлахаас өмнө бас Их Хурал дээрээ хэлэлцээд тусгах бололцоо байгаа юу гэдэг дээр би Төсвийн байнгын хорооны даргаас байр суурийг нь нэг сонсьё гэж бодож байна.

Хоёрт нь, Эрүүл мэндийн сайд нэг дэх өдөр Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дээр өрхийн анхан шатанд олгогдох төрөөс хариуцан төлөх тэр анхан шатны 223 тэрбум төгрөгийг 2023 оны төсөв дээр нэмж суулгаж байна. Өөрөөр хэлбэл 63 тэрбум төгрөгөөр анхан шатанд олгох төлбөрийг нэмлээ гэж хэлсэн. Гэтэл бид бүлэг дээр ярихад 223 тэрбум төгрөгийг 2023 оны төсөв дээр суух ямар ч бололцоо байхгүй ээ. Ийм зүйл хууль зөрчинө гэж Сангийн яамнаас мэдэгдэж байсан л даа.

Тэгэхээр Эрүүл мэндийн яам нь үнэн яриад байгаа юм уу, эсвэл Сангийн яам нь уу үнэн яриад байгаа юм уу. Бодит байдал Эрүүл мэндийн сайдын багц дээр харахад энэ 67 тэрбум нь нэмэгдээд 223 тэрбум төгрөгөөр төр хариуцан төлөх Эрүүл мэндийн даатгалын энэ шимтгэлийн орлого нь нэмэгдсэн нь харагдахгүй байна л даа.

Тэгэхээр энэ тоонууд маань зөв байхгүй бол бид дараа нь үгүй ээ, одоо Эрүүл мэндийн яамныхнаас та нар чинь өөрсдөө хэлсэн шүү дээ. Эрүүл мэндийн даатгалаас олгох шимтгэлийн орлого 67 тэрбумаар нэмэгдээд 223 тэрбум төгрөг болж өслөө гэсэн. Гэтэл өнөөдөр санхүүжилтээ өгч чадахгүй байна шүү дээ. Тэгээд л дараа нь яг ингээд ярина. Яагаад гэхээр одоо 2023 оны 11 сар болж байхад сая Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид шахаж байж, шаардаж байж бүх гишүүд хэлж байж сүүлийн хоёр сарын гацсан санхүүжилт нь өчигдрөөс эхлээд орж эхэлж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ шалтгаанаа бас л Сангийн яамнаас мөнгө ингээд дусааж дусааж өгөөд байгаа. Тэр хэмжээгээр нь бид бас эмнэлгүүдэд дусааж дусааж тэр санхүүжилтийг нь олгож байгаа гэх мэт нэг сонин утгагүй хариултыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга нь хариулаад сууж байгаа байхгүй юу. Гэтэл тэр хүмүүс хугацаандаа ажлаа хийж байна. Эмч, ажилтнууд цалингаа хугацаандаа авах ёстой. Эмнэлэгт үзүүлж байгаа хүмүүс эмнэлгийн тусламж үйлчилгээг авах ёстой. Төсөвлөсөн мөнгө зориулалтын дагуу зарцуулагдах ёстой.

Тэгэхээр энэ дээр тодорхой хяналтууд хэрэгтэй. Энд нэгдүгээрт бас хариулт авчихъя гэж бодож байна.

Гурав дахь зүйл нь, бид иргэдийнхээ саналыг тусгаад шөнийн цахилгааны тариф 33 тэрбум төгрөгийг Эрчим хүчний сайдын багцад суулгаж чадсан. Ингээд ард иргэдийнхээ саналыг бид ингээд явцын дунд нь тусгаад ингэж хэрэгжүүлж байна. Энд иргэд маань маш их баяртай байгаа. Үүнийгээ би дуулгачихъя гэж бодож байна. Энэ тэгээд Эрчим хүчний сайдын багцтай холбоотой мэдээллийг өгчихөөрэй.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Төсвийн байнгын хорооны дарга.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ удаагийн хувьд Улсын Их Хурлын зүгээс 2023 онд төсөвтэй холбогдуулж төсөв дээр бас тодорхой ажлын хэсгийг гаргаж ажиллуулсан.

Бид бүхний хувьд сая сүүлийн гурван долоо хоногийн хугацаанд ажиллаж, тодорхой асуудлуудыг нягталж, судалж үзэж. Тэр дундаа тэвчиж болох зардлуудыг бууруулах. Мөн дээрээс нь тодорхой хэмжээнд төсвийн зохицуулалтуудыг хийх. Боломжит төсвийн тэнцлийг сайжруулах арга хэмжээнүүдийг авсан.

Үүн дотроо би нэг зүйлийг онцолж хэлэхэд Улсын Их Хурлын зүгээс төсвийн алдагдлыг 127.6 тэрбум төгрөгөөр нэмж бууруулсан. Үүгээрээ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 0.23 хувиар сайжруулсан байгаа.

Төсвийн алдагдал нийтдээ Засгийн газраас өргөн баригдсан төслөөр 1.55 их наяд төгрөгийн алдагдалтай төсвийн төслийг өргөн барьсан. Улсын Их Хурлын зүгээс ажлын хэсэг ажиллаад энэ хүрээнд бид

1.4 их наяд төгрөгийн алдагдалтай болгож тодорхой хэмжээнд бууруулах энэ зохицуулалтыг хийсэн. Хуулиараа төсвийн хүрээний мэдэгдэлдээ төсвийн алдагдлыг 1.9 их наядад нийцүүлэх ёстой байсан.

Тэгэхээр үүнээс нь давуулаад бид 500 тэрбум төгрөгөөр тодорхой зөрүү гарч ирж байгаа. Төсвийн мэдэгдлээс.

Саяын таны хэлсэн тодорхой орлоготой холбоотойгоор, магадгүй тооцооллын зөрүү гарсан, дутуу тооцсон зүйлүүд тодорхой алт тушаалт дээр байсан.

Өмнөх онуудын жишгүүдийг аваад үзэхээр КОВИД-той он жилүүдэд тээвэрлэлт хүнд байсан, бензин түлш хүнд байсан 2020, 2021 онуудад. Энэ оны 2022 оны гүйцэтгэлээс ч гэсэн аваад үзсэн алт тушаалт бол 20 тонноос буугаагүй. Дундаж хэмжээ 20-оос 23 тоннтай байсан. Ирэх онд ч гэсэн ер нь Монголбанканд тушаах алт тушаалтын хэмжээ доод тал нь 20-оос 24 тонн хүрэх боломж бололцоо байгаа. КОВИД-той он жилүүдээс доод тал нь 15 хувиар нэмэгдэх боломж бололцоо байна гэсэн тооцооллыг бид нарт гаргаж өгсөн.

Энэ үндсэн дээр бид ирэх оны төсөв дээр тусгасан байсан Монголбанканд тушаах алтны тушаалт 17 тонн байсныг хамгийн эрсдэлгүй бага хувилбараар буюу 20 тонноор тооцож авч үзэж, нийтдээ 29.7 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг тооцохоор төсвийн төсөлд тусгасан байгаа.

Саяын Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг Засгийн газрын зүгээс 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр

барагдуулах арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай байгаа.

Ерөнхийдөө таны хэлсэнчлэн 230 орчим тэрбум төгрөгийн асуудлууд яригдаж байгаа. Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг нь саадгүй явуулах үүднээс энэ асуудлыг ойрын хугацаанд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай. Ажлын хэсгийн зүгээс энэ зарчмыг баримталсан. Үүнтэй холбоотой тодорхой Засгийн газарт чиглэл өгсөн заалтыг төсөв дагалдан гаргах тогтоолын төсөлд тусгасан байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг Засгийн газар 2023 ондоо төсөв дээр төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээг авах ёстой гэсэн ийм байр суурьтай байна. Бусад асуудлыг. Хариулт ерөнхийдөө болсон байх. Тийм ээ. Шөнийн тарифын асуудлыг өөрөө ярьчихсан.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Асуулт хариултын цаг дууссан.

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ нарын урилгаар Хэнтий аймгийн “Өлзий мэргэн үндэсний сурын холбоо” төрийн бус байгууллагын тэргүүлэгч, гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт үндэсний сурын харвааны зүтгэлтнүүд Та бүхэндээ сум мэргэн, ажил үйлс нь өндөр арвин байхыг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс. /алга ташив/

Одоо санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгээрэй. Гишүүдэд асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй 7 санал байгаа. Зарчмын зөрүүтэй 7 саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна.

1.Төслийн 4 дүгээр зүйлээс “47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг,” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 47.9 дэх хэсэг нэмэх:

“2/47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг:

“47.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана. Хайгуулын ажлын технологийн явцад туршилтын журмаар олборлох ашигт малтмалын дээд хязгаарыг төрлөөс нь хамааруулж Засгийн газар журмаар зохицуулна.””

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт явуулна. Хөөе. Сангийн сайд, М.Оюунчимэг гишүүн хоёр суудалдаа суугаарай. Санал хураалт. /алх цохив/

55.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ заавал бүртгүүлж байх шаардлагыг яасан. Тэгээд бүргүүлээгүй бол экспортолно гэсэн нөгөө хориглосон хувилбараар биш, бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулна гэсэн ийм зохицуулалтаар шинэчлэн найруулж.

Т.Доржханд гишүүн яриад байсан. Тэгээд өөрөө гараад явчихсан байна шүү дээ. Энэ хяналтыг сайжруулж байгаа шүү дээ. Нүүрс, ашигт малтмалын.

Хоёр.Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.7 дахь хэсэг нэмэх:

“1/16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг:

16.7.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар батална.”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

33 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар үүнийг “газар” гэсэн утгатай болсон уу.

Гурав.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Энэ чинь тэгээд бас л цагдаагаасаа юу руу эвтэйхэн шилжүүлчихлээ шүү дээ. Яам руу.

Б.Энхбаяр гишүүн ээ, та чинь санал гаргаад энэ чинь нөгөө яам руу. Цагдаагийн ерөнхий газартаа байя гэсэн чинь Цагдаагийн ерөнхий газартаа үлдээчихэж байгаа юм биш үү. За за.

61.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “Б.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.“Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх санал.

1.Төслийн 2 дахь заалтын 9 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт малтмал олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Танилцуулах гээд ерөнхий санкцгүй хаячихаар л энэ хэрэгжихгүй болчихно. Улирал бүр танилцуулж байна ч гэдэг юм уу, нэг тийм юутай байвал уг нь. Тийм ээ.

2.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 10 дахь дэд заалт нэмэх:

“10/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр

суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлого боловсруулах;”

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Энэ Дамдины Цогтбаатар гишүүний гаргасан саналын агуулга байна. Өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн чинь агуулга ингээд орчихож байгаа үзэж болох уу. Тийм ээ.

57.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дахь заалтын 12 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлт үзүүлэх.”

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 6, 19 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

51.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Өнгөрсөн саналаар энэ дэмжигдчихээд. Тэгээд арай зөөлрүүлж яаж л орж байгаа юм шиг байна лээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хийх үед төсвийн тооцоололтой холбоотойгоор, түүнчлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд холбогдох хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн тул Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн үйлчилгээний чанар, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилах өөрөөр хэлбэр төрийн үйлчилгээний байгууллага нэмэлт орлого олж, түүнийг зарцуулах эрхтэй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөжийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах үүднээс тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуульд тусгагдаж батлагдахад үүсгэснээс хойш тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд коджуулах, шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж дуусгах зэрэг зохицуулалтыг төсөлд тусгалаа.

2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хууль санаачлагч нь анхдагч хуулийн төсөл, шинэчилсэн найруулгын хуулийн төсөл болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, түүнчлэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тусдаа үзэл баримтлалтайгаар, бие дааж өргөн мэдүүлж байх зохицуулалтыг тусгалаа.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар иргэдэд цахимаар мэдээлэл хүргэдэг байх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс санал, санаачилга гарсан бол Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараагийн ээлжит чуулганы хяналт шалгалтын цаглаварт оруулан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байх, төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт хяналт шалгалт явуулах үндэслэл, үргэлжлэх хугацааг тусгадаг болох, Байнгын хороо ээлжит чуулган эхлэхээс өмнөх 30 хоногийн хугацаанд тодорхой хяналт шалгалтын ажлыг заавал явуулахаар цаглаварт тусгах, Засгийн газар дахь хяналтын талаарх Засгийн газрын тайланг тодорхой хугацаанд Улсын Их Хурлаар сонсож байх, мөн Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хуульд тусгайлан сонсгол хийхээр заасан бол тухайн хугацаанд, харин тухайлан хугацаа заагаагүй тохиолдолд чуулганы чөлөө цагт зохион

байгуулдаг болох асуудлыг тусгасан болно.

4.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө эхэлсэн, дуусгаагүй хяналт шалгалтын асуудлыг зохион байгуулах, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хийсэн хяналт шалгалттай холбоотой гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэх, түүнчлэн 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах зэрэг шилжилтийн үеийн зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Төсвийн байнгын хороо дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж хуралдаанд санал гаргасан гишүүдийн саналыг бүрэн тусгаж, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нанзадын Наранбаатар гишүүнээр тасаллаа.

Содномын С.Чинзориг гишүүн асуулт асууя.

С.Чинзориг: Энэ Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал уг нь Засгийн газраас өргөн бариагүй юм. Тэгээд ажлын хэсэг дээр ярьж байгаад Байнгын хороогоор хэлэлцээд орж ирж байгаа юм байна л даа.

Би энэ дээр хоёр, гурван зүйл тодруулмаар байгаа юм. Зарим юмтай нь санал нийлэхгүй байгаа юм. Тухайлбал, тэр 29 дүгээр зүйлийн 29.3.6-д тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх гэж. Ингэж хатуу заалт хийж болохгүй шүү дээ.

Төсвийн тодотгол хийж л байгаа бол тодорхой зардал хасч л таарна. Урсгал зардлаас хасах юм ерөөсөө байдаггүй шүү дээ. Тэгээд л энэ хөрөнгө оруулалтын зардлыг чинь л хасаж таарна шүү дээ.

Тэгэхээр ийм хатуу төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж болохгүй гэдэг заалт оруулж ирж болохгүй ээ, Байнгын хороон дарга аа. Юу бодоод ингээд ийм юм хийчхэж байгаа юм бэ.

Би үүнийг дэмжихгүй байгаа юм. Өчигдрөөс ажлын хэсэг дээр ч би дэмжихгүй гэсэн. Энэ бол байж болохгүй ээ.

Хоёр дахь санал нь би бас эргэлзээтэй байна. 29 дүгээр зүйлийн 3.5 дахь заалт. Энэ 30 хувь гэж байсныг нь өөрчилчихсөн юм байна. Би бас 30 хувь болохгүй л гээд байсан юм.

Шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэмжээг 3 жилд багтаан дуусгаж санхүүжүүлэх гэж. Ингэх юм бол гишүүд минь хоёр талтай. Нэг бол том үнийн дүнтэй цөөхөн юм ороод. Жижиг үнийн дүнтэй барилга, сургууль, цэцэрлэг ерөөсөө орохгүй юм болно. Эсвэл дан жижиг хөрөнгө оруулалт ч орж ирээд том үнийн дүнтэй бүтээн байгуулалтын ажил явахгүй болно шүү дээ. Заавал энэ хөрөнгө оруулалтын ажлыг 3 жил дуусгах гэж ингэж хязгаар хийдэг нь яаж байгаа юм бэ. Өчигдөр заавал 30 хувийг нь тусах ёстой гэсэн. Би ингэж болохгүй гэж ажлын хэсэгтэй санал нийлэхгүй байна гээд гараад явчихсан юм. Тэгээд дахиад энэ өөрчилчихсөн юм байна.

Тэгэхээр энэ хоёрыг би дэмжихгүй байгаа юм. Тэр төсвийн тодотгол хийхээр хөрөнгө оруулалтын зардал бууруулж болохгүй гэхээр чинь төсвийн тодотгол хийх ямар ч боломжгүй л болчихно шүү дээ. Ямар урсгал зардлаас хасдаг биш. Тэгээд л хөрөнгө оруулалтаа л тайрч танадаг шүү дээ. Ингэж боомилж болохгүй байх.

Хоёр дахь асуудал нь, заавал 3 жилд хөрөнгө оруулалт хий гэвэл энэ Сангийн сайд тэгээд сайхан ам таглана шүү дээ. 3 жилд хөрөнгө оруулалтаа дуусгах гэсэн гээд нэг том үнийн дүнтэй хоёр, гуравхан зам тавьчихаад наадах чинь ороод ирнэ.

Тэгээд сургууль, цэцэрлэг тэр юу ч байхгүй. Та нарын баталсан хууль энэ. 3 жилд энэ зам гүүрийг чинь дуусгана гээд ингээд л ам таглана шүү дээ. Ингэж хэт Их Хурал өөрсдийгөө хөл гараа боомилсон юм бас хиймээргүй л байгаа юм даа.

Тэгээд дараагаар нь тэгээд дараагаар нь бид хэзээ ийм юм хийчихэв гээд л ингээд л амаа барьдаг шүү.

Тэр Хууль тогтоомжийн тухай хуульд оруулж байгаа өөрчлөлттэй ч гэсэн би бас өчигдөр саналаа хэлсэн юм. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлтүүдийг Төсвийн тухай хуультай хамт өргөн барьж болохгүй л гэж байгаа юм байна л даа.

Яах вэ, төсвийн хүрээний мэдэгдлийн хууль болохгүй байж болох юм. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг Төсвийн тухай хуультай хамт өргөн барьж болохгүй гэж ийм хязгаар хийж болохгүй шүү дээ. Энэ ямар үндэслэл байгаа юм, ямар шаардлага байгаа юм.

Эртээд Б.Энхбаяр гишүүн иймэрхүү санал хэлэхээр нь тэгээд нэг гишүүн ийм санал хэлсэн гээд ингээд хуульдаа өөрчлөлт хийгээд байх юм уу.

Харин зүгээр үүнийхээ оронд Төсвийн тухай хуультай Төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийг хамт өргөн барьж болохгүй гэхийнхээ оронд төсвийн хүрээний мэдэгдэлд харин өөрчлөлт оруулбал гишүүдийн гуравны хоёр дэмжсэн нөхцөлд төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулна гэдэг ч юм уу, ийм босго хийж өгөх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол ингээд Төсвийн тухай хуультайгаа төсвийн хүрээний мэдэгдлийн хамт оруулж ирж болохгүй. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулийг хамт оруулж ирж болохгүй гэж энэ хязгаар нэг их тийм зөв оновчтой зохицуулалт биш байна.

Г.Занданшатар: Эхлээд Ганзоригийн Тэмүүлэн. Төсвийн байнгын хороон дарга хариулна.

Г.Тэмүүлэн: С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ төсвийн сахилга баттай холбоотой, төсвийн хариуцлагатай холбоотой хэд хэдэн зарчмын асуудлууд орж ирж байгаа юм.

Энэ олон жилийнх. Магадгүй сүүлийн 10 жилийнхээ алдаа оноогоо засаж залруулах ёстой гэж харж байгаа. Бага ч гэсэн бид шинэчлэлийг хийх ёстой гэж харж байгаа. Өөрчлөлтийг бид хийхгүйгээр, Улсын Их Хурал дээрээс бид шинэчлэлийг хийхгүйгээр энэ нөхцөл байдал нь төсөв цаашдаа даахгүй. Төсвийн ачаалал улам их нэмэгдэнэ. Төсөв гэдэг энэ бөмбөг чинь

өөрөө цаашдаа задрахад, хагарахад бэлэн болсон байна.

Бид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэдэг нэрийдлээр улсын төсвөөс хөрөнгө оруулалт, барилга байгууламж барьдаг зүйлүүдээ тодорхой хэмжээ, хязгаар тавих ёстой.

Энэ жил бид 2.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс хийж байна. Энэ юуг харуулж байна вэ гэхээр яг таны сая хэлээд байгаа олон жилийн хугацаанд 5-аас 10 жилд тухайн тэр төсөв, хөрөнгө оруулалтыг олон жилд хувааж тавьдаг, амсуулаад тавьдаг энэ нөхцөл байдалтай улбаатай байгаа. Магадгүй 4, 5 аймаг энэ дээрээс илүү их хожсон байж магадгүй. Бид энэ төсвийн хулгай байхгүй болгоё гэдэг асуудлыг тавьж байгаа.

Цаашдаа нийгэмд чиглэсэн барилга, бүтээн байгуулалтыг хийх гэж байгаа бол тэр нь зөвхөн тухайн жилдээ баригдаж дуусдаг байх ёстой. Зарчмын асуудал. Олон нийтийг бид хүлээлгэх ёсгүй. Энэ татвар гэдэг бол, төсөв гэдэг бол татвар төлөгчдийн мөнгө, ард нийтийн мөнгө.

Бид тухайн тэр хүлээж байгаа барилга байгууламж, сургууль, цэцэрлэгийг нь богино хугацаанд оруулдаг байх, түүнийг барьж байгаа барилгын салбарынханд, хувийн хэвшлийнхэнд, аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр төсвийг нь төлөвлөдөг байх ёстой байгаа юм. Түүнээс төсөв гэдэг бол энэ өөрөө мөрөөдлийн жагсаалт биш. Мөрөөдлийн жагсаалт биш. Маш олон зүйлүүдийг бид амсуулаад тэнд тавьж болохгүй гэдэг асуудал байгаа.

Дээд хязгаар нь 3 жил гэдэг бол би бүр урт байна гэж харж байгаа. Болж өгвөл хоёр жилдээ дуусгадаг байх ёстой. Энэ Засгийн газрын улсын хөрөнгө оруулалтын хэмжээнд 30 тэрбумаас дээших Засгийн газрын бодлогоор орж ирж байгаа асуудлууд дээр тодорхой хэмжээнд гарц гаргалгаа байгаа гэж харж байгаа.

Саяын олон хуваадаг асуудлыг бид 3 жилээр тавьж байгаа. Уг нь 30 хувиар гэж бид хувьчилж бас оруулж өгсөн.

Мөн дээрээс нь тодотголоор бууруулдаг. Тодотголтой холбоотой асуудлуудыг аж ахуйн нэгж, байгууллагууд, барилгын салбарынхан маш ихээр ярьж байна. Энэ жил бид төсөв дээрээ хоёр удаа тодотгол хийсэн. 4 сард нэг тодотгол орсон, 6 сард тодотгол орсон.

Магадгүй тэрбум төгрөгийн ажил хийх гэж байсан, барилга барих гэж байсан компани түүнтэй дүйцүүлээд банкнаас зээл авсан. Гэтэл авах гэж байсан, санхүүжүүлэх гэж байсан тэрбум төгрөг нь 100 сая төгрөг болдог, 50 сая төгрөг болдог. Эргээд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийнхэн банкны хүүд дарлуулдаг, хохирдог нөхцөл байдал байгаа юм. Төр өөрөө хариуцлагатай байгаач ээ гэж байгаа юм.

Энэ компани, хувийн хэвшлийнхэн ярьж байгаа зүйл бол төр хамгийн найдвартай түнш гээд төрөөс зохион байгуулж байгаа хөрөнгө оруулалт, барилга бүтээн байгуулалтыг хийе гэж орж ирсэн чинь та нар төсвийн тодотголоор хоёр удаа хэрчээд төсвийн жил эхэлчихсэн байхад 4 сард, 6 сард хөрөнгө оруулалтуудыг байхгүй болголоо. Бид та бүхнээс болж хохирлоо

гэдэг асуудал ярьж байгаа. Энэ байх ёсгүй асуудал. Төр энэ хариуцлагагүй байдалтайгаа нүүр тулах ёстой. Үнэхээр тэр тодотгол хийх гэж байгаа бол өөрөө өөрсдөөсөө хасдаг, урсгал зардлаасаа хасдаг, хүн хүчээ цомхотгодог, төрийн захиргааг оновчтой бүтэц, зохион байгуулалтыг нь үр дүнтэй байлгадаг байх зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгэхээр энэ бол төсвийн дөнгөж шинэчлэлийг эхлэл нь. Бид цаашид илүү сахилга бат, хариуцлагатай байлгах, олон нийтийн хяналттай байгуулах асуудлуудыг өргөн барина. Энэ сардаа багтаж өргөн барина. Цаашид илүү хариуцлагатай байх асуудлууд орж ирнэ. Илүү улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийдэг зүйлийг больж, хувийн хэвшилд тулгуурласан, хувийн хэвшилдээ либеральчилсан байдлаар бид үүнийг хийх ёстой гэж харж байгаа.
/алга ташив/

Г.Занданшатар: Сайн хариуллаа. Ингээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ сурлагын өндөр амжилт хүсье. /алга ташив/

Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя. 1 минут.

С.Чинзориг: Яах вэ, шинэ дарга төсвийн шинэчлэл хийнэ гээд л байгааг нь дэмжиж байна.

Гэхдээ хэт сэтгэлийн хөөрлөөр асуудалд хандаж болохгүй. Засгийн газрын гар хөлийг хэт ингэж боомилж болохгүй.

Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зардлыг хасаж болохгүй гэж ийм хязгаар хийж болохгүй. Урсгал зардлаас танах ямар ч боломж байхгүй шүү дээ. Тэрийг мэдэж байгаа. Мэдсээр байж ийм юм хийж болохгүй.

Тэр хөрөнгө оруулалт 3 жил байна гэвэл сайн хэрэг. Гэхдээ томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлаа тэгвэл үүнийгээ жичид нь ялгаж өг л дөө. Засгийн газрын тэр хөтөлбөрт хэрэгжиж байгаа шинэ сэргэлтийн бодлого ч гэдэг юм уу, энэ нь өөр хугацаагаар байна гээд ялгахгүй бол хэдхэн том хөрөнгө оруулалт чинь 3 жилийн хугацаа нь дуусна гээд бусад орон нутгуудад сургууль, цэцэрлэг барих асуудал чинь хөрөнгө байхгүй ингээд дараа нь өөрсдөө амаа барина шүү. Гишүүд минь ээ. Асуудалд бас жаахан наана цаанатай хандах хэрэгтэй.

Г.Занданшатар: Д.Тогтохсүрэн дарга хариулна гэсэн үү, үгүй юу?

Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна. Дараа нь санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд.

Н.Наранбаатар: Төсвийн тухай хуульд ийм тодорхой заалтууд оруулж өгөх нь зөв гэж бодож байгаа юм.

Орон нутаг, дүүрэг, сум болгонд л дуусаагүй, тэгээд жилээс жилд төсөв нь нэмэгдээд явж байдаг. Тэгээд нураах хэцүү, цаашид үргэлжлүүлэхэд төсөв байхгүй ийм асуудлууд зөндөө байгаа.

Тийм учраас Төсвийн тухай хуульд 3 жилд багтаан санхүүжүүлж

дуусах гэдэг бол маш их зөв асуудал орж ирж байгаа юм байна. Харин өмнө нь яригдаж байсан тэр 30 хувь нь яагаад алга болчихов. Бүр болдог бол эхний жил нь 50 хувь, дараагийн жил нь тэгээд дуусгачихдаг. 50 хувиар нь. Ингээд 100 хувь болчихдог болчих юм бол одоо бүр л их сайн байсан юм. Ингээгүйгээс болоод сүүлийн жилүүдэд маш их төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, төсвийн алдагдлыг нэмэх ийм зүйлүүд рүү орсон байсан.

Тийм учраас үүнийг дэмжиж байгаа юм.

Мөн энэ жил тухайлбал төсвийн тодотгол хоёр удаа хийгээд ингээд хөрөнгө оруулалтуудыг маш их санхүүжих дүнг нь хассанаас болоод хэзээ дуусах нь мэдэгдэхгүй маш олон барилгатай боллоо. Тухайлбал, манай тойрогт 4.5 тэрбумын төсөвтэй номын сангийн барилга дээр 2002 онд сая тодотголоор 200-хан сая тавьчихаж байгаа юм.

Тэгэхээр хэн энэ ажил руу чинь ямар компани орох юм, хэзээ дуусгана гэх юм, хэзээ санхүүжилтээ авч дуусгана гэх юм. Тэгээд хэдэн жил болох юм. Энэ чинь үүнээсээ болоод энэ ажлууд эхлэхгүй байх, хөрөнгө оруулалтууд зогсох ийм зүйлүүд бий болж байгаа учраас төсвийн тодотголоор бууруулахгүй байх гэдгийг дэмжиж байна.

Бас нэг асуудал байна. Нэг л асуулт байна. Энэ төрийн үйлчилгээний байгууллагууд нэмэлт орлого олж болно гэсэн байх юм. Ер нь энэ төрийн байгууллагууд чинь бизнес хийхгүй, хувийн хэвшлийн хийдэг юмыг заавал давхцаж хийхгүй, хувийн хэвшлээ дэмжинэ гээд байсан чинь төсвийн байгууллагууд маань бизнес хийж

орлого олдог ийм болчхож байгаа юм биш биз ээ. Энэ дээр нэг жаахан тодруулаач. Ямар хүрээнд хязгаарлах юм? Ямар ажлууд хийж нэмэлт орлого олох юм? Тэрийгээ тэгээд юунд зарцуулах эрхтэй байх юм бол гэдэг дээр нэг тодруулга авъя.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн. Төсвийн байнгын хорооны дарга. Төсвийн ажлын хэсгийн ахлагч.

Г.Тэмүүлэн: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр бидний хувьд сая сүүлийн асуусан асуулт болох энэ төрийн үйлчилгээний байгууллагууд нэмэлт орлого олдог байх, түүнийгээ захиран зарцуулах эрхийг нь бас энэ хуулийн хүрээнд нь нээж өгье гэсэн энэ зарчмын саналыг гаргаж байгаа.

2011 онд баталсан төсвийн хуулиар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах ямар ч сэдэл төрийн байгууллагуудад байхгүй байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ ер нь энэ төрийн үйлчилгээний байгууллагууд өөрөө өөрсдөө илүү орлого олоод түүнийгээ нэмэгдүүлээд, эсвэл өөрсдөд нь төсөвлөөд тавьсан зарлагаа бууруулах, хэмнэлт үүсгэх сонирхол ерөөсөө байхгүй байна гэсэн үг. Энэ хуулиар.

Бидний оруулж ирж байгаа хуулийн өөрчлөлтөөр ерөөсөө төрийн үйлчилгээний байгууллагууд өөрсдөө үр ашигтай ажиллаад, магадгүй юу гэдэг юм олдог орлого нь нэмэгдээд боломж нь бий болоод ирэх юм бол эргээд тэр юу гэдэг юм эсвэл хэмнэсэн үр ашиггүй зардлуудаа бууруулсан тохиолдолд өөр өөрсдийнх нь цалин хөлсийг нэмэгдүүлдэг, нийгмийн баталгааг нь

зах зээлийнх нь зарчмаар нэмэх боломжийг л нээж өгье гэдэг асуудлууд байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө үйлчилгээний байгууллага гэдэгт та бас юу гэж ойлгож болно гэвэл шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулиуд, эсвэл хөдөлмөр эрхлэлтийн салбарын байгууллагууд ч гэдэг юм уу. Тийм ээ. Бид нар үүний бодит нэг жишээ нь манай энэ Газар тариалангийн хүрээлэн байна. Малын удмын сангийн үндэсний төв байна. Энэ салбарууд чинь юу гэдэг юм хувийн хэвшилтэйгээ хамтраад тэд нарт шаардлагатай байгаа судалгаа, шинжилгээнүүдийг хийгээд, инновац, технологийг нэвтрүүлээд, шаардлагатай үр тариаг нь ч гэдэг юм уу, эсвэл одоо юу гэдэг юм тухайн тэр бэлдмэлийг нь нийлүүлж өгөөд гаргасан тэд нарын олсон орлогоос нь тодорхой хувь хэмжээг аваад өөрсдөө ашигтай ажиллаад, түүгээрээ өөр өөрсдийнхөө ажилчид, албан хаагчдын нийгмийн баталгааг нь хангаад явах боломжийг л нээе гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол зарчмын хувьд бид энэ үйлчилгээний байгууллагууд дээр гүйцэтгэлд суурилсан энэ санхүүжилтийг нээж өгөх нь зөв байх. Ингэж байж энэ байгууллагуудын ажил, үйлчилгээнийх нь чанар нь, гүйцэтгэл нь сайжрах боломж бололцоо бүрдэх болов уу гэсэн үндсэн дээр оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ бол зөвхөн үйлчилгээний байгууллагууд хамаарах, тэр дундаа энэ боловсрол, шинжлэх ухаан болоод хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн байгууллагууд илүү их түлхүү хамрагдаж байгаа л гэдэг хэлэх байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хороо Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг

дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

30 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалдаа оръё. Дөрөвдүгээр асуудал байна.

Дөрөв. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны эцсийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөлд болон холбогдох хавсралтуудад тусгаж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд:

1.Төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн тэнцлийг сайжруулахтай холбоотой төсвийн орлогыг **127.7 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.Төрийн хэмнэлтийн тухай хууль болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зарим шаардлагагүй төсөл хөтөлбөр, урсгал зардлыг хэмнэж, төсвийн зардлыг **176.9 тэрбум төгрөгөөр** бууруулах;

3.Зарим шаардлагагүй зардлыг бууруулсан эх үүсвэрээр зохицуулалт хийн хүн ам ихтэй хот, суурингийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт олгох, хавдраас урьдчилан сэргийлэх үндэсний арга хэмжээ болсон “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойн хортон шавжтай тэмцэх, ой хамгаалах, хүүхэд хамгаалах арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэх, “хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилтуудыг бодитой ажил болгох зэрэг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд **176.9**

тэрбум төгрөгөөр төсвийн зардлыг тус тус нэмэгдүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг **19 их наяд 049.6 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **34.9 хувь**, нийт зарлагыг **20 их наяд 475.3 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **37.6 хувь**, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг **1 их наяд 425.7 тэрбум төгрөг** буюу дотоодын нийт бүтээгдэхүүний **2.6 хувьтай** тэнцүү байхаар тооцлоо. Тодруулбал, Засгийн газрын өргөн мэдүүлсэн нийт тэнцвэржүүлсэн орлогыг **127.7 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлж, төсвийн алдагдлыг 127.7 тэрбум төгрөгөөр буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 0.23 хувиар сайжрууллаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын хэмжээг нэмэгдүүлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн

тухай хуулийн төслийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт, тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх тус Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн, төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнд.

Одоо ажлын хэсгийг танилцуулъя. Түрүүчийнхтэй үндсэндээ адилхан. Тэгэхдээ Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Сангийн яамны Санхүүгийн ерөнхий удирдлагын газрын дарга Солонгын Тулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны

Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуулт асууна.

Д.Ганбат: Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Угаасаа энэ төсвийн хэлэлцүүлэгт би оролцохгүй байгаа л даа. Ардчилсан намаас энэ төсвийг татаж ав гэдэг шаардлага тавьсан. Татаж аваад янзлаад эргүүлээд оруулж ир ээ. 20 их наядын зарлагатай. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний бараг тал хувь нь улсын төсөв нэрээр зарлагдаж байгаа.

Хэзээ ч ийм их мөнгийг улсын төсөв нэрээр зарцуулж байгаагүй. Өнөөдөр Улсын Их Хурал утгаа алдчихсан шүү дээ. Улсын Их Хурал ерөөсөө ёстой нэг Ардын намын улаан булан шиг л ажиллаж байна даа. Тийм.

Өнөөдөр хувийн хэвшлүүдийг бүгдийг нь хоолойг нь боочихсон. Сөрөг хүчин гэдэг юм энд алга. Улсын Их Хурал ч гэсэн утгаараа байхгүй болчихлоо.

Тэгээд энэ Монголын ард түмний амьдрал сайжирч байгаа юм уу. Байхгүй шүү дээ. Энэ их мөнгийг ямар ч хараа хяналтгүй зарцуулж байна. Өдөр болгон ард түмний амьдрал доройтож байна. Юмны үнэ өсөж байна. Нөгөө найрласан хэвээрээ л байна.

Тэгээд мөнгөний бодлого, төсвийн бодлого энэ бүхэн уялдаж байгаа юм алга. Өнгөрсөн долоо хоног

тав дахь өдөр гэхэд Улсын Их Хурал Хуралдсангүй. Г.Занданшатар дарга та наад санал ширээтэй зууралдахаа боль. Та тэр ард түмнийхээ дотор орж ард түмнийхээ амьдралд ямар байгааг хар.

Энэ төсвийг энд сонирхож байгаа хүн ч алга байна шүү дээ. Одоо эцсийн хэлэлцүүлэг гээд ороод ирж байна. Тэгээд л энд чинь нэг оршуулгын газар байгаа юм шиг л байна шүү дээ. Одоо ард түмнээс төлөөллөө авсан Улсын Их Хурал бол ажил төрлөө хийж байгаа юм алга.

Энд баахан дарга нар байна. Баахан Байнгын хорооны дарга нар. Тэгээд хэчнээн ч сайдтай юм, дэд сайдтай ч юм. Ийм их ачааг Монголын ард түмэн үүрч чадахгүй ээ. 2023 онд гэрэл гэгээтэй юм ерөөсөө алга. Өдөр болгон бид дефолт руугаа явж байна. Энэ бүхнийг сүүлийн долоон жил...

Г.Занданшатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож яриа шүү. Энэ одоо юу яриад явчихав аа.

Д.Ганбат: Тэгээд ороод юм хэлэхээр ингээд ам хаагаад байдаг шүү дээ. Тэгээд би ард түмнийхээ өмнөөс үг хэлэх гээд сууж байна. Хэлж болох юм уу, үгүй юм уу.

Тэгээд нэг санал ширээтэйгээ битгий зууралд гэхээр тэндээс тэгээд л...

Г.Занданшатар: Төсвийн ганц ч хэлэлцүүлэг Д.Ганбат гишүүн оролцоогүй. Тасалсан. Сануулга өгч байна. Төсвийн ажлын хэсэгт ажиллахгүй. Төсвийн бүх хэлэлцүүлэгт оролцоогүй. Тэгээд өнөөдөр төгсгөлд нь орж ирээд одоо ингээд юм яриад явах юм. Танай О.Цогтгэрэл гишүүн чинь

маш идэвхтэй оролцлоо шүү дээ. Ажлын хэсэгт.

Төсвийн зардал буулгаад, алдагдал бууруулахад маш идэвхтэй ажиллаж байна. Ажил хэрэгч ярилцахыг сануулья танд. Нөхөрсгөөр санал хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хариулах хүн байна уу? Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгье. Мэдээлэл өгье. Яах вэ, хариултыг нь өгөхгүй бол.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр бид бүхэн бас энэ Улсын Их Хурлын зүгээс сүүлийн 20 хоногийн хугацаанд, сүүлийн 3 долоо хоногийн хугацаанд тодорхой хэмжээнд бас энэ төсөв дээр төсвийн тэнцлийг сайжруулах болоод алдагдлыг бууруулах хүрээнд бас ажилласан.

Энэ хүрээндээ бид ямар ч бай бас Засгийн газраас өргөн баригдсан энэ төсвийн алдагдлыг тодорхой хэмжээнд бууруулж, төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд заасан алдагдлыг 1.9 их наяд гэж байсан бол 1.4 их наяд руу бууруулж оруулж ирсэн гэдгийг Та бүхэндээ хэлэх байна.

Тэгэхээр ер нь мэдээж эдийн засгийн нөхцөл байдал тодорхой хэмжээнд амаргүй байгаа энэ цаг үе дээр бид тэвчиж болох зардлууд байна. Тэр дундаа Төрийн захиргааны байгууллагууд төр өөрөө өөрөөсөө тодорхой хэмжээнд энэ зардал хэмнэх, зардал бууруулах, бүсээ чангалах, тэвчиж болох зардлуудаа хийе гэдэг үндсэн дээр улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагааны зардлыг тодорхой хэмжээгээр бууруулж байгаа.

Нийтдээ 100 орчим тэрбум төгрөгийг энэ яам, Тамгын газар болоод агентлагуудаас бууруулж байгаа. Үүнд яах вэ, онцолж би хэлэх нь энд зөвхөн яам болоод агентлагууд орж байгаа. Үүнд орон нутгийн төсөв болоод Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сангууд хамаарахгүй, эсвэл цалин тэтгэврүүд бас хамаарахгүй. Цэвэр үйл ажиллагааны зардлууд хамаарна гэдэг зүйлийг хэлэх байна.

Мөн дээрээс нь гадаад зээл, тусламжаар хэрэгжих төслийн зардлаас тодорхой хэмжээний бууралтуудыг бас бид хийж байгаа. Зарим боомтын замын болоод дэд бүтцийн зардлуудыг бууруулж байна. Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах, зураг төсөв, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ энэ тэр гэсэн зардлуудыг бас тодорхой 50 хувиар бууруулж оруулж ирж байгаа.

Тэгэхээр хүрээндээ бид энэ хэмнэсэн, тэвчсэн, бууруулсан зардлуудаар нийгмийн хэмжээнд тулгамдаж байгаа, олон нийтийн эрх ашгийг хөндсөн, мөн тодорхой хэмжээнд хүлээлттэй байгаа энэ асуудлуудыг хэмнэсэн эх үүсвэрээр зохицуулалт хийх шийдлийг Улсын Их Хурал дээрээс ажлын хэсгийн зүгээс гаргаж байгаа гэдгийг хэлэх байна. Үүний нэг нь бид бүхэн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг хийсний хүрээнд үүн дээр хамгийн их тулгамдаж байсан, бас гаргаж ирж тавигдаж байсан, яригдаж байсан асуудлын нэг нь эдийн засаг хүнд үед энэ эрчим хүчний тарифын хөнгөлөлтийг ядаж нэг жил үргэлжлүүлж өгөөч ээ. Үүнийг бас төрөөс шийдэж өгөөч ээ гэдэг асуудал байсан.

Тэгвэл улсын хэмжээнд 10 мянгаас дээш хүн амтай аймаг, нийслэлийн хот суурингийн гэр

хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн зардлыг Улсын Их Хурлаас санхүүжилтийг нь бүрэн шийдэж ингэж гаргаж өгч байгаа.

Үүний үндсэн дээр нийтдээ Улаанбаатарт 125 мянган өрх, орон нутагт 48 мянга 600 гаруй айл өрхүүд энэ шинийн тарифын хөнгөлөлтөд хамрагдах бүрэн боломж бололцоо бүрдэж байгаа.

Мөн дээрээс нь энэ хавдраас урьдчилан сэргийлэх болоод хүүхэд хамгаалах зардалтай холбоотой, боомтын сэргэлттэй холбоотой, хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний зорилтуудыг бэхжүүлэхтэй холбоотой гээд тодорхой зорилтуудыг хийж өгсөн.

Мөн Засгийн газрын зүгээс төсөв өргөн барихдаа шинэ хөрөнгө оруулалтыг хийхгүй. Өмнөх хөрөнгө оруулалтуудыг дуусгая гэдэг бодлогыг гаргаж орж ирсэн.

Улсын Их Хурлын зүгээс энэ бодлогыг зарчмын үед бүрэн дэмжиж байгаа. Бид энэ улсын төсөв дээр хийж байгаа хөрөнгө оруулалтын ачааллуудыг ирэх онуудад бууруулах. Энэ жил юу гэдэг юм дуусгах боломжтой ажлуудаа дуусгах бодлогыг баримталж, энэ тодорхой хэмжээнд зохицуулалтын юунууд хийсэн. Үүн дотроо боловсрол, эрүүл мэндийн салбаруудыг хамгийн тэргүүний ээлжинд шийдвэрлэхийг чухалчилсан байгаа.

Үүн дотроос би онцолж хэлэхэд нийтдээ саяын хэмнэсэн зардлын хүрээнд зохицуулалт хийсэн зардлууд дунд нийтдээ 65 сургууль, цэцэрлэг, 19 эрүүл мэндийн төвийн санхүүжилтүүдийг тодорхой зохицуулалтуудыг хийж, дийлэнх зарим

нь ирэх онд дуусгаж ашиглалтад орж, мянга мянган хүүхдүүд эргээд шинэ сургууль танхимдаа орж сурах, эргээд эрүүл мэндийн төвдөө үйлчлүүлэх энэ боломж бололцоонууд бүрдэж байгаа гэдгийг хэлэх байна.

Бид цаашид энэ төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шинэчлэлийг үргэлжлүүлэх юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлагдах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар

Одоо Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээс санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг тогтоолын төсөлд нэг бүрчлэн тусгаж, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг нэмж тусгасан эцсийн хувилбарын төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Мөнхөөгийн М.Оюунчимэг гишүүн нараар тасаллаа.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би нэг л зүйл тодруулъя. Энэ бас нийгмийн сүлжээгээр ч гэсэн яригдаад л байгаа асуудал байгаа юм.

Энэ бол ипотекийн зээлийн асуудал байгаа. Бид энэ КОВИД-той холбоотойгоор ипотекийн зээлийн эргэн төлөлтийг тодорхой хугацаанд царцаасан. Энэ нь мэдээж иргэдийн КОВИД-той холбоотой, дээр нь иргэдийн орлоготой холбоотой асуудал байгаа.

2023 оны мөнгөний бодлогыг хэлэлцэх явцад ипотекийн зээлтэй холбоотой асуудлыг ажлын хэсэг ажилласан байх ёстой. Би ажлын хэсгийн ахлагч асууя гэж бодож байна.

Ипотекийн зээлийг сунгахтай холбоотой асуудлыг юу гэж шийдсэн бэ? Сунгах. Эсвэл эргэн төлөлтийг нь хийгдээд явах юм уу? Энэ талаар ажлын хэсэг ярилцаад Байнгын хороо энэ асуудлыг юу гэж эцэслэн шийдэж байгаа гэдэг ийм зүйлийг асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга хариулах уу. Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг хариулна.

Ц.Цэрэнпунцаг: КОВИД-ын хууль 12 сарын 31-нээр зогсохоор зэрэг,

үйлчлэл зогсохоор зэрэг энэ ипотекийн зээл бол цаашаа төлөгдөж явах ёстой.

Тэгээд ер нь ипотекийн зээл хамгийн гол нь одоо энэ зээлийн төлөлт явагдахгүй бол ипотекийн зээл цаашдаа олгогдох асуудал хүндэрнэ. Эх үүсвэргүй болно.

Тийм учраас ипотекийн зээл явах ёстой гэж үзэж байгаа. Тэгэхдээ ипотекийн зээлийг цаашдаа явуулахдаа бид хөдөө орон нутаг руугаа ер нь ипотекийнхаа зээлийн бодлогыг чиглүүлбэл яасан юм бэ гэж.

Нэгдүгээрт, бид хамгийн алс, орон нутагт ажиллаж байгаа, тэр суман дээр ажиллаж байгаа төрийн албан хаагч, малчдадаа, сумынхандаа бас энэ ипотекийн зээл авах ийм боломжийг нээж өгөх ёстой гэж харж байгаа юм.

Ер нь ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр дээр нь хүртэл анхаарах хэрэгтэй. Ялангуяа Улаанбаатараас хөдөө орон нутагт шилжиж ажиллаж байгаа хүмүүст энэ дээр чинь хөнгөлөлтийг нь үзүүлнэ гээд бид хөнгөлөлтүүд өгсөн байгаа.

Дээрээс нь энэ ипотекийн зээлийг сум, аймаг, Улаанбаатар гэсэн энэ дараалалтай эрэмбэ дарааг нь тогтоож явуулбал Улаанбаатарын түгжрэлтэй холбоотой асуудлуудыг шийдэхэд. Дээрээс нь Улаанбаатар руу чиглэсэн нүүдэл суудлыг сааруулах энэ чиглэлд бас үр дүнтэй ажил болох болов уу гэж харж байгаа юм.

Тийм учраас үүнийг цаашдаа үргэлжлүүлэх ёстой гэж үзэж байгаа юм.

Ер нь ипотекийн зээл авчихсан 100 гаруй мянган өрх байгаа. Цаашдаа

энэ боломж нь олдвол авахаар 200, 300 мянган айл өрх байгаа. Энэ айл өрхүүд Улаанбаатар, аймгийн төв, сум сууринд байгаа.

Тийм учраас бид эхний ипотекийн зээл авсан улсууд нь дараагийнхаа ипотекийн зээл авах гэж хүлээж байгаа, энэ боломжийг харж байгаа хүмүүстээ боломжийг нээж өгөх ёстой. Хариуцлагаа хүлээж, үүргээ хүлээж ипотекийнхаа төлөлтийг хийх ёстой.

Тэгээд дараагийнх нь хүмүүс тохитой тухтай орчинд амьдрах боломжийг нь харж ипотекийн зээлийн төлөлтийг цааш нь үржүүлэх нь зөв зүйтэй гэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Би Тогтохсүрэн даргын асуусныг бас үргэлжлүүлэх гэж байна л даа.

Эдийн засгийн байнгын хороон дээр төрөөс баримтлах мөнгөний бодлого хэлэлцэж байх үед Төв банкныхан нь ч, Банкнуудын холбооны зүгээс ч гэсэн хамгийн сайн эргэн төлөгддөг зээл бол ипотекийн зээл гэж хэлж байгаа.

Сүүлийн одоо энэ 4, 5 жилийн байдлаас аваад үзэхэд бараг 400 орчим тэрбум төгрөгийг энэ ипотекийн зээл дээр эргэлдсэн. 100 мянга гаруй иргэд бас ч гэж энэ ипотекийн зээл аваад орон сууцанд орчихсон. Одоо цаана нь 240 гаруй мянган иргэд байна. Энэ хүмүүс үнэхээр зээлэнд хамрагдах хүсэл хот хөдөөгүй байна гээд ярьж байгаа. Нэг талаасаа бид сая төсөв хэлэлцэх үед төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас барилгын салбар, түүнтэй холбоотой

үнийн зөрүүг хүртэл тусгах асуудал ингээд л орж ирж байна л даа. Энэ банк, барилга гээд л бүгд бие биедээ уялдаа холбоотой.

Тэгэхээр олон нийтийн саналыг бид төсөв 2023 хэлэлцэхдээ авч байгаа. Төрийн мөнгөний бодлого хэлэлцэхэд эдийн засагч, хувь хүмүүс, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өнгө, энэ уур амьсгалыг харахад ипотекийн зээлийг төр оролцохгүйгээр нээлттэй орхичхооч ээ. Төлөх нь төлөөд яваг, төлөх боломжгүй нь тухайн банктайгаа яриад тодорхой хэмжээгээр хойшлуулах нь бас энэ төрөөс баримтлах мөнгөний бодлого дээрээ нээлтээ орхиод өгчихвөл яасан юм бэ гэдэг хүсэлт яваад байгаа юм.

Тэгэхээр энд бид албаар заавал КОВИД-ын нөхцөл байдал угаасаа бид бас чөлөөтэй ингээд аль болохоор эдийн засгаа, иргэдийнхээ орлогыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх энэ явж байгаа тохиолдолд 07 сарын 01-н хүртэл ингээд автоматаар бүгдийг нь сунгах биш нээлттэй орхичихвол яасан бэ гэсэн байр суурийг би илэрхийлмээр байна.

Ер нь үүнийг бас олон хүмүүс хэлж байна л даа. Тэгэхээр Монголбанкныхан энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгчихвөл яасан юм бэ? Одоо жишээлбэл яг хүсэлт өгсөн хэд байна? Хэдий хэмжээний мөнгө эргэн төлөгдөж байгаа. Сая КОВИД гээд 07 сарын 01-н гээд хоёр жил хойшлуулчихсан. Энэ нь өөрөө эргэлдэж байгаа мөнгөний тал хувийг нь зогсооход хүргэчихсэн гээд байгаа шүү дээ. Гэхдээ зарим хүмүүс нь бас эдийн засаг, энэ чинь өр болоод л үлдэх учраас төлөөд л яваад байгаа хүмүүс ч байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид нэг мөр шийдчихгүйгээр нээлтээ орхиод явчихвал яасан юм бэ. Хөндлөнгөөс энд шууд оролцоод байвал өөрөө ипотекийн салбараа ч гэсэн, барилгын салбараа, эдийн засагт ч гэсэн сөрөг нөлөө үзүүлнэ гэж тайлбарлаж болохоор байгаа юм.

Нөгөө талаасаа Засгийн газрын зарим гишүүд маань, одоо жишээ нь өөрсдөө ингэж яриад байх юм. Ипотекийн зээлийн 8 хувийг 6 хувь болгочих бололцоо байна. 6 хувь болго гээд бас ингээд яриад байна л даа. Гэтэл бодлогын хүү маань өнөөдөр 8 байгаа энэ тохиолдолд, бодлогын хүү өсчихсөн тохиолдолд ипотекийн зээлийн 8-ыг 6 хувь болгох бололцоо харагдахгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хувь дээр ч гэсэн бид олон нийтэд нэг мөр зөв ойлголт өгөх нь өөрөө чухал байна.

Тэгэхээр энэ дээр Монголбанкны байр суурийг сонсчихоод төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр бид яг зохион байгуулалттайгаар 07 сарын 01-н хүртэл хойшлуулна гэхгүйгээр нээлтэй орхичихвол яасан бэ гэсэн байр сууриа илэрхийлээд асуултдаа хариулт авъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 83. Монголбанкны ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: М. Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр энэ ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй энэ хөтөлбөр маань 2013 онд эхэлсэн. Одоо ингээд нийтдээ 2022 оны 09 дүгээр сарын сүүлийн тоо мэдээгээр 6.6 их наяд

төгрөгийн зээлийг 109.8 мянган өрхөд олгосон байна.

Тэгэхээр 109.8 мянган өрх ипотекийн зээлтэй орон сууцанд амьдарч байна гэсэн үг.

Тэгээд бас 2022 оны тоог хэлэхэд 2022 оны эхнээс авхуулаад 10 сарын 19-ний өдрийн байдлаар 523.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй ийм одоо 6 хувийн хүүтэй зээлийг 5.8 мянган өрхөд олгоод явж байгаа.

Тэгэхээр 2021 онд 13 мянган өрх авч байсан. 2022 онд 5.8 мянга гээд. Хэдийгээр он дуусаагүй байгаа ч гэсэн гэхдээ мэдээж тэр өндөр, өнгөрсөн оны тэр үзүүлэлтэд хүрэхгүй нь ойлгомжтой байгаа.

Ингээд ерөнхийдөө КОВИД-той холбоотойгоор зээл төлөлтийг хойшлуулсан. Анх тэр шийдвэр гарснаас хойш 31 орчим сар өнгөрөөд байна. 31 сар.

Тэгэхээр энэ маань юу хэлж байна гэхээр эхлээд ер нь анх тэр шийдвэр нь өөрөө юу гэж гарсан бэ гэхээр төлөх нь төлж байж болно. Төлөхгүй нь бас төлөх төлөхгүйгээр ингээд хойшлуулж энэ боломжийг ашиглаж болно гэдгээр шийдвэр гарсан.

Тэгэхээр анх шийдвэр гаргаж байхад ерөнхийдөө 20 орчим хувь нь төлөхгүй байхаар байсан бол одоо энэ нь нэмэгдсээр байгаад бараг 50 хувь руугаа хүрчхэж байгаа юм. Тэгэхээр нэлээн ийм нэмэгдсэн юутай байгаа.

Хоёрдугаарт гэвэл ипотекийн энэ хөтөлбөр маань өөрөө эхний санхүүжилтээ буцаж төлөгдөж орж ирээд дараагийнхыг санхүүжүүлээд ингээд эргэлтийн сангийн маягаар өөрөө

өөрийгөө санхүүжүүлэх ийм тогтолцоо нэгэнт бий болчихсон гэдэг утгаараа одоо төлбөр орж ирэх юм бол дараагийн эх үүсвэр болж гарахаар ийм л боломжтой л доо.

Тэгэхээр энэ утгаараа энэ онд мэдээж ингээд бага гарч байна гэдэг маань төлбөр нэлээн орж ирэхгүй байгаа учраас л ийм саатал үүсэж байгаа.

Өнөөдрийн гаргаж байгаа эх үүсвэрийн 80 хувийг нь Монголбанк гаргаж байна. 20 хувийг нь банк гаргаад явж байгаа.

Монголбанкны хувьд өөр дээрээ өргөдлийг хүлээж аваад шийдэж явдаггүй. Банкнууд өөрөө шийдээд явдаг. Гаргасан зээлийнхээ араас ийм хэмжээний зээл гарчихлаа. Тэгээд эх үүсвэрээ 80 хувийг нь Монголбанк гаргах ёстой гэдгээрээ ингээд Монголбанкнаас аваад явж байгаа.

Яах вэ, энэ хөнгөлөлттэй санхүүжилтээр зээл ба орон сууцад ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж байгаа нийгмийн шинжтэй бодлого бол төрийн бодлого. Тэр утгаараа дэлхийн олон улс оронд яг ийм бодлого явж байгаа. Монголын хувьд эхнээсээ Монголбанк гаргаад явж байгаа. Төв банк энд оролцоод явж байгаа учраас ялангуяа олон улсын байгууллагуудаас гол нь шүүмжлэл гарч ирдэг. Энэ нь төсвийн шинжтэй арга хэмжээг Төв банк хийгээд яваад байна гээд.

Тэр утгаараа нэгдсэн төсөв нэг төсөвтэй байх үүднээсээ энэ бол Засгийн газарт очих ёстой ийм тогтолцоо. Тэгээд тэр утгаараа ч тэр, КОВИД-ын хууль энэ 12 сарын 31-нээр дуусаж байгаа учраас Монголбанкны хувьд үүнийгээ шилжүүлэхэд бэлэн байна.

Тэгэхээр Засгийн газрын агентлаг байх юм уу, төрийн өмчтэй банк, санхүүгийн байгууллага байх юм уу. Алинд нь ч хамаагүй хийж болно. Энэ бол өөрөө нэг их бодлого гэхээсээ илүү өөрөө ийм тогтолцоо болчихсон одоо тийм механик үйлчилгээний ажиллагаа байгаа. Оператор. Одоо тэгэхээр нэг операторын үйл ажиллагаа хийх компани л гарч ирэх нь зайлшгүй зүйл болж байгаа ийм л зүйл байгаа.

Г.Занданшатар: М.Оюунчимэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

М.Оюунчимэг: Надад нэг санал байна. Их Хурлын дарга аа. Сая Монголбанкны Ерөнхийлөгч хэлж байна. Бид бас Эдийн засгийн байнгын хороон дээр энэ Төрөөс баримтлах мөнгөний бодлогын 2023-ыг хэлэлцэхдээ 06 сарын 01-н гээд. Тийм ээ. Хоёрдугаар улиралдаа багтаагаад энэ ипотекийн зээлийн асуудлыг Монголбанкнаас Засгийн газартаа шилжүүлэх тухай орж байгаа.

Тэгэхээр агентлаг байх уу, ямар бүтэц байх вэ гэдэг асуудал нь мэдээж одоо яригдана.

Дээрээс нь 12 сарын 31-нд КОВИД-ын тухай хууль цуцлагдана гэж бид ойлгож байгаа шүү дээ. КОВИД-ын хуулиар ипотекийн зээлийг сунгах, эс сунгах чинь мөрдөгдөөд яваад байгаа.

Тэгэхээр КОВИД-ын хуультайгаа хамт 12 сарын 31-нд үүнийгээ ингээд орхичхоод. Харин энэ бүтэц энэ тэрээ Засгийн газарт яг тодорхой болгоод ипотекийн зээлийг үргэлжлүүлэх, эргэн төлөлтийг нь яг нээлттэй болгоод зах зээлийн жамаар нь явуулах ийм чиглэлийг Их Хурлын зүгээс Засгийн газартаа, энэ Монголбанктэй өгчихвөл

ямар вэ гэсэн саналыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Тэгээд мөнгөний бодлогын баримт бичиг батлагдах нь ээ.

Тэгээд ер нь мөнгөний бодлого төсөвтэйгөө нягт уялдаж явагдаж байх ёстой л доо. Тэгээд төсөв маань ингээд батлагдаад явж байгаа. Хэчнээн сайн мөнгөний бодлого байгаад төсөв маань буруу явбал тэгээд мөнгөний бодлого маань өөрөө буруу явна л даа.

Мөнгөний бодлого зөв хэрэгжих гол үндсэн шалтгаан бол Засгийн газрын үйл ажиллагаа, дэмжлэг ч гэж хэлдэг шүү дээ. Төсвийн орлогоо их оновчтой зөв төлөвлөх ёстой. Нөөц бололцоогоо зөв ашиглаж дайчлах ёстой. Орлогоо нэмэгдүүлэх хэрэгтэй. Зарлагаа эрэмбэлж, илүү дутуу зардал гарахгүй байх ёстой. Өрийн менежментээ их зөв удирдах ёстой. Төсөв алдагдалгүй байх ёстой. Гадаад худалдаа ашигтай байх ёстой. Гаднаас орж ирж байгаа мөнгө, тэр экспортод гарч байгаа баялгийн мөнгө Монголдоо орж ирэх ёстой. Долларжилтыг бий болгохгүй болох энэ нөхцөлүүдийг. Ард түмний амьдралыг дээшлүүлэх. Монгол Улсын үнэ цэнийг нэмэгдүүлэх. Энэ ханшийн уналт, энэ инфляц, энэ эдийн засгийн доройтлоос болоод Монгол Улсын нэр хүнд, монгол хүний нэр хүнд унаж байна шүү дээ.

Ийм үед мөнгөний бодлогыг баталж байна л даа. Тэгээд нэг хэд хэдэн асуулт байна.

Энэ чанаргүй зээлийн хэмжээ 11 хувь болчихсон байсан. Оны төгсгөлд 14 хувь болох магадлалтай гэж. Яг өнөөдөр хэд байна? 2022 оны хүлээгдэж байгаа

гүйцэтгэл хэд болох вэ? Нэгдүгээрт энэ асуултыг би асууя гэж байгаа юм.

Дараагийн асуудал юу гэхээр энэ төлбөрийн тэнцлийн хямрал. Одоо энэ оны эцсээс эхлээд Америкийн Нэгдсэн Улсаас үүдэлтэй, тэгээд дэлхийг хамарсан хямрал үүснэ. Төлбөрийн тэнцлийн хямрал гэдэг юм үүснэ гэж үзээд байгаа юм.

Тэгээд төлбөрийн тэнцлийг хангах чиглэлд мөнгөний бодлогоор ямар ажлууд хийгдэж болох вэ гэж байгаа. Энэ нэг асуулт байгаа юм.

Энэ **LIBOR**[London Inter-Bank Offered Rate] гэдэг үзүүлэлтүүдийг хэрэглэхээ больж байгаа. Тийм ээ. Тэгээд **SOFR**[Secured Overnight Financing Rate] ГЭЭД НЭГ үзүүлэлт явж байгаад энэ LIBOR-ийн 3.5 гээд, SOFR-ийг нь болохоор 3 гээд орж ирж байгаа шүү дээ.

Тэгээд үүнийг би бодохдоо арай өндөр байгаа юм биш үү гэж. Та нар юу гэж бодож байгаа вэ? Ийм асуултуудад хариулт авъя.

Тэр гаднын банкны талаар урд талд нь би ярьсан байгаа. Тийм ээ. Нөгөө топ 100 банк байх ёстой. Гадаадад салбартай байх ёстой. Монголд ирээд тодорхой хугацаанд, жилийн хугацаатай ажиллах ёстой гээд. Тэгтэл энэ гурав ингээд саад болоод байна уу? Тэр Монголын эдийн засаг өөрөө жижиглээд хүний сонирхол татахгүй байна уу?

Би урьд нь асуулт асуугаад тодорхой хариулт аваагүй л дээ. Тэгээд энэ асуултад хариулт авъя.

Мөн 2023 онд та нарын тооцоолж байгаагаар энэ үлдэж байгаа банкнуудаас хэд нь нөгөө хуулиараа бол

IPO^[initial public offering] гаргаж дуусах ёстой байна. Манай хөрөнгийн биржийн хөрөнгөжилт их бага байгаа. Валютын нөөц багассан. Эдийн засаг хүндэрч болзошгүйтэй холбоотойгоор банкны салбарын тогтворгүй байдал үүсэж болзошгүй гэсэн нэг ийм юм харагдаж байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг ер нь юу гэж харж байна вэ? Тэр **AQR**^[Asset Quality Review]-ийн үнэлгээг олон нийтэд зарласан уу? Банк болгоноороо. Энэ яагаад ингэж байна гэхээр зэрэг хувьцаа худалдаж авахад тэр олон нийтийн итгэл үнэмшил ач холбогдолтой юм гэсэн ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: 83.
Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн асуултад хариулна.

Б.Лхагвасүрэн: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Тэгээд эхний асуулт, сүүлийн асуулт хоёрыг нь би хамтатгаад хариулчихъя гэж бодож байна.

Одоо чанаргүй зээлийн хэмжээ 10 сарын сүүлийн байдлаар 11.7 хувь. Энэ нь өөрөө 9 сарын тоотой харьцуулах юм бол 2 нэгж хувиар өсчихөөд байгаа юм. 9 сард 9.2 хувь байсан.

Энэ өсөлт болсон гол шалтгаан нь активын чанарын үнэлгээ. Активын чанарын үнэлгээ хийгдээд тодорхой хэмжээний тохируулгууд хийгдэх болсон. Активын чанараар тодорхой хэмжээний муу зээлүүд дахиж үнэлэгдэж гарч ирээд.

Энэ үнэлгээг хийгээд 08 сарын 31-ний баланс дээр нь арилжааны банкны бүх баланс дээр санхүүгийн

тохируулгыг нь хийсэн байгаа. Монголбанкны хяналт шалгалтынхаа энэ зарчмаар ажиллаад. Тэгээд энэ зээл бол чанаргүй зээл 11.7 хувь болж нэмэгдсэн.

Тэгэхээр активын чанарын үнэлгээ 8 сард хийгдэж дуусаад санхүүгийн тайланд нь, банкны санхүүгийн тайланд тохируулга хийгдсэн гэсэн үг.

Тэгэхээр үүнээс цаашаа бүр их ингэж огцом нэмэгдэх зүйл гарахгүй гэж төв банкны зүгээс харж байгаа. Яагаад гэвэл одоо энэ хагас жилээс эхлээд банк зээл гаргах үйл ажиллагаа нь нэлээн хязгаарлагдмал гэдэг юм уу, нэлээн тийм удаашралтай явж байгаа гэдэг маань өөрөө дахиж шинээр зээл гарахгүй буюу дахиж зээлийн чанарт муу зүйл гарахгүй гэдэг талаасаа ингэж Монголбанк үзэж байгаа.

Тэгээд активын чанарын үнэлгээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр Монголбанк өөрөө мэдээлчихсэн байгаа. Мөн Монголбанк дээр тодорхой хэмжээний нөгөө асуулт хариулт гээд сэтгүүлчидтэй хийх уулзалт дээрээ энэ талаар мэдээлсэн. Активын чанарын үнэлгээг системийн 5 том банканд хийсэн.

Тэгээд нэгэнт ингээд үнэлгээ хийгдээд, санхүүгийн тайланд нь тохируулга нь хийгдчихсэн учраас дахиж санхүүгийн тайлан муудахаар зүйл гарахгүй. Дээр нь ингээд түрүүчийн банк нь өөрөө хийгээд явж байгаа юм.

Тэгээд бас үүнтэй холбоотой нэг асуулт та сая хөндлөө. Олон улсын байгууллагуудын зүгээс нэгэнт ингээд дэлхий нийтийг хамарсан ийм санхүүгийн хүндрэлтэй байдал байгаа

нь өөрөө санхүүгийн салбарт муу нөлөө үзүүлнэ гэдгээрээ харж байгаа.

Гэхдээ бидний хувьд нэгэнт ингээд КОВИД-ын дараах, дараа нь энэ олон улсын хурцадмал нөхцөл байдлын үеийн бүх нөлөөг оруулчихсан банкныхаа санхүүгийн тайланд активын чанарын үнэлгээ хийчихсэн гэдэг маань өөрөө урьдчилаад бидний хувьд оношоо тогтоочихсон байна. Хаана нь ямар зүйл дээрээ банк илүү анхаарч ажиллах вэ гэдэг дээрээ бас зөвлөмж, чиглэлээ өгчихсөн байгаа учраас илүү их муудах зүйл одоогийн энэ гадаад орчин илүү үүнээс муудахгүй бол ерөнхийдөө гайгүй байх боломжтой гэж Төв банкны зүгээс үзэж байгаа юм.

Таны асуусан тэр LIBOR, тэгээд дараа нь шинээр явж байгаа хүүгийн хооронд бараг зөрүү байхгүй. Яах вэ, LIBOR бол өнөөдрийн банк хоорондын захын яг өнөөдрийн байгаа хүү. Дараагийнх нь гаргаж байгаа тэр хүү бол урагшаа 6 сар, хойшоо 6 сарын дундаж нь байгаа юм.

Тэгэхээр ингээд дунджаа аваад явж байгаа гэдэг маань өөрөө бараг ялгаа байхгүй. Тэгэхдээ урагшаагаа 6 сар авч байгаа гэдэг маань өөрөө урьд нь бага байсан байгаа бол одоо дүнгээсээ арай бага гарахаар ийм арай л хөнгөлөлттэй нөхцөл гэж хэлж болохоор ийм зүйлээр тооцоо хийгээд явж байгаа.

Банкнүүдтай холбоотой зүйл дээр мэдээж Монгол Улсад өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа 12 банк маань

бүгдээрээ дотоодын банк байгаа. Монголын банк.

Тэгэхээр мэдээж гаднын банкны салбар болон бие даасан банк орж ирж ажиллах дээр бүх талаар Төв банкны зүгээс дэмжихэд бэлэн байгаа. Яах вэ, хамгийн гол нь Монгол Улсын эдийн засаг өөрөө жижигхэн. Монголын харилцагч аж ахуйн нэгжүүд бас жижигхэн байгаа учраас зах зээл өөрөө том биш гэдгээрээ сонирхол бага байх шиг байна. Бас дээр нь гаднын банкнуудын үйл ажиллагаа явуулах тэр хөшүүргийг төрийн зүгээс бодлогоор дэмжихгүй бол бас орж ирэх магадлал нь бага байгаа. Яагаад гэвэл үүнийг юун дээр тулгуурлаж хэлж байна вэ гэхээр **Standard Chartered** гээд Английн нэлээн томоохон банк Монгол Улсад орж ирээд төлөөлөгчийн газраа нээгээд ажиллуулж байсан. Тухайн үед юу байсан бэ гэхээр Оюу Толгойн төсөл яг эхэлж явж байсан.

Тэгэхээр Оюу Толгойтой холбоотой бүх төлбөр тооцоог хийж гүйцэтгэхээр тэр банк орж ирээд байж байсан бол тэгээд Оюу Толгойн төлбөр тооцоог заавал Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байх албагүй гээд нөгөө Дубайн.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үдийн завсарлага болсон тул үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа. /алх цохив/

14.00 цагт санал хураалтаар эхэлнэ.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явна.

Хууль санаачлагч ажлын хэсэг байхгүй байгаа учраас хойшлууллаа.

хойшлуулсан учраас, хууль санаачлагч байхгүй бол хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулж болно гэж заасны дагуу хойшлууллаа.

Дараагийн асуудалд орно. Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлнэ. Энэ асуудлыг

Дараагийн асуудалд орно.

Зургаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, хаалттай/

Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ. Хаалттай горимд шилжинэ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан.

Одоо хэлэлцэх гэж байгаа асуудал нь төрийн нууцтай холбоотой учир нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийг хаалттай горимд шилжүүлбэ. Хаалттай горимд шилжүүлбэ.

Х А А Л Т Т А Й

Нээлттэй горимд шилжсэн байна. Дараагийн асуудалдаа орно.

Тав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ /үргэлжлэл/

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж байгаа. Үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо санал хураалт явуулахад бэлэн болсон байгаа.

саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. /алх цохив/ Санал хураалт явуулж байна.

25 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар санал тавьж дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

15-ны өдөр ёсчлох ажиллагаанд бэлэн байцгаагаарай. Монголбанк.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн

Долоо. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны санал,

дүгнэлтийг Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн танилцуулах ёстой. Байна. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг танилцуулна.

Ё.Баатарбилэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 5 гишүүн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.3 дахь заалтад заасны дагуу зарчмын зөрүүтэй 2 саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Мэдээж энэ асуудал амьдралаас урган гарч ирсэн. Ялангуяа орон нутгуудаар ингээд явж байхад төрийн захиргааны албан хаагчид. Тэгээд ер нь ганцхан захиргаа ч гэлтгүй дээ. Тэгээд төрийн үйлчилгээний албан хаагчид. Тэгээд ер нь л бүх хүмүүс энэ цалин хөлс амьдралд нь хүрэхээ болиод энэ асуудал нэлээн хурц болчихсон явж байгаа энэ цаг үед ингээд орж ирж байгаа.

Уг нь 2023 оны Улсын Их Хурлын төсвийг дагаж орж ирж байгаа хууль тогтоомж дотор энэ асуудал уг нь ороод, тэгээд дээрээс нь ирэх оны улсын төсөв дээр энэ шийдвэрлэж байгаа асуудал нь ороод явчихсан бол илүү л цаг хожих ийм зүйл байсан юм. Өнөөдрөөс хойш ингээд энэ хууль батлагдсаны дараа жил 3 сар орчим, жил 2 сар орчим энэ хууль ингээд батлаастай хүлээгдэх болчихож байгаа юм. Энэ хооронд хууль баталж байгаа харилцаа энэ тэр чинь бас л бодит шийдлээ, бодит нэмэгдлээ хүлээгээд л байх ийм нөхцөл байдал үүсчихэж байна л даа.

Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал уг нь бас зориг гаргаад, шийдэл гаргаад энэ асуудлаа шийдчихсэн бол их зүгээр, амьдралд нийцэх байлаа гэж.

Хоёрдугаарт, нэг тийм зарим гишүүдийн үгэнд гараад байсан. Энэ хөдөө орон нутгийнхныг. Ялангуяа аймаг ч гэсэн хөдөө орон нутагтаа орно шүү дээ. Аймгийн төвийн сумдыг адилхан сумын статустай, сумыг бас сумдаас нь хасах. Дээрээс нь Улаанбаатар хотоос тодорхой. Зарим нь бүр 130, 140 километрийн цаана байгаа ийм алслагдмал, орон зайн хувьд алслагдмал ийм дүүргүүд орохгүй байсан асуудлууд орхигдчихсон байсан.

Тэгэхээр энэ асуудлууд яг бодитойгоороо бүгд орсон уу гэдэг нэг ийм тодорхой асуулт асууя.

Хоёрдугаарт, хууль санаачлагчдаас хариулж байна уу, хэн хариулж байна. Энэ төрийн үйлчилгээнийхны асуудлыг яахаар болж байгаа вэ?

Ер нь өнгөрсөн жилээс хойш маш олон удаа энэ төрийн захиргаа, “ТҮ”-гийнхны асуудал яригдаж ирсэн. 2023

оны төсөв дээр энэ асуудлууд шийдэгдэнэ ээ л гэж хэлээд яваад байсан. Засгийн газар. Тэгээд яг одоо төсөв хэлэлцэх энэ үед нь болохоор хасаад оруулаад ирсэн. Зарим гишүүд мэдрэмжтэй энэ асуудлыг бас зэрэгцүүлээд өргөн барьсан. Тэгээд мөнгөтэй холбоотой асуудал боллоо гэж явж байгаад цаг хугацааны хувьд 2024 оноос гээд ингээд явж байх шиг байна.

Тэгэхээр энэ нэг тийм цаг хугацааны хувьд хоцорч байгаа л юм уу гэсэн ийм бодол байгаад байгаа юм.

Тэгэхээр давхар үүнтэй холбоотой бас адилхан асуудлууд зөндөө яваад байна шүү дээ. Одоо Нийгмийн даатгалын ерөнхий хууль, түүнийг дагасан 5 багц хууль хаачихсан. Засгийн газар өргөн барьчихсан байсан. Дагаад мөнгөний асуудал орж ирнэ гэхээр нь бушуухан татаад авчихсан.

Одоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шахаад энэ асуудлаа бас оруулж ирэхгүй бол ганцхан тэтгэвэр нэмэхээс бусад өөр энэ хүлээгдэж байгаа маш олон харилцаанууд байгаа шүү дээ. Тэтгэврийн тогтолцооныхоо асуудлыг яах юм. Энэ өдөр болгон сан хөмрөг нь багасаж байгаа, шавхагдаж байгаа сангуудынхаа юмыг яах юм. Ер нь энэ тогтолцоогоо авч үзэхгүй юм уу гээд ингээд маш олон асуудлууд хүлээгдээд байна.

Тэгэхээр үүнтэй адилхнаар түрүүний хоёр тодорхой асуултдаа хариулт авъя. Тэр нь бүгд орсон уу? Дээрээс нь “ТҮ” дээрээ ямар бодлого баримталж байгаа вэ гэсэн. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хороог төлөөлж ажлын хэсэг Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн хариулт өгье.

Д.Тогтохсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хороо Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн.

Анхны болон эцсийн хэлэлцүүлгийн явцад гишүүдээс гарсан саналыг тусгасан. Энэ хүрээндээ нэгдүгээрт бүх сум ялгаваргүй орж байгаа гэж ойлгож болно. Энэ өмнөх анхны хэлэлцүүлэг дээр шийдэгдсэн. Суманд ялгаваргүй.

Хоёрдугаарт нь, өргөн баригдсан хуулиар зөвхөн Тамгын газрын ажилтан байсан. Энэ нь больсон. Суманд ажиллаж байгаа төрийн захиргааны жинхэнэ албан хаагч л бол энэ хөнгөлөлтөд хамрагдана.

Тийм учраас одоо босоо тогтолцоотой гэж нэрлэдэг. Татвар ч юм уу, даатгал ч юм уу, халамж ч юм уу, улсын бүртгэл ч юм уу, байгаль орчинд ч юм уу, газар эдэлбэр ч юм уу бүгд энд багтаж орж байгаа гэж ойлгож болно.

Гурав дахь нь, хэлэлцүүлгийн явцад нийслэлийн алслагдсан дүүргүүд орох ёстой гэж гишүүд санал гаргасан. Энэ дагуу Багахангай, Багануур дүүрэг орсон. Өмнөх анхны хэлэлцүүлгээр. Өнөөдрийн эцсийн хэлэлцүүлэг дээр Налайх дүүргийн асуудал зарчмын зөрүүтэй саналаар явж байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ц.Туваан: Дэгээрээ Байнгын хорооны дарга хариулах ёстой юм байна. Тэгээд дарга байхгүй байгаа юм байна. Тийм. Хариулж байна.

Тэр дээр бас тодорхой нэг нэмэлт юм нь одоо хэдүүлээ бас тэр орон нутаг дээр Тамгын газраасаа л цалин авч байгаа шүү дээ. ТҮ-гийнхэн. Тийм ээ.

Багш, цэцэрлэгийнхэн бол Боловсролын яамнаасаа. Эрүүл мэндийн яамныхан бол бүгдээрээ тэр чигээрээ Эрүүл мэндийн яамнаасаа. Одоо энэ орон нутгийн ТЗ-гийнхан маань бас ингээд алагчлалгүй аймаг, сум бүгдээрээ ороод. Тэгээд дээрээс нь алслагдсан дүүргийнхээ авч байгаа. ТҮ-гийнхэн яах юм бэ гээд бүр тодорхой энэ дээр. Энэ асуудал яг яаж яригдсан бэ? Орсон уу, ороогүй юу гэдэг асуулт.

Г.Занданшатар: Орсон уу, ороогүй юу гэнэ ээ. Сайн уншаагүй юм шиг байна. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн Байнгын хороог төлөөлж хариулж өгье.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр энэ хуулийн төслийн ерөөсөө үзэл баримтлал нь суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдэх нэг хэлбэр нь байгаа юм.

Тийм учраас төрийн үйлчилгээний албатай холбоотой асуудал энэ хуулийн хүрээнд ороогүй. Багш, эмч, соёлын ажилтнууд өөрийнхөө хуулиар явж байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд нарын урилгаар Төв аймгийн Заамар сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллол. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг “51.3.Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх.

Найм.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

53.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Аймаг байхгүй болоод дүүрэг орчихсон л юм байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “2023” гэснийг “2024” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

58.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан.

Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хангах үүрэг бүхий үүргийг Монголын төр хариуцна гэж заасан байдаг.

Энэ үүргийн дагуу Үндэсний үндэсний батлан хамгаалах болон нийгмийн дэг журмыг хэвийн хэмжээнд байлгах, мөн түүнчлэн хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай чиг үүрэг бүхий 13 байгууллага байдгийн нэг нь төрийн захиргааны албан хаагч ажилладаг. Энэ бол Гадаадын иргэн, харьяатын байгууллагын газрын албан хаагч нар байгаа.

Тийм учраас энэ үндэсний аюулгүй байдлын чиг үүргийг хангах зорилго бүхий энэ байгууллагыг төрийн тусгай болгох энэ заалтыг хуульд оруулах.

Мөн хоёрдугаарт нь Хувь хүний аюулгүй байдлыг хамгаалах хууль, 05 сарын 01-нээс хэрэгжсэнтэй холбоотойгоор гадаадын иргэдийн оршин суух зөвшөөрлийг хэвлэх асуудал хувь хүний нууцад хамрагдах болсон. Ийм учраас энэ хэвлэх үйл ажиллагааг хувийн хэвшил биш төрийн байгууллага хэвлэх үүргийг тусгаж өгсөн байгаа.

Гуравдугаарт нь, Гадаад иргэний харьяатын байгууллагын тодорхой үйл ажиллагаанаас орж байгаа орлогыг энэ байгууллагын цахим хөгжилд зарцуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон нутагт орж байгаа орлогын 20 хувийг Гадаад иргэн, харьяатын байгууллагад зарцуулах.

Мөн дөрөвдүгээрт нь, өнөөдрийн байдлаар хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын нэг жил

ажилласныг 1.3 жилээр тооцож байгаа. Үүнийг бүх албан хаагчдад тусгай чиг үүргийн байгууллага болж байгаа учраас 1.3 жилээр тооцох энэ заалтуудыг хуулийн төсөлд тусгасан байгаа.

Энэ хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд дэмжиж шийдвэрлэсэн. Ийм учраас Их Хурлын гишүүд Та бүхэн энэ хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа. Та бүхэнд.

Г.Занданшатар: Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдийн Адьшаа танилцуулна. Индэрт урьж байна.

Ш.Адьяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг төрийн тусгай албан тушаалд хамааруулах, 5 шатлал бүхий цолтой байх, гадаадын иргэний оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээг байгууллагын дотоод нөөц бололцоонд тулгуурлан хэвлэх зохицуулалтыг тусгах, Улсын тэмдэгтийн хураамжийн

тухай хуульд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг тус байгууллагын дараа жилийн төсөвт тусгах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдыг төрийн тусгай албан тушаалд хамааруулах зохицуулалттай уялдуулж Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн гадаадын иргэн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүрэг бүхий Гадаадын иргэн, харьяатын газар нь үйлчилгээний байгууллага болохыг онцолж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн үүрэгтэй байгууллагын хувьд Гадаадын иргэн, харьяатын албан хаагчдыг төрийн тусгай чиг үүрэгт хамааруулах, сахилга, хариуцлага, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, төрийн тусгай албан хаагчийн нийгмийн хэв журам хамгаалах, үндэсний болон үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй учраас гадаадын харьяа харьяатын асуудал хариуцсан байгууллагыг төрийн тусгай алба болгосноор энэ зорилгыг хангахад ахиц гарах нөхцөлтэй байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлаас аялал жуулчлалыг дэмжих зорилгоор хил орчим жуулчид өдрийн виз олгох зохицуулалтыг, Улсын Их Хурлын

гишүүн Л.Мөнхбаатар Гадаадын иргэн, харьяатын газрын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий 11 байгууллагын нэг болох тухай тус тус хэлэлцсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Үг хэлэх гэж хүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. /алх цохив/

53.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул

төслүүдийг үзэл баримтлын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ хамгийн олон хууль хэлэлцүүлж, дэмжүүлж байгаа хүн

Б.Пүрэвдорж гишүүн болж байна шүү, ер нь. Нэн ялангуяа Ардчилсан намын бүлгээс хамгийн олон хууль хэлэлцүүлж байгаа.

Дараагийн асуудалд орёё.

Ес.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Хууль зүйн байнгын хорооны дарга Лхагваагийн Мөнхбаатар үг хэлнэ. Байнгын хорооны үг гэж ойлголоо.

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүдийн амрыг эрбэ.

Энэ асуудал дээр бас горимын саналтай байгаа юм. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар уг төслийг хэлэлцэх эсэхийг нь шийдээд Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн байгаа юм.

Тэгээд Хууль зүйн байнгын хорооноос Ж.Сүхбаатар гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа. Ингээд ажлын хэсэг нь 8 зарчимын зөрүүтэй санал, 4 найруулгын саналыг бэлтгэсэн.

Ингээд 2021 оны 06 сарын 29-ний өдрийн хуралдаанаараа төслийн анхны хэлэлцүүлгийг явуулчихсан юм. Гэхдээ үүнээс хойш бас нөхцөл байдлууд нэлээн өөрчлөгдөөд байгаа.

Тодруулж хэлэх юм бол Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн төсөлтэй хамт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг дагуулаад өргөн барьчихсан байгаа юм.

Түүнээс гадна энэ Мэдээллийн ил тод байдлын тухай болон Мэдээлэл авах эрхийн тухай хуульд бас өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг хамт өргөн мэдүүлсэн.

Гэтэл энэ хуулийн төсөл нь Мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь батлагдаад гарчихсан. Энэ хугацаанд. Мөн Засгийн газар болохоороо энэ хуулийн төслөө харин хүчингүй болгох биш, шинэчлэн найруулахаар одоо ингээд ажиллаж байгаа юм билээ.

Ийм учраас ийм тодорхой нөхцөл, шинэ нөхцөл байдлууд үүссэн

учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана гэсэн ийм заалт байгаа.

Үүнийг баримтлаад хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт Хууль зүйн байнгын хороогоор дахин явуулах горимын саналыг гаргаж байна.

Энэ саналыг хураалгаж өгөхийг Их Хурлын даргаас хүсье.

Г.Занданшатар: Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Хууль зүйн байнгын хорооноос Хууль зүйн байнгын хорооны дарга Лхагваагийн Мөнхбаатарын гаргасан саналаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.8-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаас олонхын саналаар анхны хэлэлцүүлэгт

буцаах горимын саналаар санал хураалт явуулна.

41.8-д анхны хэлэлцүүлэгт олонхоос буцааж болно гэсэн заалттай.

Санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/ Анхны хэлэлцүүлэгт буцаая. Гүйцээн боловсруулъя.

27 гишүүн дэмжиж, 58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Лхагваагийн Мөнхбаатар гишүүний гарсан горимын саналын дагуу энэ хуулийг анхны хэлэлцүүлэгт буцаалаа.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаалаа.

Байнгын хороо анхны хэлэлцүүлгийг дахин явуулж оруулж ирнэ.

Дараагийн асуудалд орно.

Арав. “Жижиг, дунд үйлдвэрийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудал Жижиг, дунд үйлдвэрийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшингээс Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах хүсэлтээ Байнгын хороонд ирүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26.3. 26.5 дахь хэсэгт заасны дагуу “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Үйлдвэрчдийн бодлогын

байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудлын сүүлийн буюу арав дахь асуудал. Сүүлийн асуудал шүү. Одоо энэ асуудлаа хэлэлцээд тэгээд.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд суудалдаа суугаарай. Энэ Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хаачив. Хуулиа батлуулчихаад гараад явчих юм. Одоо ингээд. Санал хураалт явуулъя. Ц.Туваан гишүүн суу. Сахилгагүй хүүхэд шиг. Санал хураалт. /алх цохив/

27 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулна. Тогтоолыг уншиж танилцуулахын өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. /алх ташив/

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3. 26.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг баталсанд тооцлоо. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал. Хянан шалгах түр хороо байхгүй. Хянан шалгах түр хорооны асуудал байна шүү дээ. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээгүй тул нэгдсэн хуралдааны

хэлэлцэх асуудлаас хаслаа. /алх цохив/
Хянан шалгалтын хорооны асуудлыг.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх 10 асуудлыг амжилттай хэлэлцлээ. 10 асуудлыг хэлэлцэж дууссан байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 10 асуудлыг бүгдийг нь хэлэлцэж дууссан учир чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Өнөөдөр эрт тарлаа шүү.

Бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД